

Нийслэлийн Засаг даргын А/1106 дугаар
захирамжийн 2 дугаар хавсралт



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН 2023 ОНЫ ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

**УЛААНБААТАР ХОТ
2023 ОН**

ТАЙЛАНГИЙН БҮТЭЦ, АГУУЛГА**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН**

1.1. Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрт БЗДЭМТ хариуцан хэрэгжүүлэхээр тусгасан заалтуудын хэрэгжилт

1.2. “Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”, “Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд БЗДЭМТ хариуцан хэрэгжүүлэхээр тусгасан арга хэмжээний хэрэгжилтийг хангахад чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөж зохион байгуулсан байдал

1.3. Улс, Нийслэл, Дүүргийн төсөв, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, зээл тусламж болон өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын төлөвлөлтийн оновчтой байдал, гүйцэтгэл, чанар, үр дүн

1.4. “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангахад чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөж, зохион байгуулсан байдал

1.5. Нийслэлийн Засаг даргын захирамж, албан даалгаврын хэрэгжилт

1.6. Нийслэлийн Засаг даргаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт

1.7. Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх чиглэлээр хийсэн ажил, үр дүн

1.8. Тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр хийсэн ажил, үр дүн

ХОЁРДУГААР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

2.1. Байгууллагын “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-ний хэрэгжилт, үр дүн

2.2. Нийслэлийн Засаг дарга болон дүүргийн Засаг даргын хооронд байгуулсан “Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх гэрээ”-ний хэрэгжилт, үр дүн

2.3. Төвсийн орлогын төлөвлөгөө болон нийслэлийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөний биелэлт, нийслэлийн төсвөөс дүүргийн төсөвт олгож буй санхүүгийн дэмжлэгийн харьцуулалт

2.4. Хяналт шалгалтын байгууллагаас ирүүлсэн, санал зөвлөмж, түүнийг хэрэгжүүлсэн байдал

2.5. Төрийн захиргааны албан хаагчдын ажлын гүйцэтгэл, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэсэн байдал

2.6. Үндсэн чиг үүргийн биелэлт, үр дүнд дотоод аудит, хяналт эсвэл хяналт, шинжилгээ, үнэлгээ хийсэн эсэх, уг ажлын дүгнэлтийг үйл ажиллагаандаа авч хэрэгжүүлсэн байдал

2.7. Архив, албан хэрэг хөтлөлт, хариутай албан бичгийн шийдвэрлэлтийн байдал

2.8. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал

2.9. Байгууллагын үйл ажиллагаанд дотоод удирдлагын программ нэвтрүүлсэн байдал, үр дүн

2.10. Байгууллагын үйл ажиллагааны зардал хямдруулах, төсөв хэмнэх чиглэлээр зохион байгуулж, үр дүнд хүрсэн бодитой ажил

ГУРАВДУГААР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

3.1. Мэдээллийн ил тод байдлыг хангах чиглэлээр хийж хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн

3.2. Хүний нөөцийн ил тод байдлыг хангах чиглэлээр хийж хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн

3.3. Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангасан байдал буюу шилэн дансны хөтлөлтийн байдал, үр дүн

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

МУЗГ	Монгол улсын Засгын газар
НЗДТГ	Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар
НИТХ	Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал
БЗДНЭ	Баянзүрх дүүргийн нэгдсэн эмнэлэг
БЗДЭМТ	Баянзүрх дүүргийн эрүүл мэндийн төв
НҮБ	Нэгдсэн үндэсний байгууллага
НҮБХАС	Нэгдсэн үндэсний байгууллагын хүүхдийн сан
НААГ	Нийслэлийн амгалан амаржих газар
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
ЭХЭМҮТ	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв
НҮЭМ	Нөхөн үржихүйн эрүүл мэнд
АШҮҮИС	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль
НЭМҮТ	Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв
ЖСА	Жирэмснээс сэргийлэх арга
ЭМСДИ	Эрүүл мэндийн сайн дурын идэвхитэн
ЭМНА	Эрүүл мэндийн нийгмийн ажилтан
УНТЭ	Улсын нэгдүгээр төв эмнэлэг
ХСҮТ	Хавдар судлалын үндэсний төв
ХӨСҮТ	Халдварт өвчин судлалын үндэсний төв
УГТЭ	Улсын гуравдугаар төв эмнэлэг
ХХНЖ	Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт
ОУБ	Олон улсын байгууллага
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ҮЭХ	Үйлдвэрчний эвлэлийн хороо
ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
ИДС	Их дээд сургууль

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ**БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН****1.1. Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрт Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төв хариуцан хэрэгжүүлэхээр тусгасан заалтуудын хэрэгжилт**

Монгол улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/605 дугаар тушаалаар баталсан “Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Нийслэлийн эрүүл мэндийн газрын даргын 2022 оны А/215 дугаар тушаалаар “Харъяа Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д тусгагдсан Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, байгууллагын үйл ажиллагааны тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх төлөвлөгөөний дагуу ЭМТ хариуцан хэрэгжүүлэхээр тусгасан нийт 80 хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийг хэрэгжилтэнд жилд 2 удаа хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ажилласан.

Дээрх хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэсгийн үнэлгээ:

Хэрэгжилтийн ангилал		НИЙТ	Монгол улсын хууль	УИХ-ын тогтоол	Ерөнхийлөгчийн зарлиг	Засгийн газрын тогтоол	Нийслэлийн Засаг даргын захирамж	Эрүүл мэндийн сайдын тушаал	НЭМГ-ын даргын тушаал
Хяналтад авсан нийт шийдвэрийн тоо		80	16	1	1	9	6	42	5
Бүрэн хэрэгжсэн	100%	70	16	1	1	9	9	42	5
Хэрэгжих шатанд	70%	10							
Хэрэгжилт хангалтгүй	30%								
Хэрэгжээгүй	0%								
Биелэлтийн дундаж		99	20	1.2	1.2	11.2	11.2	52.5	6.2

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2023 оны 11 сарын байдлаар хэрэгжилт 95 хувьтай буюу БҮРЭН ХЭРЭГЖСЭН үнэлгээтэй ажилласан.

1.2. “Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”, “Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төв хариуцан хэрэгжүүлэхээр тусгасан арга хэмжээний хэрэгжилтийг хангахад чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөж зохион байгуулсан байдал

Зорилт 1. Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлж, бэлэн байдлыг хангахтай холбоотой төсвийн санхүүжилтийг нэмэгдүүлнэ.

Эрүүл мэндийн сайдын 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/358 дугаар тушаал, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн А/149 дугаар тушаал, Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвийн даргын 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн А/110 тоот тушаалыг тус тус үндэслэн Баянзүрх дүүргийн харьяа өрх, тосгоны эрүүл мэндийн төвүүдийн байнгын болон цэцэрлэг дээр байгуулагдсан түр цэгүүдэд түшиглэн томуугийн дархлаажуулалтыг зохион байгуулан ажиллаж байна. Зорилтот бүлгийн хүн ам буюу 2-5 насны нийт 28640 хүүхэд хамрагдахаас нийт 117 цэцэрлэг дээр байгуулагдсан түр цэгүүдэд 14025 хүүхдийг хамруулж 2023 оны 11 сарын 17-ны өдрийн байдлаар хамралт 48.9%-тай байна. Учир нь Эрүүл мэндийн сайд, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын тушаал, Халдварт өвчин судлалын үндэсний төвөөс өгсөн чиглэлийн дагуу зорилтот насны бүлэгт 2-5 насны хүүхдүүдийг эхэнд хамруулсан. 11 сарын 1-ний өдрөөс эхлэн эцэг эхийн зөвшөөрлийн үндсэн дээр томуугийн дархлаажуулалтад хамрагдах хүсэлтэй сургуулийн насны буюу 6-15 насны 1571 хүүхдийг нэмж хамруулсан.

Зорилт 2. Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, иргэн бүр урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд тогтмол хамрагдах нөхцөлийг олон улсын жишигт нийцүүлэн сайжруулж, эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ

- “ЭРҮҮЛ ИДЭВХТЭЙ АМЬДРАЛ” арга хэмжээ нийт 5 зорилт 77 арга хэмжээ хэрэгжүүлэхээс БЗДЭМТ-ийн хэмжээнд 3 зорилт 21 арга хэмжээ хэрэгжүүлэхээр тусгагдсанаас 2023 оны 11-р сарын байдлаар төлөвлөсөн 21 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, хэрэгжилт 98 хувьтай ажилласан байна.

Эрүүл зөв хооллолтын чиглэлээр ганцаарчилсан болон сургалт хэлбэрээр 12073, идэвхитэй хөдөлгөөний чиглэлээр 21189, сэтгэцийн эрүүл мэндийн чиглэлээр 9802, архи, тамхи, хорт зуршилд донтох эмгэгийн чиглэлээр 922 иргэн тус тус хамрагдаж нийт 34184 иргэн сургалтанд хамрагдсан байна.



“Энэ жилдээ-Эрүүл жиндээ” аяны хүрээнд БЗД-ийг үндэсний хэмжээнд ТҮМЭН дасгалыг сурталчлагч загвар дүүрэг болгох зорилгоор идэвхтэй хөдөлгөөн, чийрэгжүүлэлтийн ТҮМЭН дасгалын сургагч багш бэлтгэх, мэргэжил аргазүйн сургалтыг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, БЗД-ийн Биеийн тамир спорт хороотой хамтран амжилттай зохион байгуулж, үндэсний хэмжээнд ТҮМЭН дасгалыг сурталчлагч загвар дүүрэг болон өргөмжлөгдсөн. Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, биеийн тамир, спортын үйл ажиллагааг идэвхжүүлэх, идэвх сонирхлыг дэмжих,

хөдөлгөөний хомсдолоос сэргийлэх, эрүүл мэндийг бэхжүүлэх зорилгоор ЭМТ-ийн даргын 2023 оны А/89 дугаар тушаалын хүрээнд, Биеийн тамир спортын хороо, ЭМТ-ийн ҮЭ-ийн салбар хороотой хамтран зохион байгуулсан эрүүл мэндийн төвийн ажилтан, албан хаагчдын дундах явган аялал, спортын арга хэмжээ явагдаж алба хаагчид идэвхтэй оролцож, өргөмжлөл, мөнгөн шагналаар урамшуулсан.



Дүүргийн харъяа ААНБ, ИДС, ЕБС, СӨБ, БЗДЗДТГ НДХ, ЭМТ болон амбулаторид хяналтанд байдаг жирэмсэн ээж болон аавууд, хорооны хэсгийн ахлагч, иргэд олон нийтэд “Сэтгэцийн эрүүл мэнд”, “Сэтгэл зүйн боловсрол”, “Сэтгэл зүйдээ анхаарал хадуулах нь эмгэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтуудыг зохион байгуулан сургалтаар мэдээлэл зөвлөгөө өгч мөн оролцоонд тулгуурлан асуулт хариулт, чөлөөт ярилцлага, хамт олны харилцааг сайжруулах, өөрийн мэдрэмжийг гадагшлуулж суралцах сэтгэл зүйн дасгал ажил явуулан, сэтгэл зүйн боловсролын тараах материал өгөн сургалт, сурталчилгааг зохион байгуулсан. Нийт 156 удаагийн сургалтаар 2352 сурагч, оюутан, багш, алба хаагч, иргэд, олон нийт хамрагдсан. 28 өрх, тосгоны эрүүл мэндийн төвийн 160 эмч, мэргэжилтэн, нийгмийн ажилтан нарт “Сэтгэл зүйн анхан шатны тусламж ба сэтгэл зүйн боловсрол”, “Стресс менежмент” сэдвээр сургалт зохион байгуулж, “Гамшгийн үеийн сэтгэл зүйн дэмжлэг” чиглэлээр 3 удаагийн сургалт, уулзалтыг 15 айл өрх, 3 ӨЭМТ дээр зохион байгуулсан.

Олон нийтийн нийгмийн сүлжээ болох UBS, C1, NTV, Eagle телевиз, мэдээний 2 сайтад “Сэтгэцийн эрүүл мэнд”, “Өсвөр насны сэтгэл гутрал, түгшилт”, “Нойргүйдэл”, “Стресс тайлах арга зам”, “Дэлгэцийн хамаарал” сэдвүүдээр нийт 11 удаагийн иргэд, олон нийтэд ярилцлага, зөвлөмж, мэдээлэл хүргэсэн.

Мөн Авто машингүй өдөр /Бөхийн өргөө/ болон Баянзүрх зах, Тэнгэр худалдааны төв, Дүнжингарав төв, Нарантуул ОУХТөвийн гадаа талбайд /Намайг алгас/, үндэсний цэцэрлэгт хүрээлэн, БЗДЭМТ Салбар амбулатори 1, Сүхбаатрын талбайн өдөрлөгөөр иргэд, олон нийтэд зориулан сэтгэцийн эрүүл мэндийн болон архи согтууруулах ундаа хорт зуршлаас татгалзах талаар тараах материал тарааж, нийт 7 удаагийн гадаа талбайн өдөрлөгт 2000 гаруй иргэдэд мэдээлэл, сурталчилгааны нөлөөллийн ажил зохион байгуулсан.

Олон улсын эрдэм шинжилгээний хуралд Монгол улсын 21 аймаг, Улаанбаатар хотын 9 дүүрэг, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Эрүүл мэндийн яам, сэтгэцийн эрүүл мэндийн салбарт хийгдсэн 61 эрдэм шинжилгээний

судалгааны бүтээлүүд хэлэлцэгдэж Сэтгэц наркологийн багийн “Баянзүрх дүүргийн ӨЭМТ-д ажиллаж буй эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн сэтгэцийн эрүүл мэндийн байдлыг үнэлсэн нь” судалгаа 3-р байранд шалгарсан.

Мансууруулах бодистой холбоотой болон Архидан согтуурахтай тэмцэх, архины хор хөнөөл, хүний эрүүл мэнд, гэр бүл, хамт олон, нийгэмд учрах хор уршиг, түүнээс урьдчилан сэргийлэх болон архины хэрэглээг багасгах, архинд донтох эмгэг, архинаас хэрхэн татгалзах талаар 65 арга хэмжээ зохион байгуулж, сургалтанд 634 иргэн хамруулж, 2 өдөрлөгт 308 иргэнд мэдээлэл зөвлөгөө хүргэж ажилласан.



Эрүүл зөв зохистой хооллолтын талаар ӨЭМТ-ийн эмч, сувилагч, эмнэлгийн ажилтан албан хаагчдад нийт 15 удаагийн сургалтаар 253 хүнд, БЗД-ийн 12, 30, 23, 9, 18, 13, 14-р хорооны 103 иргэнд, ЭМТ-ийн жирэмсэний хяналтанд байгаа эхчүүдэд нийт 29 удаагийн 880 ээжид, БЗД-ийн харъяа ЕБС-ийн үдийн цайны ач холбогдол, хүүхэд ахуй наснаас нь амьдралын зөв хэв маягийг төлөвшүүлэх сургалтыг 33, 79, 87, 14-р сургуулиудын 1-5 дугаар ангийн хүүхдүүдэд нийт 12 удаагийн сургалтаар 420 хүүхэд хамруулж, БЗД-ийн харъяа 14 цэцэрлэгийн насны бэлтгэл, ахлах, дунд, бага бүлгийн хүүхдүүдэд 2-5 хүртэлх насны хүүхдийн хооллолт, зөв зохистой хооллолтын талаар цэцэрлэгийн бүлгийн багш, туслах багш, тогооч, ажилчид, эцэг эх асран хамгаалагч нарт нийт 25 удаагийн сургалтаар 1059 хүнийг сургалтанд хамруулж, 8308 иргэнд ганцаарчилсан зөвлөгөөг өгсөн.



• “ХАЛДВАРТ ӨВЧИНТЭЙ ТЭМЦЭХ, СЭРГИЙЛЭХ” арга хэмжээний нийт 8 зорилт 177 арга хэмжээ хэрэгжүүлэхээс эрүүл мэндийн төв нь тус арга хэмжээнд 8

зорилт 53 арга хэмжээ хэрэгжүүлэхээр тусгагдсанаас 2023 оны 10 дугаар сарын байдлаар 50 арга хэмжээг хэрэгжүүлж, хэрэгжилт 94,3 хувьтай ажилласан байна. Хугацаа болоогүй 1 арга хэмжээ, хэрэгжээгүй 2 арга хэмжээ байна.

“Өндөр хоруу чанартай шувууны томуугийн вирусээр үүсгэгдсэн хүний томуугийн өвчний үеийн тархалтын хариу арга хэмжээ”-г БЗД 9, 16, 17, 19, 24-р хорооны өрхийн эрүүл мэндийн төвүүд хамтран 2023 оны 04 сарын 06-ны өдөр зохион байгуулж, тусгаарлах өрөө, хамгаалах хувцас хэрэгслийн бэлэн байдал, хариу арга хэмжээ авах журам, төлөвлөгөө, холбогдох материалыг танилцуулах сургалтыг өрхийн эрүүл мэндийн төвөөс тус бүрээс 1 эмч, дарга нар нийт 36 хүнийг хамруулсан. “Ковид-19 халдварын үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээ” сэдэвт үзүүлэх сургалтыг 2022 оны 04 сарын 12-ны өдөр эрүүл мэндийн төв, 1, 3, 4, 5, 7, 13, 14-р хорооны нийт 33 хүнийг хамруулан өрхийн эрүүл мэндийн төвүүд хамтран 2 тохиолдлын кейс гарган түүн дээрээ ажиллаж зохион байгуулсан. Газар хөдлөлтийн үеийн бэлэн байдлыг хангах команд штабын дадлага, сургууль, бэлэн байдлын хангах үзүүлэх сургуулилыг яаралтай тусламжийн бэлэн байдал, эрэмбэлэн ялгалт, нуранганд дарагдаж гар, хөлөө хугалсан ард иргэдэд үзүүлэх тусламж үйлчилгээ, аранзын бэлэн байдал, цугларах цэгийн мэдээ мэдээлэл зэргээр 6, 15, 18, 25, 26-р хорооны ӨЭМТ-үүдтэй хамтран 2023 оны 04 дүгээр сарын 07-нд зохион байгуулсан. Боом болон галзуу өвчний үеийн бэлэн байдал хариу арга хэмжээ сэдэвт үзүүлэх сургалтыг 2023 оны 04 сарын 11-ны өдөр 8, 10, 12, 23, 28-р хорооны өрхийн эрүүл мэндийн төв, Хонхор болон Гачуурт тосгоны эрүүл мэндийн төвүүд хамтран боом болон галзуу өвчний талаарх ерөнхий мэдээлэл, Боом өвчний сэжигтэй тохиолдолд үзүүлэх тусламж үйлчилгээ, Лабораторын сорьц авах, тээвэрлэх, Голомтын арга хэмжээ, Тайван үед авч хэрэгжүүлэх арга гэсэн 5 өртөөгөөр кейс тохиолдол дээр суурилан дүрд тоглон 60 эмч, эмнэлгийн ажилтан хорооны засаг дарга нарыг хамруулсан. Тарваган тахал өвчний үеийн бэлэн байдал хариу арга хэмжээ сэдэвт үзүүлэх сургалтыг 2, 21, 22, 27 дугаар хорооны өрхийн эрүүл мэндийн төвүүд 2023 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр “Тарваган тахал өвчний сэжигтэй тохиолдол илэрсэн үед авах арга хэмжээ” видео баримтат кино хэлбэрээр тус бүр зохион байгуулж, хорооны засаг дарга нар болон бусад ажилчид, дүүргийн эрүүл мэндийн төвийн эмч мэргэжилтэн, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч ажилчид зэрэг нийт 31 хүн хамрагдсан.



Баянзүрх дүүргийн хэмжээнд эхний 10 сарын байдлаар товллын дархлаажуулалтын хамралт 96.1% байна. Баянзүрх дүүргийн хэмжээнд дархлаажуулалтын байнгын болон сургууль, цэцэрлэг дээрхи түр цэгүүдэд түшиглэн улаанбурхан, улаанууд өвчний эсрэг нэмэлт дархлаажуулалт зохион байгуулж, 10 сараас 8 хүртэлх насны нийт 21811 хүүхдийг хамруулж хамралт 31.8% байна. Дархлаажуулалтын 10 хоногийн хүрээнд зорилтот бүлгийн нийт 26058 иргэнийг хамруулж, хамралт 76,8% байна.



Эрсдэлт бүлгийн иргэдийн дунд сүрьеэ илрүүлэх үзлэгийг амжилттай зохион байгуулан ажилласан. 2023 оны эхний 11 сарын байдлаар 7177 иргэнийг үзлэгт хамруулан 54 тохиолдлыг илрүүлэн эмчилгээнд хамруулсан. Солонгосын Үндэсний Сүрьеэгийн Нийгэмлэгээс 2023 оны 6 сард тус эрүүл мэндийн төвийн сүрьеэгийн диспансерт сүрьеэгийн далд халдвар илрүүлэх ICHROMA аппаратыг дагалдах хэрэгсэл оношлуурын хамт хүлээж авсан. Тус аппаратанд ажиллах хүний нөөцөөр сүрьеэгийн диспансерийн 4 сувилагч, 2 лаборант бэлтгэгдсэн. Тус аппаратаар 470 иргэний цусанд шинжилгээ хийснээс 90 иргэнд сүрьеэгийн далд халдварыг илрүүлэн ажилласан.



Бэлгийн замаар дамжих халдварын кабинетаар хийгдсэн үзлэгийн тоо эхний 11 сарын байдлаар 16712 үүнээс 7559 буюу 45,2%-ийг урьдчилан сэргийлэх үзлэг, 9,6%-ийг идэвхтэй хяналт, 45,2%-ийг амбулаторийн үзлэг эзэлж байна. Шинээр бүртгэгдсэн өвчлөл-657, хуучин өвчлөл-1063. Тэмбүү-317, заг хүйтэн-95, трихомониаз -168, бусад халдвар-77 илрүүлж эмчилгээ хяналтанд авсан байна. Үүнээс жирэмсэн эмэгтэйчүүдийн эзлэх хувь 39.7 %, өсвөр насныханы эзлэх хувь 15.8 % байна. Эмийн эмчилгээнд хамруулсан-1058. 2023 онд оношилгоо шинжилгээний нэр төрлийг нэмэгдүүлж 2023 оны 02-р сарын 06-ны өдрөөс эхлэн үндсэн 7 төрлийн үүсгэгч илрүүлэх PCR шинжилгээг хийж, 926 иргэнийг хамруулсан. Идэвхтэй эрт илрүүлгийн үзлэгийг 28 удаа зохион байгуулж, 2974 оюутан, ажилтан алба хаагчдыг хамруулж, 74 эерэгээс 17 шинэ тохиолдол илрүүлж эмчилсэн.



• “ЭХ, ХҮҮХЭД, НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНД” арга хэмжээ нийт 5 зорилт 72 арга хэмжээ хэрэгжүүлэхээс БЗДЭМТ-ийн хэмжээнд 4 зорилт 10 арга хэмжээ хэрэгжүүлэхээр тусгагдсанаас 2023 оны 10 дугаар сарын байдлаар 10 арга хэмжээг хэрэгжүүлж, хэрэгжилт 95 хувьтай ажилласан байна. 2023 оны эхний 10 сарын байдлаар:

- 0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 72 тохиолдол 1000 амьд төрөлтөд 12 промилль, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.2 промолиор өссөн. Улаанбаатарын дунджаас 1,3 промолиор өссөн.

- 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 5 тохиолдол буюу 0.8 промилль, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.8 промолиор буурсан. Улаанбаатарын дунджаас 0.7 промолиор буурсан.

- Эхийн эндэгдэл -3 тохиолдол /100,000 амьд төрөлтөд/-49.3

- Амьгүй төрөлт-35 тохиолдол /1000 амьд төрөлтөд/- 5.7 промилль өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.1 промилль буурсан Улаанбаатарын дунджаас 0.9 промилль өссөн үзүүлэлттэй.

- Хяналтгүй төрөлт-38 тохиолдол /1000 амьд төрөлтөд/ -0.6 промилль өмнөх оны мөн үетэй адил байна. Улаанбаатарын дунджаас 0.1 промилль өссөн үзүүлэлттэй.

- Гэрийн төрөлт -16 тохиолдол /1000 амьд төрөлтөд/- 0.3 промилль өмнөх оны мөн үетэй харьцуулахад ижил, Улаанбаатарын дунджаас 0.1 промилль өссөн үзүүлэлттэй.

Дүүргийн хэмжээнд нийт 49857 жирэмсэн хянагдаж байгаа бөгөөд 5121 нь Өрхийн эрүүл мэндийн хяналтад байна. Шинээр 3080 жирэмсэн хяналтад орсон. Эрт үеийн жирэмсний хяналтад 2736 эмэгтэй (90.5%), хожуу үеийн жирэмсний хяналтад 344 эмэгтэй (9,5%) орсон байна. Эх, нярайд үзүүлэх тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор нийт 36 өрхийн эрүүл мэндийн жирэмсний хяналтын үзлэг, 2 тосгоны эмнэлгийн жирэмсний хяналтын үзлэг, тусламж үйлчилгээг амбулаториор болон Дарь-эх нэгдсэн эмнэлгээр үзүүлж байна.

Баянзүрх дүүргийн харьяа өрхийн эрүүл мэндийн төвүүдийн илүү өртөмхий болон эрсдэлт бүлгийн нийт 8.884 эмэгтэйчүүд байгаагаас хөгжлийн бэрхшээлтэй, хөдөлмөрийн чадвар алдалт тогтоолгосон 1457 эмэгтэйгээс 610 эмэгтэй, сэтгэцийн эмгэгийн улмаас хөдөлмөрийн чадвар алдалт тогтоолгосон нөхөн үржихүйн насны 407 эмэгтэйгээс 168 эмэгтэй, өвөр үеийн 51 охин, бусад нь нийгэм биологийн хүчин

зүйлээс шалтгаалан нийт зорилтот бүлгийн эмэгтэйчүүдийн 4823/54.2%-ийг жирэмснээс сэргийлэх арга хэрэгсэлд хамруулсан.

Харьяа өрхийн эрүүл мэндийн төвүүдийн цахим хаягаар нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүд болон жирэмсэн эхчүүдэд эрүүл мэндийн боловсролыг "жирэмслэхээс сэргийлэх арга хэрэгсэл", "Жирэмсэн үеийн сэтгэл зүй", "Жирэмсний хяналтын ач холбогдол", "Гэр бүл төлөвлөлт" чиглэлээр нийтдээ 61 удаагийн сургалтыг онлайнаар давхардсан тоогоор 2719 эмэгтэйчүүдийг хамруулсан.

Хүүхдийн эмнэлгийн бус эндэгдлийн шалтгаан, үр дагаварыг дүгнэх, дахин давтагдахаас сэргийлэх, эрсдэлт нөхцөл байдлыг дүгнэх, холбогдох эмч нарын үйл ажиллагаа, үүрэг, хариуцлага, харилцаа, хандлага, эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар аюулгүй ажиллагааны үр дүнг дээшлүүлэх зорилготой 3-р улирлын байдлаар 6 тохиолдол гарсан. Үүнээс магадлан хэлэлцэх хуралд 4 тохиолдлыг хэлэлцсэн. Мөн амьгүй төрөлтийн 9 тохиолдлыг хэлэлцэж, хурлаас гарсан зөвлөмжийн дагуу эрсдэлт бүлгийн нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүд болон архины хамааралтай эмэгтэйчүүдийн судалгаа шинэчлэн гаргаж, жирэмснээс сэргийлэх арга хэрэгслийн хамрагдалт сайжирсан байна. 1-5 хүртэлх хүүхдийн нас баралт буурсан үзүүлэлттэй байна.


Жирэмсний хяналтыг сайжруулахаар амгалан амаржих газрын төрөлжсөн нарийн мэргэжлийн зөвлөх эмчтэй хамтран өндөр эрсдэлтэй 147 жирэмсэн эмэгтэйчүүдийг үзэж цаашид гарах эрсдэлийг тооцон ажиллаж байна.

ЭМТ-ийн даргаар батлуулсан 2023.01.10, 2023.02.08, 2023.03.29, 2023.04.13, 2023.06.15, 2023.08.12, 2023.09.17-ны өдрийн "Эх барих эмэгтэйчүүдийн эмч нар болон эх баригч нарын жирэмсний карт хөтлөлтөнд дэмжлэг" хяналтыг сар бүр тогтмол хийж, гарса алдаа дутагдалд зөвлөмж өгч ажиллаж байна.

Жирэмсэн эхчүүдэд эрүүл мэндийн боловсролыг "Жирэмсэн үеийн сэтгэл зүй" "Жирэмсний хяналтын ач холбогдол" "Гэр бүл төлөвлөлт", "Жирэмсэн үеийн эмийн хэрэглээ" "Жирэмсний үед илрэх аюултай шинж тэмдэг, түүний урьдчилан сэргийлэлтийн талаар", "Жирэмсэн үед фолийн хүчил, төмрийн бэлдмэл уухын ач холбогдлын талаар сургалтуудыг онлайнаар давхардсан тоогоор 2100 хүнд хийсэн байна.

"Нярайн шарлалтын эмнэлзүй, оношилогоо эмчилгээ"-ний сургалтыг 2023 оны 03 сарын 09-ний өдрийн сургалтад харьяа амбулаторийн хүүхдийн кабинетын хүүхдийн эмч 4, өрх эмч 26, 2 тосгоны эрүүл мэндийн төвийн 2 нийт 32 эмч, "Нярайн үзлэг" сургалтыг 2023 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр харьяа хүүхдийн кабинетын эмч, өрхийн эрүүл мэндийн төвийн залуу эмч нар нийт 32 эмчийг тус тус сургалтад хамруулсан. "Хүүхдийн амьсгалын замын халдварулаан бурханы хүндрэл" эмнэлзүй сургалтыг 05 дугаар сарын 24-ний өдөр хүүхдийн эмч, өрхийн эрүүл мэнд. Тосгоны эрүүл мэндийн нийт 35 эмч нарт, "Эрэмбэлэн ангилалт яаралтай тусламж" сургалтыг 09 дүгээр сарын 13-ны өдөр өрхийн, 2 тосгоны эмч нарт нийт 42 эмч, "Амьсгалын замын цочмог халдвар, томуу, томуу төст өвчний сэргийлэлт, эмнэлзүй, эмчилгээ оношилгоо, нарыг тус тус хамруулсан. "Томуу, томуу төст өвчний сэргийлэлт, эмнэлзүй, эмчилгээний удирдамж" "Амьсгалын замын цочмог халдварын үед хэрэглэгдэх утлага эмчилгээ "Хүүхдийн сүрьеэгийн өнөөгийн байдал, тандалт хүүхдийн эмч, өрхийн эмч нарыг 10 дугаар сарын 04-нд нийт 38 нарыг тус тус хамруулсан. "Хүүхдийн өвчний цогц менежментийн сургалтыг 2023 оны 10 дугаар сарын 22-ны өдрөөс 5 хоног өрхийн

32 эмчийг, “Хоол тэжээлийн цочмог дутлын сургалтыг нийгмийн эрүүл мэндийн багш нар 11 дүгээр сарын 13-наас өрхийн эрүүл мэндийн төвийн 30 хүнийг хамруулсан.



• “ХАВДРЫН ЭСРЭГ” арга хэмжээ нийт 6 зорилт 61 арга хэмжээ хэрэгжүүлэхээс БЗДЭМТ-ийн хэмжээнд 5 зорилт 10 арга хэмжээ хэрэгжүүлэхээр тусгагдсанаас 2023 оны 11-р сарын байдлаар 10 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, хэрэгжилт 98 хувьтай ажилласан байна.

“Хавдраас сэргийлье”, “Эрсдэлт хүчин зүйлийн хор хөнөөл, нөлөө”, “Умайн хүзүүний эсийн шинжилгээг хэрхэн авдаг”, “Хавдрын үеийн хөнгөвчлөх тусламж үйлчилгээг үзүүлэх нь”, “Хорт хавдартай үйлчлүүлэгчийн ар гэрт өгөх зөвлөгөө” зэрэг сэдвүүдээр байгууллагын цахим хуудас, пэйж хуудас болон өрхийн эрүүл мэндийн төвийн цахим сүлжээгээр 30 гаруй сурталчилгааны материал, инфографик боловсруулан 100,000 иргэнд хүргэсэн. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн эрүүл мэндийн багш, туслах багш нарт хавдраас урьдчилан сэргийлэх, түүний ач холбогдол, хүүхдийн хоногийн хоолны илчлэгийн хэмжээ, хүнсний бүтээгдэхүүний зөв хадгалалт, эрт илрүүлэгийн ач холбогдолын талаар мэдлэг олгох сургалтыг нийт 2500 багш, туслах багш нарт 45 удаагийн сургалт хийсэн. Хорт хавдрын хамгийн нийтлэг эрсдэлт хүчин зүйл болох шууд болон дам тамхидалтын тархалтыг бууруулахад чиглэсэн ажлын хүрээнд Өсвөр насны 7-10-р ангид “Тамхи, архины нөлөө эрүүл мэндэд хэрхэн яаж нөлөөлдөг вэ?”, “Архи, тамхи зүрх судасны тогтолцоонд хэрхэн нөлөөлдөг вэ?”, “Архи, тамхинаас татгалзах аргууд”, “Тамхины зохисгүй хэрэглээг бууруулах нь”, “Нийгэм, эдийн засагт учруулах тамхины нөлөө” сэдвээр давхардсан тоогоор 5400 гаруй сурагчид, Холбоо мэдээлэл, Донбоско МСҮТ, Отгонтэнгэр, УБИС-ийн 1000 гаруй оюутанд эрүүл мэндийн хичээл орсон байна.



Тэмдэглэлт өдрийн хүрээнд Хөхний болон умайн хүзүүний эрт илрүүлэгийн 2022 оны мэдээ, цаашид анхаарах зүйл, хөнгөвчлөх тусламж үйлчилгээ, зөвлөгөө, хооллолт, хорт хавдартай үйлчлүүлэгч, тэдний ар гэрт өгөх зөвлөгөө сэдвүүдээр хавдрын эмч, сувилагч ажлын байранд 9, танхимаар 26 мэргэжилтэнд тус тус зохион байгуулж, нийт 35 мэргэжилтэнийг чадавхижуулж, дотоодын 42 сургалтад 512 мэргэжилтэн тус тус хамрагдаж, нийт 47 удаагийн сургалтад 683 эрүүл мэндийн ажилтан хамрагдсан.



2023-04/06-07 ХБӨХМ
сургалт
65 Items



2023-03/23-24 ХБӨХМ
сургалт
43 Items

Эрүүл мэндийн төвийн даргын А/94 тоот тушаалын Урьдчилан сэргийлж-Эрүүл амьдаръя-Өглөөний цайг өөртөө- Өөрчлөлтийг өөрөөсөө аянд артерийн даралт, цусан дахь сахар тодорхойлох, чихрийн шижингийн эрсдэлийг үнэлэх, биеийн жингийн индекс тооцох, амин дэм, эрдэс, ясны сийрэгжилт тодорхойлох, хооллолтын болон сэтгэл зүйчийн зөвлөгөө өгөх, ерөнхий хавдрын болон элэг, өндгөвч, бүдүүн гэдэсний хавдрын маркерийн шинжилгээ, хеликобактери, MRSA илрүүлэх шинжилгээ, сүрьеэгийн эрсдэл үнэлэх, нүдний эмчийн үзлэг, оношилгоо гэх мэт 16 оношилгоонд нийт 309 эмч, мэргэжилтэн хамрагдсан байна. Элэг /АФП/, элэг нарийвчилсан анхдагч /PIVKAII/, өндгөвч/CA-125/, бүдүүн гэдэс/CEA/-ний гэх мэт 4 төрлийн хавдрын маркерийн шинжилгээг нийт 309 ажилтанд хийсэн. Үүнээс хавдрын маркер эерэг 20 ажилтан илэрсэн. Тус эерэг гарсан ажилчдын 7 нь жирэмсэн болон сарын тэмдэг ирсэн байсан тул CA-125 /өндгөвч/ маркер эерэг гарсан, 4 ажилтан шинжилгээний бэлтгэл буруу хангагдсан 8 ажилтаны шинжилгээ өөрчлөлттэй буюу хавдрын урьдал илэрсэн. Хавдрын маркер эерэг гарсан ажилчид нь элэгний хатууралтай, үрэвсэлтэй, элэгний өөхлөлтэй хүмүүст илүү илэрсэн

байна. Тухайн хүмүүст дараагийн нарийвчилсан оношилгоо шинжилгээнд хамрагдах хавдрын эмчийн заавар зөвлөмжийг хүргэсэн.

“ЭЛЭГ БҮТЭН МОНГОЛ” арга хэмжээний төлөвлөгөөг Эрүүл мэндийн сайдын 577 тоот тушаалын дагуу 4 зорилт 30 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 2023 онд 29 арга хэмжээг хэрэгжүүлж, хэрэгжилт 96.6% хувьтай байна. 2023 онд С вирусийн илрүүлэг шинжилгээнд нийт 8787 хүнийг хамруулж эерэг тодорхойлогдсон 357 хүнийг ачаалал тоолох шинжилгээнд илгээж үүнээс 88 хүн хамрагдаж идэвхтэй 15 хүнийг хяналтад авч эмчлэн эрүүлжүүлж байна.

В Вирусийн илрүүлэг шинжилгээнд 8764 хүнийг хамруулж, эерэг тодорхойлогдсон 283 хүнийг ачаалал тоолох шинжилгээнд 135 хүнийг илгээж үүнээс идэвхтэй тодорхойлогдсон 15 хүнийг хяналтад авч эмчлэн эрүүлжүүлж байна. Мөн Гепатитын В, С вирустэй жирэмсэн эхийн илрүүлэг тандалт, бүртгэл мэдээлэл, тандалтыг дүүргийн харьяа 26 өрхийн эрүүл мэндийн төв, 2 тосгоны эрүүл мэндийн төвийн түвшинд илрүүлж тухай бүр дүүргийн халдвартын эмч, дотрын эмчид илгээгдэж бүртгэн сар бүр ХӨСҮТ-д мэдээлж хариу арга хэмжээг авч ажиллаж байгаа бөгөөд 2023 оны эхний 10 сарын байдлаар С вирусийн илрүүлэг шинжилгээнд 2641 жирэмсэн хамрагдаж С вирус эерэг тодорхойлогдсон 30 жирэмсэн бүртгэгдсэн байна. Үүнээс ачаалал тоолох шинжилгээнд 13 жирэмсэн хамрагдсан байна. В вирусийн илрүүлэг шинжилгээнд 2860 жирэмсэн хамрагдаж В вирус эерэг тодорхойлогдсон 33 жирэмсэн бүртгэгдсэн байна. Үүнээс ачаалал тоолох шинжилгээнд 10 жирэмсэн хамрагдсан байна.



• “ХАРШЛААС СЭРГИЙЛЭХ” арга хэмжээ нь нийт 4 зорилт 48 арга хэмжээ хэрэгжүүлэхээс БЗДЭМТ-ийн хэмжээнд 3 зорилт 15 арга хэмжээ хэрэгжүүлэхээр тусгагдсанаас 2023 оны 11 дүгээр сарын байдлаар 14 арга хэмжээг хэрэгжүүлж, хэрэгжилт 93 хувьтай ажилласан байна. Байгууллагын вэб сайтаар болон фэйсбүүк пэйж хуудсаар нийт сургалт сурталчилгаанд хамрагдсан хүний тоо 7041 байна. Харшлаас сэргийлэх дэлхийн өдрийг угтан БЗДЭМТөв болон Өрхийн эрүүл мэндийн төвөөс Аж ахуй нэгж байгууллагуудтай хамтран “Харшлын дэлхийн өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлсэн. Нийт өдөрлөгийн тоо 5. Харшил судлалын чиглэлээр зохион байгуулсан сургалтын тоо 22, дүүргийн хэмжээнд арьс харшлын өвчтэй иргэдийг амбулаторид үзэж картад дүгнэлт бичдэг. Диспансерын хяналтад нийт 64 иргэн, үүнээс хүүхэд 10. Хөдөлмөр чадвар алдалт тогтоолгосон 27 байна. Атопийн дерматит, астматай өөрийгөө хянах төлөвлөгөөг хэрэгжүүлдэг үйлчлүүлэгчийн тоо-21.



• "ЭРҮҮЛ ЧИЙРЭГ ЭР ХҮН" арга хэмжээ нь нийт 4 зорилт 45 арга хэмжээ хэрэгжүүлэхээс БЗДЭМТ-ийн хэмжээнд 3 зорилт 20 арга хэмжээ хэрэгжүүлэхээр тусгагдсанаас 2023 оны 11 дүгээр сарын байдлаар 20 арга хэмжээг хэрэгжүүлж, хэрэгжилт 100 хувьтай ажилласан байна. Эрэгтэйчүүдийн эмчийн (урологи, андрологи) тоо-1, Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд, аймгийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эмнэлэгт эрэгтэйчүүдийн кабинетын (урологи, андрологи)-1. Андрологийн кабинетаар 2023 оны 11 сарын байдлаар 1329 хүн үйчлүүлсэн.

"Өсвөр үе залууст ээлтэй клиник" цахим хуудсаар дамжуулан 7 төрлийн зөвлөмжийг 4823 хүргэсэн. Өсвөр үеийн 73 хөвгүүдийн тулгамдсан асуудлыг сонсож асуултанд нь тохирсон зөвлөгөө мэдээлэл өгсөн. Өсвөр үеийн "Бэлгийн ба нөхөн үржихүйн эрүүл мэнд"-ийн сургагч багш бэлтгэх сургалтанд этүгэн их сургууль болон ерөнхий боловсролын 148, 127, 111 сургуулиудтай хамтран 76 үе тэнгийн сургагч багшаар бэлтгэсэн. Үе тэнгийн сургагч багш нар нь 6-аас 10 ангийн 71 бүлгийн 2838 хүүхдүүдэд нөхөн үржихүйн эрүүл мэнд, халдварт өвчин, халдварт бус өвчин чиглэлээр сургалт орсон. Үе тэнгийн сургагч багш нартаа 4 брошур 1 бичлэг бэлдэж өгсөн. 2023 оны 01-р сарын 01-нээс 10-р сарын 01 байдлаар Урьдчилан сэргийлэх эрт илрүүлгийн үзлэг, оношилгоо, шинжилгээнд нийт 186536 иргэн буюу эрэгтэйчүүд хамрагдсан.



Зорилт 3. “Элэг бүтэн Монгол” арга хэмжээний үр ашиг, өгөөж, хүртээмжийг нэмэгдүүлж, элэгний Д вирусийн халдвартай иргэдийн 50-иас дээш хувийг эмчилгээнд хамруулж, хорт хавдрын эрт илрүүлгийг олон улсын жишигт хүргэнэ.

- Д вирустэй иргэдийг эмчилгээнд хамруулах ажлын хүрээнд элэгний дельта вирустэй иргэд эмчилгээнд тухайн лавлагаа шатлалын эмнэлэгт хянагдаж байна. Д вирусийн эмчилгээ Монгол улсад орж ирээгүй байна.

Зорилт 4. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан иргэд эх орондоо оношлогдон эмчлэгдэх боломжийг нэмэгдүүлж, орчин үеийн оношилгоо, шинжилгээний төвүүдийг шинээр байгуулна.



- 2022 оны 3 дугаар улиралд тус эмнэлгийн барилгыг барих байршлын судалгааг гаргаж, 34 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 3 га газрыг шийдвэрлэсэн боловч 300 ортой эмнэлгийг барихад нийт 15000 га газар шаардлагатай тул газрын асуудлыг Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газар бүрэн шийдвэрлэж чадаагүй. Эрүүл мэндийн төв нь өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлох, шинээр эмнэлэг байгуулахад санхүүгийн боломж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийж, эмнэлэг тусламж, үйлчилгээний ямар чиглэлд ажиллах талаар Эдийн засагчдын холбоогоор судалгаа, төлөвлөлт хийлгэж, 300 ортой эмнэлгийн дотоод зохион байгуулалтын зураг төслийг мэргэжлийн байгууллагаар гаргуулсан, шаардлагатай тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, аж ахуйн тооцооллыг гаргаж, Баянзүрх дүүргээс сонгогдсон Улсын Их хурлын 5 гишүүдэд танилцуулж, шаардлагатай санхүүжилтийг 2024 оны төсөвт тусгуулахаар хүргүүлэн ажилласан.



Зорилт 5. Нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлж, хууль, эрх зүйн орчныг бий болгоно.

- 2021 оны 05 дугаар сарын 25-ны өдөр Төрийн худалдан авах ажиллагааны газраас түлхүүр гардуулах нөхцөлтэй “Нийгмийн эрүүл мэндийн төвийн барилга”-ийн тендерийг зарлаж, 2,159.0 сая төгрөгөөр гүйцэтгэхээр “Шилдээд” ХХК шалгарч, 2021 оны 7 сарын 23-нд захиалагч Эрүүл мэндийн яамтай гэрээ байгуулсан. Газар чөлөөлөх хуучин сүрьеэгийн диспансерын барилгыг 2022 оны 8 сарын 19-нд нурааж дууссан. Сантехникийн шугам сүлжээ татахад 69-р сургууль, 115-р цэцэрлэгээс зөвшөөрөл авч, гадна дулаан, цахилгаан, бетон каркас цутгалтын ажил хийгдсэн бөгөөд 11 сарын 10-ны өдрийн байдлаар дулаан авах хүсэлтийг холбогдох байгууллагад өгч, дотор будгын ажил хийгдэж, тааз хийгдэж, ажлын гүйцэтгэл 90

хувьтай үргэлжилж байна. Барилгын ажлыг 2023 оны 12 сард дуусгаж, ашиглалтад оруулахаар төлөвлөгөөтэй ажиллаж байна.




Зорилт 6. Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн оновчтой арга, хэлбэрийг нэвтрүүлж, эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний нэр, төрлийг нэмэгдүүлж, эрсдэлийн сан байгуулна.

- Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтэд 2021 онд хагас, 2022 оноос бүрэн шилжиж, Эрүүл мэндийн ерөнхий газартай 2022 оны 9 дүгээр сард байгуулсан УБ-01/032 гэрээний дагуу 13 оношийн хамааралттай бүлгээр, 2023 оны 10 дугаар сард хийсэн нэмэлт гэрээний дагуу 7 оношийн хамааралтай бүлгээр эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтийг авч байна.

- Эрт илрүүлгийн үзлэгээр Эрүүл мэндийн төвтэй гэрээний дагуу хамтран ажиллаж байгаа хувийн хэвшлийн 8 эмнэлгүүдэд E-health програмыг суурилуулан цахимжуулснаар эрт илрүүлгийн үзлэгийн тоон мэдээг Hier програмаас өдөр тутам авч ажиллаж байна. Мөн шинжилгээний бүх хариунууд E-clinik-ийн киоск машинаар, E-mongolia програмаас бүрэн гарч байна. 11 сарын байдлаар Киоск машинаар 12660 иргэн үйлчилгээ авч шинжилгээний 19200 хуудас хэвлэгдэн гарсан байна.






• “Up do date” олон улсын тусламж үйлчилгээний удирдамжийн цахим платформыг нэвтрүүлсэнээр 11 сарын 12-ны өдрийн байдлаар нийт 127 эмчийн 109 эмч буюу 85.8% нь ашиглаж байна. Үзлэг хийдэггүй болон чөлөө авсан эмч нараас бусад нь бүгд программыг ашиглаж байна.



Зорилт 7. Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлыг хангаж, хүртээмжийг нэмэгдүүлэн бүртгэл, хяналтын цахим тогтолцоог бүрдүүлнэ.

• Эмийн аюулгүй байдал хадгалалт, зарцуулалтыг сайжруулах зорилгоор эмийн сангийн санхүүгийн программ хангамжтай болох, эмийн сангийн агуулах, нөөцийн өрөөнд нийт 7 камер суулгах, 2 цонхонд хамгаалалтын хаалт хийх, төр хариуцан олгох эмийн өрөөнд засвар хийх гэсэн нийт 3 ажлуудыг төлөвлөсөнөөс эмийн сангийн ORION программ хангамжийг шинээр салбар амбулатори 1, Дарь Эх нэгдсэн эмнэлгийн эмийн санд тавьж, шинээр салбар амбулатори 1-ийн эмийн сангийн 2 цонхонд хамгаалалтын хаалтыг шинээр хийж, эмийн агуулахын 2 өрөөнд 7 камер тавьж байршуулсан. Амбулатори 1-д байрлах Төлбөрийг төр хариуцан олгох эмийн сан нь Эмийн сангийн стандарт MNS2015:5260-ын “Эмийн сангийн барилга байгууламжинд тавигдах шаардлага” 8.1.1, “Эмийн санд тавих эрүүл ахуйн шаардлага” 15.3, 15.7-д заасан шаардлагыг хангахгүй байсан өрөөний хана болон шал зэрэгт засварыг 2023 оны 5 сард хийж, гар угаах угаалтуурыг байршуулан стандартын дагуу өрөөг тохижуулсан.



- Салбар амбулаториудын өндөр өртөгтэй болон нарийн мэргэжлийн нийт 500 гаруй тоног төхөөрөмжүүдийг амбулатори тус бүрээр бүртгэлжүүлж, өндөр өртөгтэй тоног төхөөрөмж ашиглаж байгаа нийт 20 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ байгуулж ажилласан. Тус гэрээг Дарь эх нэгдсэн эмнэлэгт 6 гэрээ, салбар амбулатори 1-д 6 гэрээ, салбар амбулатори 2-д 2 гэрээ байгуулсан.

Зорилт 8. Эрүүл мэндийн ажилтны эрх зүйн шинэчлэл хийж, хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлж, нийгмийн хамгааллыг дэмжинэ.

1. “MACAM II” хөтөлбөрийн хүрээнд 5, 7, 16, 19, 24, 10, 23 дугаар хорооны өрхийн эрүүл мэндийн төвд иргэдийн оролцоотой нөлөөллийн хяналт, хөндлөнгийн үнэлгээг ярилцлага 4, сургалт 4, уулзалт 4, хяналт 10 удаа зохион байгуулж, иргэдийн санал, дэмжлэгээр орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэх боломжтой ажлуудыг төлөвлөн хэрэгжүүлж, гүйцэтгэлийг төслийн хүрээнд ажлын хэсэг иргэдэд тайлагнан мэдээллийн сайтад байршуулан ажилласан. Мөн иргэдийн оролцоотой хороо, өрхийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавьж, санал хүсэлтээ онлайнд хэрхэн байршуулан эгэх холбоотой ажиллах талаар сургалт мэдээллийг 4 удаа тус хорооны иргэд болон өрхийн эмнэлгийн ажилтнуудад хийсэн.

2. www.1313.mn сайтаар анхан шатны 30 нэгж эмнэлгийн үйл ажиллагаа, хүний нөөц, санхүүгийн шилэн дансны мэдээллийг ил байршуулан, эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой иргэдийн саналыг /20-150/ онлайнаар авч тухай бүр нь шийдвэрсэн байна. Баянзүрх дүүргийн 28 өрхийн эрүүл мэндийн төв, 2 тосгоны эрүүл мэндийн төв угтах үйлчилгээний хэсэг QR кодыг иргэдэд ил байршуулан ажиллаж байна. “MACAM II” хөтөлбөрийн хүрээнд 5, 7, 16, 19, 24 хорооны өрхийн эрүүл мэндийн төвд иргэдийн оролцоотой нөлөөллийн хяналт-1, ярилцлага 2, сургалт 1, уулзалт 2 удаа зохион байгуулсан.

Монгол улсын Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор батлагдсан Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжүүлэхээр тусгагдсан 2 зорилт, 17 арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, 2023 оны жилийн эцсийн байдлаар **90** хувь бувуу ҮР ДҮНТЭЙ үнэлгээтэй ажилласан.



1.3. Улс, Нийслэл, Дүүргийн төсөв, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, зээл тусламж болон өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын төлөвлөлтийн оновчтой байдал, гүйцэтгэл, чанар, үр дүн

Улсын хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн арга хэмжээ

1. Баянзүрх дүүргийн 8-р хороонд баригдаж буй ЭМЯ/202102007/№203 дугаарт гэрээтэй “**ТӨРИЙН ӨМЧИЙН НЭГДСЭН ЭМНЭЛЭГ**”-ийн (зарим баримт бичигт Ахмад настан хүүхдийн эмнэлэг гэж дурдагдсан байдаг) барилгын явц 70-80%-тай хэрэгжиж байна. Нийт 8 давхар эмнэлгийн зориулалттай барилга баригдсан. ЭМЯ/202102007/№203 дугаарт гэрээтэй БЗД-ийн 8-р хороонд байрлах Төрийн өмчийн нэгдсэн эмнэлгийн барилгын явцад байгууллагын удирдлагууд биечлэн очиж, 3 удаа очиж хяналт хийж, Нэгдсэн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа MNS5095:2017 стандартын шаардлага хангуулах саналыг өгч хийлгүүлсэнээр барилгын явц 80 хувьтай байна. Ахмад настан, хүүхдийн эмнэлэг (200 ортой) ашиглалтанд ороход гадна цахилгааны узелийн төсвийг 2024 оны төсөвт суулгуулсан бөгөөд уzelь байрлуулах газрыг чөлөөлөх талаар холбогдогдох байгууллагууд ажиллаж байна. Тус эмнэлэг 2024 оны 6 сард ашиглалтанд орох төлөвлөлттэй байна.




2. 2021 оны 05 дугаар сарын 25-ны өдөр Төрийн худалдан авах ажиллагааны газраас түлхүүр гардуулах нөхцөлтэй “Нийгмийн эрүүл мэндийн төвийн барилга”-ийн тендерийг зарлаж, 2,159.0 сая төгрөгөөр гүйцэтгэхээр “Шилдээд” ХХК шалгарч, 2021 оны 7 сарын 23-нд захиалагч Эрүүл мэндийн яамтай гэрээ байгуулсан. Газар чөлөөлөх хуучин сүрьеэгийн диспансерын барилгыг 2022 оны 8 сарын 19-нд нурааж дууссан. Сантехникийн шугам сүлжээ татахад 69-р сургууль, 115-р цэцэрлэгээс зөвшөөрөл авч, гадна дулаан, цахилгаан, бетон каркас цутгалтын ажил хийгдсэн бөгөөд 11 сарын 10-ны өдрийн байдлаар дулаан авах хүсэлтийг холбогдох байгууллагад өгч, дотор будгын ажил, тааз хийгдэж, ажлын гүйцэтгэл 90 хувьтай үргэлжилж байна. Барилгын ажлыг 2023 оны 12 сард дуусгаж, ашиглалтад оруулахаар төлөвлөгөөтэй ажиллаж байна.



Нийслэлийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн арга хэмжээ

Дарь-эх нэгдсэн эмнэлэгийн яаралтай тусламжийн тасагруу орж гарах машины орц гарцыг Нийслэлийн захирагчийн ажлын албанаас гүйцэтгэсэн.



Дүүргийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн арга хэмжээ

Поликлиникийн эмэгтэйчүүд, хүүхдийн кабинетуудад дотоод засварын ажлын тендер 2023 оны 05 сард Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газраас 150 сая төгрөгөөр зарлагдсан. 2023 оны 09 сард “Баяндээ” ХХК шалгарч гэрээ байгуулсан. Барилгын засварын зургийн ажил Барилгын хөгжлийн төвийн магадлалаар хянагдаж байна. Засварын ажлыг 2023 оны 12 сард эхлэхээр төлөвлөж байна.

Өөрийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн арга хэмжээ

Поликлиникийн гадна фасадны их засварын ажлын тендерийг өөрийн хөрөнгөөр 350 сая төгрөгөөр зарлаж, “Зууны сод хийц” ХХК шалгарч гэрээ байгуулан 2023 оны 05 сараас 07 сарын хугацаанд хийж гүйцэтгэн 08 дугаар сарын 14-нд комисс хүлээн авч, иргэд үйлчлүүлэгчид үйлчлүүлэх таатай орчин бүрдсэн.



Салбар амбулатори 1-ийн эмэгтэйчүүдийн кабинетэд Шинжьюкү ХХК-иас 279,564,000 төгрөгийн үнэтэй ургын гажиг тодорхойлох суурин ЭХО аппаратыг 2023 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр нийлүүлсэн.



Салбар амбулатори 1-ийн эрэгтэйчүүдийн кабинетэд Ашидбуян ХХК-иас 78,264,549 төгрөгийн зөөврийн ЭХО аппарат 1 ширхэг, төмсөг хэмжих орхидометр 1 ширхэг, халаагч тавцан /cell heater platform, warmaer platform/ 1 ширхэг, эр бэлгийн эс тоологч/ эс тоологч тоолуур/ 1 ширхэг, маклер чамбер makler chamber-ийн эс бэлгийн эс тоолох тор 1 ширхэг, жин хэмжигч 1 ширхэг, глюкометр 1 ширхэг, микроскоп 1 ширхэг, негатскопи 1 ширхэг, центрифуги 1 ширхэг, жижиг мэс ажилбарын ком багаж 1 ширхэг нийт 11 нэр төрлийн тоног төхөөрөмжийг 2023 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр нийлүүлсэн.



Сүвэн уул ХХК-иас нийт 19,238,000 төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмжүүдийг салбар амбулатори 1-ийн ариутгалын кабинетад ам наагч 1 ширхэг, уламжлалтын кабинетэд инфра улаан гэрэл 1 ширхэг, доторын кабинетад суурин даралтын аппарат 1 ширхэг, Салбар амбулатори 2-ын уламжлалтын кабинетад инфра улаан гэрэл 1 ширхэг, Поликлиникийн эмэгтэйчүүдийн кабинетад суурин даралтын аппарат 1 ширхэг, лабораторид биохимийн бүрэн автомат анализаторын ус цэвэршүүлэгч 1 ширхэг, Дарь эх нэгдсэн эмнэлгийн лабораторид биохимийн бүрэн автомат анализаторын ус цэвэршүүлэгч 1 ширхэг аппаратуудыг 2023 оны 06-р сарын 28-ны өдөр нийлүүлэгдсэн.



Салбар амбулатори 1-ийн дурангийн кабинетэд СИ АЙ ТИ ХХК-иас 80,000,000 төгрөгийн үнэтэй уян дурангын хошууг 2023 оны 06-р сарын 15-ны өдөр нийлүүлсэн.



Монголфарм ХХК-иас 10,890,000 төгрөгийн өртөгтэй Солонгосын Үндэсний Сүрьеэгийн Нийгэмлэг Койкагийн санхүүжилтээр сүрьеэгийн далд халдварыг илрүүлэх ИГРА шинжилгээний аппаратыг 2023 оны 06-р сарын 27-ны өдөрт сүрьеэгийн диспансерт хүлээлгэн өгсөн. Мөн Медикал ресус ХХК-аас 5,600,000 төгрөгийн үнэтэй термостат, 1,300,000 төгрөгийн үнэтэй центрифуги тус тус нийлүүлсэн байна.



Гадаадын зээл тусламжаар хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөр, арга хэмжээ

Солонгосын Үндэсний Сүрьеэгийн Нийгэмлэгтэй хамтран Койка ОУБ-ын санхүүжилтээр нийслэлийн 6 дүүргийн 2021, 2022 онд сүрьеэгээр өвдсөн иргэдийн хавьтал иргэдэд сүрьеэ илрүүлэх үзлэгийг хуваарийн дагуу зохион байгуулан ажиллаж байна. Үзлэгт 600 хүн хамрагдсанаас сүрьеэгийн 6 тохиолдол, сүрьеэгийн далд халдварын 11 тохиолдол илрүүлэн эмчилгээнд хамруулан ажиллаж байна.



Солонгосын үндэсний сүрьеэгийн нийгэмлэгээс 2023 оны 06 сарын 28-ны өдөр БЗД-ийн ЭМТ-н Сүрьеэгийн диспансерт цусанд далд сүрьеэ илрүүлэх iCHROMA-III аппаратыг дагалдах хэрэгсэл оношлуурын хамт хүлээж авсан. Хүлээж авсанаас хойш Сүрьеэгийн диспансерт бүртгэгдсэн түрхэц эерэг, сөрөг, эмэнд тэсвэртэй сүрьеэгийн хавьтал, сайн дурын үндсэн дээр шинжилгээнд хамрагдсан нийт 470 иргэнд шинжилгээ хийж 97 шинжилгээ эерэг гарсан бөгөөд эдгээрээс 56 тохиолдолыг сүрьеэгийн далд халдварын эмчилгээнд хамруулсан байна.



1.4. “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангахад чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөж, зохион байгуулсан байдал

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд Эрүүл мэндийн төвийн хийж хэрэгжүүлэх 1 бүлэг, 7 зорилт, 18 арга хэмжээний хэрэгжилт жилийн эцсийн байдлаар **88** хувийн хэрэгжилттэй байна.


✓ **ХОЁР. ЭРҮҮЛ МЭНД-бүлгийн хүрээнд Зонхилон тохиолдох халдварт бус өвчин эмгэг, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлсийг тандах, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, эмчлэх замаар нас баралтын хувийг бууруулах зорилтын хүрээнд** Зонхилон тохиолдох халдварт бус өвчнөөс сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах эмч, эрүүл мэндийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалтыг “Эрүүл мэндийн боловсролыг дэмжих ухуулга, нөлөөллийн арга хэмжээ, зан үйлийг өөрчлөх, мэдээлэл, сургалт сурталчилгааны төрөл, чанарыг сайжруулж, иргэдийн сонирхол төрүүлэхүйц шинэлэг, сонирхолтой хэлбэрээр хэрэгжүүлэх”, “Халдварт бус өвчлөл, өвчний эрт үеийн хяналт, тандалтыг сайжруулах, эрт илрүүлгийн хамрагдалтыг нэмэгдүүлэх”, “Умайн хүзүүний хорт хавдрын цогц хяналтын зааврын танилцуулга”, “Хорт хавдрын өвчлөл, өвчний эрт үеийн хяналт, тандалтыг сайжруулах, эрт илрүүлгийн хамрагдалтыг нэмэгдүүлэх” зэрэг 4 сэдвийн хүрээнд 136, дотоодын 42 сургалтад 512 мэргэжилтэн тус тус хамрагдаж, нийт 46 удаагийн сургалтад 648 эрүүл мэндийн ажилтан хамрагдсан. Баянзүх дүүргийн нутаг дэвсгэрийн зах, худалдааны төв дээр зохион байгуулагдсан “Нэгдсэн арга хэмжээ” өдөрлөгт 5000 гаруй иргэн, 150 гаруй сургалтанд 5,100 иргэн хамрагдаж, 100 төрлийн мэдээ, мэдээллийг 110,000 иргэнд хүргэсэн. Эрүүл мэндийн төвийн ажилтануудын дунд зохиогдсон “Урьдчилан сэргийлж-эрүүл амьдарья-өглөөний цайг өөртөө-өөрчлөлтийг өөрөөсөө” аяны хүрээнд артерийн даралт, цусан дахь сахар тодорхойлох, чихрийн шижингийн эрсдэлийг үнэлэх, биеийн жингийн индекс тооцох, амин дэм, эрдэс бодис, ясны сийрэгжилт тодорхойлох, хеликобактери илрүүлэх, ерөнхий хавдрын болон элэг, өндгөвч, бүдүүн гэдэсний хавдрын маркерийн шинжилгээ, нүдний эмчийн үзлэг, оношилгоо хооллолтын болон сэтгэл

зүйн зөвлөгөө гэх мэт нийт 16 оношилгоонд 310 ажилтан хамрагдсан байна. 2023 оны эхний 10 сарын байдлаар бөөр шээсний замын эрт илрүүлэг шинжилгээнд 37596 иргэн хамрагдаж, бөөрний нарийн мэргэжлийн эмчид 5401 иргэн үзүүлсэнээс 510 иргэн өдрийн эмчилгээнд хамрагдсан ба үүнээс 92 буюу 18% нь бөөрний үрэвслийн оношоор эмчлэгдэн эрүүлжиж байна. Үүнд:

- Зонхилон тохиолдох осол гэмтлээс сэргийлэх чиглэлээр 5 удаагийн сургалтыг сургуулийн өмнөх боловсролын байгууллагын ажилтан, албан хаагч нар, эцэг эх асран хамгаалагч нарт зохион байгуулж, нийт 141 хүнийг хамруулж, осол гэмтлээс сэргийлэх чиглэлээр 5 удаагийн өдөрлөгөөр дамжуулан 3000 орчим иргэдэд зөвлөгөө мэдээлэл хүргэсэн. Байгууллагын цахим хуудсаар дамжуулан осол гэмтлээс урьдчилан сэргийлэх 2 төрлийн видео шторк, 15 төрлийн зөвлөмжийг байршуулж 12000 иргэнд хүргэсэн.



- Эрүүл мэндийн төвийн даргын А/94 тоот тушаалын Урьдчилан сэргийлж-Эрүүл амьдаръя-Өглөөний цайг өөртөө- Өөрчлөлтийг өөрөөсөө аянд артерийн даралт, цусан дахь сахар тодорхойлох, чихрийн шижингийн эрсдэлийг үнэлэх, биеийн жингийн индекс тооцох, амин дэм, эрдэс, ясны сийрэгжилт тодорхойлох, хооллолтын болон сэтгэл зүйчийн зөвлөгөө өгөх, ерөнхий хавдрын болон элэг, өндгөвч, бүдүүн гэдэсний хавдрын маркерийн шинжилгээ, хеликобактери, MRSA илрүүлэх шинжилгээ, сүрьеэгийн эрсдэл үнэлэх, нүдний эмчийн үзлэг, оношилгоо гэх мэт 16 оношилгоонд нийт 310 эмч, мэргэжилтэн хамрагдаж тус бүр зөвлөгөө өгсөн байна.



- Зөв зохистой хооллолтын чиглэлээр 8308 иргэнд ганцаарчилсан зөвлөгөө, танхимын сургалтаар 3765 иргэдийг хамруулж, нийт 12073 иргэнд зөвлөгөө зөвлөмж өгч ажилласан байна.



• “Энэ жилдээ-Эрүүл жиндээ” аяны хүрээнд БЗД-ийг үндэсний хэмжээнд ТҮМЭН дасгалыг сурталчлагч загвар дүүрэг болгох зорилгоор идэвхтэй хөдөлгөөн, чийрэгжүүлэлтийн ТҮМЭН дасгалын сургагч багш бэлтгэх, мэргэжил аргазүйн сургалтыг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, БЗД-ийн Биеийн тамир спорт хороотой хамтран амжилттай зохион байгуулж, үндэсний хэмжээнд ТҮМЭН дасгалыг сурталчлагч загвар дүүрэг болон өргөмжлөгдсөн. Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, биеийн тамир, спортын үйл ажиллагааг идэвхжүүлэх, идэвх сонирхлыг дэмжих, хөдөлгөөний хомсдолоос сэргийлэх, эрүүл мэндийг бэхжүүлэх зорилгоор ЭМТ-ийн даргын 2023 оны А/89 дугаар тушаалын хүрээнд, Биеийн тамир спортын хороо, ЭМТ-ийн ҮЭ-ийн салбар хороотой хамтран зохион байгуулсан эрүүл мэндийн төвийн ажилтан, албан хаагчдын дундах явган аялал, спортын арга хэмжээ явагдаж алба хаагчид идэвхтэй оролцож, өргөмжлөл, мөнгөн шагналаар урамшуулсан.



• Дүүргийн харъяа ААНБ, ИДС, ЕБС, СӨБ, БЗДЗДТГ НДХ, ЭМТ болон амбулаторид хяналтанд байдаг жирэмсэн ээж болон аавууд, хорооны хэсгийн ахлагч, иргэд олон нийтэд “Сэтгэцийн эрүүл мэнд”, “Сэтгэл зүйн боловсрол”, “Сэтгэл зүйдээ анхаарал хадуулах нь эмгэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтуудыг зохион байгуулан сургалтаар мэдээлэл зөвлөгөө өгч мөн оролцоонд тулгуурлан асуулт хариулт, чөлөөт ярилцлага, хамт олны харилцааг сайжруулах, өөрийн мэдрэмжийг гадагшлуулж суралцах сэтгэл зүйн дасгал ажил явуулан, сэтгэл зүйн боловсролын тараах материал өгөн сургалт, сурталчилгааг зохион байгуулсан.

Нийт 156 удаагийн сургалтаар 2352 сурагч, оюутан, багш, алба хаагч, иргэд, олон нийт хамрагдсан. 28 өрх, тосгоны эрүүл мэндийн төвийн 160 эмч, мэргэжилтэн, нийгмийн ажилтан нарт “Сэтгэл зүйн анхан шатны тусламж ба сэтгэл зүйн боловсрол”, “Стресс менежмент” сэдвээр сургалт зохион байгуулж, “Гамшгийн үеийн сэтгэл зүйн дэмжлэг” чиглэлээр 3 удаагийн сургалт, уулзалтыг 15 айл өрх, 3 ӨЭМТ дээр зохион байгуулсан.

Олон нийтийн нийгмийн сүлжээ болох UBS, C1, NTV, Eagle телевиз, мэдээний 2 сайтад “Сэтгэцийн эрүүл мэнд”, “Өсвөр насны сэтгэл гутрал, түгшилт”, “Нойргүйдэл”, “Стресс тайлах арга зам”, “Дэлгэцийн хамаарал” сэдвүүдээр нийт 11 удаагийн иргэд, олон нийтэд ярилцлага, зөвлөмж, мэдээлэл хүргэсэн.

Мөн Авто машингүй өдөр /Бөхийн өргөө/ болон Баянзүрх зах, Тэнгэр худалдааны төв, Дүнжингарав төв, Нарантуул ОУХТөвийн гадаа талбайд /Намайг алгас/, үндэсний цэцэрлэгт хүрээлэн, БЗДЭМТ Салбар амбулатори 1, Сүхбаатрын талбайн өдөрлөгөөр иргэд, олон нийтэд зориулан сэтгэцийн эрүүл мэндийн болон архи согтууруулах ундаа хорт зуршлаас татгалзах талаар тараах материал тарааж, нийт 7 удаагийн гадаа талбайн өдөрлөгт 2000 гаруй иргэдэд мэдээлэл, сурталчилгааны нөлөөллийн ажил зохион байгуулсан.

Олон улсын эрдэм шинжилгээний хуралд Монгол улсын 21 аймаг, Улаанбаатар хотын 9 дүүрэг, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Эрүүл мэндийн яам, сэтгэцийн эрүүл мэндийн салбарт хийгдсэн 61 эрдэм шинжилгээний судалгааны бүтээлүүд хэлэлцэгдэж Сэтгэц наркологийн багийн “Баянзүрх дүүргийн ӨЭМТ-д ажиллаж буй эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн сэтгэцийн эрүүл мэндийн байдлыг үнэлсэн нь” судалгаа 3-р байранд шалгарсан.

Мансууруулах бодистой холбоотой болон Архидан согтуурахтай тэмцэх, архины хор хөнөөл, хүний эрүүл мэнд, гэр бүл, хамт олон, нийгэмд учрах хор уршиг, түүнээс урьдчилан сэргийлэх болон архины хэрэглээг багасгах, архинд донтох эмгэг, архинаас хэрхэн татгалзах талаар 65 арга хэмжээ зохион байгуулж, сургалтанд 634 иргэн хамруулж, 2 өдөрлөгт 308 иргэнд мэдээлэл зөвлөгөө хүргэж ажилласан.

Дээрх арга хэмжээний үр дүнд Артерийн гипертензи эрт илрүүлэг 226386 хүн хамрагдахаас 127764 буюу 56.4 %, Чихрийн шижингийн эрт илрүүлэг 226386 хүн хамрагдахаас 115508 буюу 51.0 %, Умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлэг 28555 хүн хамрагдахаас 8588 буюу 27%, Хөхний өмөнгийн эрт илрүүлэг 121450 хүн хамрагдахаас 66261 буюу 54.6% тус тус хамрагдсан байна. Элэгний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт 15119 хүн хамрагдсан байна. **хэрэгжилт 90%,**



✓ **Халдварт өвчнөөс сэргийлэх, илрүүлэх, хянах, тандах, эмчлэх үйл ажиллагааг сайжруулан өвчлөлийг бууруулах зорилтын хүрээнд** БЗДХ/ДОХ, сүрьеэ халдварт гепатит болон бусад халдварт өвчний илрүүлэлтийг нэмэгдүүлж, эмчилгээнд хамруулах арга хэмжээний хүрээнд 2023 онд төрөлхийн тэмбүүгийн 3 тохиолдол бүртгэгдсэнээс хяналтанд ороогүй 2, амьгүй 1 тохиолдол бүртгэгдсэн. 2023 онд 11180 жирэмсэн эмэгтэй серологийн шинжилгээнд хамрагдаж, 121 тэмбүүгийн шинэ тохиолдол илрүүлж, эмчилгээнд хамруулсан нь өмнө оны мөн үетэй харьцуулахад 4,3 хувиар өссөн байна. 2023 онд 2021, 2022 онд сүрьеэгийн хавьтал гэж бүртгэгдсэн 1070 иргэнээс 676 буюу 63.2%-ийг үзлэгт хамруулж 7 шинэ тохиолдол илрүүлэн эмчилгээнд хамруулсан. Солонгосын үндэсний сүрьеэгийн нийгэмлэгтэй хамтран 2020, 2021, 2022 онд бүртгэгдсэн сүрьеэгийн тохиолдлын хавьтал 1293 иргэнийг урьдчилан сэргийлэх давтан үзлэгт хамруулж, 12 шинэ тохиолдол илрүүлэн эмчилгээнд хамруулсан.

Сүрьеэгийн диспансер нь эрсдэлт бүлгийн 4869 хүнээс 2750 иргэнийг үзлэгт хамруулж 31 тохиолдлыг илрүүлэн эмчилгээнд хамруулсан. Мөн Солонгосын үндэсний сүрьеэгийн нийгэмлэг, Монголын өрхийн анагаах ухааны мэргэжилтэнүүдийн холбоо, Эрүүл сүрьеэгүй ирээдүйн төлөө Төрийн бус байгууллагуудтай холбоотой хамтран хүүхдийн байгууллагад бүртгэгдсэн сүрьеэгийн хавьтал болон хороодын эрсдэлт бүлгийн 3087 иргэдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж 10 сүрьеэ, 56 сүрьеэгийн далд халдварыг илрүүлэн эмчилгээнд хамруулсан байна. Эрүүл мэндийн сайдын 2017 оны 4 сарын 14-ны өдрийн “Журам батлах тухай” А/145 тоот тушаалын дагуу 6834 иргэнийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, сүрьеэгийн 1 тохиолдлыг илрүүлж эмчилгээнд хамруулсан. 2023 оны 11 сарын 10-ны өдрийн байдлаар архины албадан эмчилгээний нийт 229 иргэн сүрьеэгийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан байна. Сүрьеэгийн 1 тохиолдол илрүүлж Энэрэл эмнэлэгт хүлээлгэн өгсөн. **хэрэгжилт 100%,**



✓ Товлолын дархлаажуулалтын хамралтын хувийг нэмэгдүүлэх зорилгоор өрхийн эрүүл мэндийн төвүүдэд товллын дархлаажуулалтын төлөвлөлтийг чанаржуулах, товллын дархлаажуулалтад хамрагдаагүй хүүхдийн бүртгэлийг сайжруулах, хамрагдаагүй шалтгааныг тодорхойлох зэрэг дэмжлэгт хяналтыг


зохион байгуулж, үүрэг даалгаврыг өгсөн. Баянзүрх дүүргийн хэмжээнд Баянзүрх дүүргийн хэмжээнд 2023 оны эхний 10 сарын байдлаар Товлолт дархлаажуулалтын хамралт 96.1%, Тавт вакцины 3 дахь тунгийн хамралт 98%, Улаанбурхан-Гахайнхавдар-Улаануудын /УГУ/ эсрэг вакцины 2 дахь тунгийн хамралтын хувь 95.9%,



Дархлаажуулалтын үндэсний өдрүүдэд зориулж “Улаанбурхан өвчнөөс хамтдаа сэргийлье, нэмэлт дархлаажуулалт” сэдэвтэй анонсуудыг салбаруудад байршуулж, харьяа ӨЭМТ-үүд нэмэлт дархлаажуулалтын анонсийг хэвлүүлж байршуулсан. Дэлхийн Дархлаажуулалтын 7 хоног” болон “Дархлаажуулалтын 10 хоног” 4 болон 5-р сарын сүүлийн 7 хоногт зохион байгуулагддаг бөгөөд Цахимаар “Дархлаажуулалтын ач холбогдлын талаар цуврал хичээл”-ийг 1998 хүнд хүргэсэн.

Баянзүрх дүүргийн харьяа өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй хамтран Хүүхдийг дархлаажуулалтад хэрхэн хамруулах талаар мэдээлэл 6000, Дархлаажуулалтын дараа анхаарах асуудлын талаар зөвлөмж мэдээлэл 1635, Дархлаажуулалтын дараах зөвлөмж мэдээлэл бүхий брошур сурталчилгааны материал 4021, Дархлаажуулалтын дараах урвал хүндрэлийн талаар зөвлөгөө, ганцаарчилсан сургалт 1300, Вакцинд хамрагдахыг зөвлөсөн зарлал мэдээллийг эмч, сувилагчаар дамжуулан 532 эцэг эхэд хүргэж ажилласан.

Томуугийн эсрэг дархлаажуулалтад зорилтот бүлгийн 26348 иргэнийг хамруулж хамралт 77.6% байна.




✓ **Эх хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, чанарыг сайжруулах зорилтын хүрээнд**

Эх, хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах арга хэмжээний хүрээнд Дүүргийн хэмжээнд нийт 49857 жирэмсэн хяналтад орсноос 2023 оны 10 сарын байдлаар дүүргийн эрүүл мэндийн төвд 5121 нь өрхийн эрүүл мэндийн төвд 359 жирэмсэн хяналтад байна. Шинээр 3080 жирэмсэн хяналтад орсон. Эрт үеийн жирэмсний хяналтад 2736 эмэгтэй (90.5%), хожуу үеийн жирэмсний хяналтад 344 эмэгтэй (9,5%) орсон байна.

Эх, нярайд үзүүлэх тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор нийт 36 өрхийн эрүүл мэндийн жирэмсний хяналтын үзлэг, 2 тосгоны эмнэлгийн жирэмсний хяналтын үзлэг, тусламж үйлчилгээг амбулаториор болон Дарь-эх нэгдсэн эмнэлгээр үзүүлж байна.

Жирэмсний хяналтыг сайжруулахаар амгалан амаржих газрын төрөлжсөн нарийн мэргэжлийн зөвлөх эмчтэй хамтран өндөр эрсдэлтэй 147 жирэмсэн эмэгтэйчүүдийг үзэж цаашид гарах эрсдэлийг тооцон ажиллаж байна. Баянзүрх дүүргийн нэгдсэн эмнэлэгт бөөр шээсний замын үрэвсэл дотрын оноштой 25 жирэмсэн эхчүүдийг цаг алдалгүй гараас гарт хүргэн хэвтэн эмчлүүлж хамтран ажиллаж байна. **хэрэгжилт 99%,**

✓ Төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагуудтай хамтран хүүхдийн сэргийлж болох эндэгдлийг бууруулах ажлыг зохион байгуулах арга хэмжээний хүрээнд 2023 оны эхний 10 сарын байдлаар 0-1 насны эндэгдэл насны хүүхдийн эндэгдэл 72 тохиолдол, /1000 амьд төрөлтөд/ буюу 12 промилль өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.2 промилль өссөн, УБ дунджаас 1.3 промилль өссөн. 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 5 тохиолдол буюу 0.8 промилль өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.7 промилль буурсан, УБ дунджаас 0.5 промилль буурсан. Эндэгдлийг бууруулах зорилгоор дараах ажлуудыг хийсэн. Үүнд: Хүүхдийн эмнэлгийн бус эндэгдлийн шалтгаан, үр дагаварыг дүгнэх, дахин давтагдахаас сэргийлэх, эрсдэлт нөхцөл байдлыг дүгнэх, холбогдох эмч нарын үйл ажиллагаа, үүрэг, хариуцлага, харилцаа, хандлага, эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар аюулгүй байдлын үр дүнг дээшлүүлэх зорилгоор жилийн эцсийн байдлаар 6 тохиолдол гарсан. Үүнээс магадлан хэлэлцэх хуралд 2 тохиолдлыг хэлэлцсэн. Мөн амьгүй төрөлтийн 6 тохиолдлыг хэлэлцэж, хурлаас гарсан зөвлөмжийн дагуу эрсдэлт бүлгийн нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүд болон архины хамааралтай эмэгтэйчүүдийн судалгаа шинэчлэн гаргаж,





жирэмсэнээс хамгаалах аргад хамралт сайжирсан байна. Үүний үр дүнд 10 дугаар сарын байдлаар 1-5 хүртэлх хүүхдийн эндэгдэл буурсан. **хэрэгжилт 100%**,

✓ **Гэр бүлийн гишүүн бүрд эрүүл мэндийн мэдлэг, боловсрол олгох ажлыг шат дараатай хийх зорилтын хүрээнд**

Эрүүл мэндийн сайдын А/274 тоот тушаал, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын 2023 оны 01 дугаар сарын 20-ний өдрийн А/10 тоот тушаалын хоёрдугаар хавсралт, Эрүүл мэндийн төвийн даргын 2023 оны 02 дугаар сарын 13-ний өдрийн А/15 тушаалын дагуу иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох мэдээлэл, сургалт, сурталчилгааг зохион байгуулан ажиллах ажлын хүрээнд иргэдэд эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн мэдээлэл, сургалт, сурталчилгааг танхимаар болон цахим хэлбэрээр тогтмол зохион байгуулан ажиллаж байна. 2023 оны 11 сарын байдлаар 250 төрийн болон төрийн бус аж ахуй нэгж байгууллагатай хамтран болон 43 өрхийн эрүүл мэндийн төвүүдээр дамжуулан 850 удаагийн сургалтаар 42800 иргэнийг хамруулж, 94 удаагийн өдөрлөгөөр 11579 хүнийг, цахимаар 2664 төрлийн мэдээллийг 185400 хүнд, 480 төрлийн мэдээлэл зөвлөмж, зөвлөгөө боловсруулан 38500 хүнд хүргэж, нийт 278279 иргэнийг эрүүл аж төрөх, зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн мэдээлэл, сургалт сурталчилгаанд хамруулсан.



Өсвөр насны хүүхдүүдийн урьдчилан сэргийлэх үзлэгийг сайжруулж, эрүүлжүүлэх арга хэмжээний хүрээнд Баянзүрх дүүргийн өсвөр насны 183253 хүүхэдтэй үүнээс 2423 хүүхэд хамрагдахаас 2023 оны эхний 4 сарын байдлаар 2163 өсвөр насны хүүхдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсанаас 1082 хүүхдээс өвчлөл илэрч, 1081 хүүхэд буюу 99 хувийг эрүүлжүүлсэн байна. Үүнд: Монголын хүүхдийн сан, Шинэ найдвар асрамжийн төв, Гэрэл асрамжийн төв, Домбоска 4 асрамж халамжийн төв болон албан бус сургалтын 122 өсвөр насны хүүхэд Төвийн харьяа 2, 5, 17, 25, 26 хорооны Өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй хамтарч 6 ерөнхий боловсролын сургуулийн 6-10 дугаар ангийн хүүхдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан. 9-10 сард Өсвөр насны хүүхдүүдийн урьдчилан сэргийлэх үзлэгийг ерөнхий боловсролын сургуулиудаар хийхээр төлөвлөсөн. **хэрэгжилт 46%**,



эмэгтэйчүүдэд "жирэмслэхээс сэргийлэх арга хэрэгсэл", "Гэр бүл төлөвлөлт" чиглэлээр нийтдээ 61 сургалтад 2719 эмэгтэйчүүдийг хамруулсан. **Хэрэгжилт 64%,**



✓ Жил бүр шат дараатайгаар 1-2 дүүргийн Эрүүл мэндийн төвд эрэгтэйчүүдийн кабинет байгуулах арга хэмжээний хүрээнд Салбар амбулатори 1-д Эрэгтэйчүүдийн их эмчийн мэргэжил эзэмшсэн, ажлын туршлагатай эмчийг ажилд авч эрэгтэйчүүдийн кабинетийг 2022 оны 10 сард байгуулсан. Тус кабинетэд өөрийн хөрөнгөөр нийт 11 нэр төрлийн (ЭХО, Эр эс тоологч тор, Эс тоологч тоолуур, ширээ 1 ширхэг, сандал 1 ширхэг, ор 1 ширхэг, жин, сахрын тест, Центрифуг, Яаралтайн шкаф 1, Орхиметр) тоног төхөөрөмж, 4 нэр төрлийн тавилга эд хогшилыг 2023 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр "Ашидбуян" ХХК-иас нийлүүлсэн. Тусламж үйлчилгээний шинэ төрлийг нэвтрүүлж, кабинетын үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. 11 сарын байдлаар эрэгтэйчүүдийн кабинетаар 1485 иргэд үйлчлүүлсэн байна. **хэрэгжилт 100%,**


✓ Эрүүл мэндийн дэмжих төвийг 8 дүүрэгт байгуулах арга хэмжээний хүрээнд Зөвлөх Поликлиникт "Эрүүл мэндийг дэмжих төв"-ийг нэг урсгалтайгаар зохион байгуулж, засварын ажил бүрэн дуусаж 2022.05.01-ний өдөр ашиглалтад орж, үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. **хэрэгжилт 100%,**

✓ 2021 оны 05 дугаар сарын 25-ны өдөр Төрийн худалдан авах ажиллагааны газраас түлхүүр гардуулах нөхцөлтэй "Нийгмийн эрүүл мэндийн төвийн барилга"-ийн тендерийг зарлаж, 2,159.0 сая төгрөгөөр гүйцэтгэхээр "Шилдээд" ХХК шалгарч, 2021 оны 7 сарын 23-нд захиалагч Эрүүл мэндийн яамтай гэрээ байгуулсан. Газар чөлөөлөх хуучин сүрьеэгийн диспансерын барилгыг 2022 оны 8 сарын 19-нд нурааж дууссан. Сантехникийн шугам сүлжээ татахад 69-р сургууль, 115-р цэцэрлэгээс зөвшөөрөл авч, гадна дулаан, цахилгаан, бетон каркас цутгалтын ажил хийгдсэн бөгөөд 11 сарын 10-ны өдрийн байдлаар дулаан авах хүсэлтийг холбогдох байгууллагад өгч, дотор будгын ажил хийгдэж, тааз хийгдэж, ажлын гүйцэтгэл 90 хувьтай үргэлжилж байна. Барилгын ажлыг 2023 оны 12 сард дуусгаж, ашиглалтад оруулахаар төлөвлөгөөтэй ажиллаж байна. **хэрэгжилт 90%,**

✓ **Эмнэлгийн мэргэжилтнийг мэргэшүүлж, чадавхжуулан, нийгмийн баталгааг хангах зорилтын хүрээнд** Эрүүл мэндийн ажилтны ур чадвараа тасралтгүй хөгжүүлэх боломжийг нэмэгдүүлж, гадаад харилцааг хөгжүүлэх арга хэмжээний хүрээнд нийт 18 ажилтныг Дотоодын Үндсэн болон төрөлжсөн мэргэжлийн сургалтанд хамруулсан. Үүнд: Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын мэргэжил олгох сургалт, Цацрагийн аюулгүй байдал, Хөдөлмөрийн эрүүл мэнд, Өөрчлөлтийн удирдлага, манлайлал, ДОХ/Серологийн лаборант, Чих хамар хоолойн сувилахуй, Дурангийн сувилахуйн мэргэжил олгох, Эрүүл мэндийн удирдлага, зохион байгуулалт, Хүүхдийн чих хамар хоолой, Талбарын тархвар судлал, Мэдрэл булчингийн цахилгаан бичлэг, Мазокын шинжилгээний сургалт

/ажлын байрны шавилан сургалт/, Хэвлийн ЭХО баримжаа олгох, Худалдан авах ажиллагааны АЗ сертификатын сургалтанд нийт 18 ажилтныг хамруулсан. 2023 онд дээд газар болон холбогдох бусад байгууллагаас зохион байгуулсан 96 сургалт, семинар, уулзалт, зөвлөгөөнд эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнуудаа оролцуулсан. 65 дотоодын сургалтыг сургалтын төлөвлөгөөний дагуу нэгж бүр дотооддоо хийсэн байна.


Гадаадын сургалтанд нийт 12 эмч, эмнэлгийн мэргэжилтэнг сургасан. Үүнд: Япон улсад захиргааны 3 мэргэжилтнийг Эмийн экспо, эмнэлгийн тоног төхөөрөмжийн үзэсгэлэнд, Япон улсын Хоккайдо мужийн Отару дүүргийн “SUSSON SUGATA” клиник эмнэлгийн 3 салбар эмнэлэг болох Төв салбар, Ахмадын сэргээн засах төв, Хүүхдийн сэргээн засах төв болон тус дүүргийн Бие бялдар сэргээн засах төвд тус тус танилцах дадлагад 2 эмч, ЭМЯ, ЭМХТ-өөс зохион байгуулж буй БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх хотод Олон улсын Монгол эмнэлгийн хороотой хамтарсан сувилагчийн ур чадвар дээшлүүлэх сургалтанд 1 сувилагч, Баянзүрх дүүргийн ИТХ-ын дарга болон Дүүргийн төлөөлөгчид Эрүүл мэндийн төвийн дарга, Чанарын албаны дарга, Сэргээн засах эмчилгээний эмч, Уламжлалт эмчилгээний эмч нар БНСУ-ын “ИНЧОН БЕК” эмнэлгийн хамтын ажиллагааны хүрээнд эмнэлэг, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, шинэ дэвшилтэт технологи, тусламж үйлчилгээний арга барилын талаар туршлага судалсан. ОХУ-ын Эрүүлийг хамгаалах яамнаас Ази, Африк, Латин, Америкийн улс орнуудад зориулж эх, нярай, бага насны хүүхдийн өвчлөл эндэгдлийг бууруулах Тогтвортой хөгжлийн зорилтын хүрээнд эмч нарыг чадваржуулах сургалтанд Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга, Хүүхдийн эмч оролцуулсан. **хэрэгжилт 100%,**





✓ Хүний нөөцийн тогтвортой ажиллах боломжийг бүрдүүлэх нийгмийн хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд Эх барих эмэгтэйчүүд, хүүхэд, өсвөр үе, сүрьеэгийн кабинетын хэвийн бус нөхцлийн нөхцлийн болон сүрьеэгийн кабинетын нэмэгдлийг 46 эмч, эмнэлгийн мэргэжилтэнд сар бүр 10 болон 30 хувиар тогтмол олгосон. Засгийн газрын 2019 оны 05, 395 дугаар тогтоолын дагуу эмч, ажиллагсдын 2023 оны 1, 2, 3-р улирлын ажлын гүйцэтгэлийг үнэлж үнэлгээгээр 352 ажилтанд 693,947,345 төгрөгийн урамшуулал олгосон. Эрүүл мэндийн төвийн даргын 2023 оны Б/37 дугаар тушаалаар ТҮЭМ, ТҮ зэрэглэлийн эмч, ажилтнуудын үндсэн цалинг 100,000 төгрөгөөр 2023.01.02-ноос нэмэгдүүлсэн. Гэмтэл, мэс заслын эмч сувилагч, чанарын багийн гишүүд, Ахлах сувилагч, Халдварын сэргийлэлт хяналтын багийн гишүүд, эд хөрөнгө хариуцдаг ажилтнуудад сар бүр 5-10 хувийн нэмэгдлийг 2023.02.01-нээс олгож эхэлсэн. Засгийн газрын 2022 оны 491 дүгээр тогтоолоор 2023.01.01-нээс төрийн алба хаасан жил тутамд нэмэгдэл олгохоор заасантай холбоотойгоор бүх ажилтны ажилласан жил тулгалт, өмнө ажиллаж байсан төрийн байгууллагын мэдээллийн тулгалтыг Төрийн албаны зөвлөлийн Хүний нөөцийн програмд хийснээр 2023.01.01-нээс нийт 332 ажилтанд 1-25 хувиар төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг олгосон. Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолоор ТҮЭМ, ТҮ зэрэглэлийн цалингийн доод хэмжээг 2023.07.01-нээс шинэчлэн батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн төвийн даргын 2023 оны А/71 дүгээр тушаалаар нийт ажилчдын цалинг 2023.06.01-нээс үндсэн цалинг 300,000 төгрөгөөр нэмэгдүүлсэн. Энэхүү тушаалаар үндсэн цалингийн доод хэмжээ 1,289,855 төгрөг, дээд хэмжээ 1,664,899 төгрөг болсон байна. Дотоод журам, ҮЭХ-той байгуулсан Хамтын гэрээнд заасны дагуу 13 дахь сарын цалинг нийт ажилчдад 12 дугаар сарын 10-ны өдөр өгөхөөр төлөвлөсөн. Ойр дотны хүн нь нас барсан 17 ажилтанд 3,400,000 төгрөгийн тэтгэмжийг ҮЭХ-той байгуулсан Хамтын гэрээнд заасны дагуу зохих зардлаас олгосон. Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр тендер зохион байгуулж, Сангийн сайдын 2019 оны 132 дугаар тушаалаар батлагдсан “Тендер шалгаруулалтын материалыг тухайн тендерт оролцогчдод ил болгох журам”-ыг үйл ажиллагаандаа баримтлан Зөөлөн эдлэл нормын хувцасны БЗДЭМТ/202301003 дугаартай худалдан авах ажиллагаагаар “Шандмин”ХХК, “Алго”ХХК, Эм Ти Эм Жи ХХК зэрэг байгууллагатай гэрээ байгуулан ажилчдад мэс заслын өмд, цамц, малгай 400 ширхэг, өвлийн дотортой ажлын өмд,

цамц 20 ширхэг бараа бүтээгдэхүүнийг худалдан авсан. Баянзүрх дүүргийн Засаг даргын тамгын газраас 1 сувилагч, 1 үйлчилгээний ажилтанд тус бүр 30 сая төгрөгийн орон сууцны урьдчилгаа олгож дэмжлэг үзүүлсэн. Эмч нарын баяраар Баянзүрх дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албанаас Дүүргийн Эрүүл мэндийн төвийн болон Өрхийн Эрүүл мэндийн төвийн эмч нарт зориулсан баярын цэнгүүн 2023 оны 3 сард зохион байгуулж, 1 хүүхдийн эмчид орон сууцны урьдчилгаа 25 сая төгрөг олгосон. Худалдаа хөгжлийн банк, Эрүүл мэндийн сайдтай байгуулсан гэрээний дагуу 6 эмч, эмнэлгийн мэргэжилтэн орон сууцны ипотекийн зээлд хамрагдаж орон сууцандаа орсон. Гэр хороололд түлш хэрэглэдэг ажилтнууд болох 90 хүнд 9,000,000 төгрөгийн түлшний мөнгөн дэмжлэг 2023 оны 11-р сард үзүүлсэн. 2023 оны 3 дугаар сард Хөвсгөл аймагт болсон “Мөсний баяр-2023” арга хэмжээнд мөсний баярын эрхээр шагнуулсан 12 ажилтныг байгууллагын зардлаар оролцуулсан. 2023 оны 7 дугаар сард 11 ажилтныг Булган, Архангай аймгийн нутгаар Дотоодын аялалд явуулсан. **Хэрэгжилт 100%,**



✓ Эрүүл мэндийн ажилтны эрүүл, аюулгүй шаардлага хангасан орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлж, эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээний хүрээнд Баянзүрх дүүргийн эрүүл мэндийн салбар 1, 2, Дарь эхийн нэгдсэн эмнэлэг, поликлиник зэрэг 4 эмнэлгийн нийт 26 ажлын байрыг хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээнд хамруулсан. Эдгээр ажлын байранд нийт 32 ажилтныг төлөөлүүлэн 28 ажилтныг АШУУИС-ийн НЭМС-ийн Хөдөлмөр орчны эрүүл ахуйн лабораторитой хамтран хөдөлмөрийн нөхцөлийн хэмжилтэд хамруулсан. Үнэлгээ дараах байдалтай гарсан. Үүнд: Хэмжилт, шинжилгээний дүнд үндэслэн MNS 5080:2001 стандартын дагуу хөдөлмөрийн нөхцөлийг үнэлэхэд бүх ажлын байр /26/ ажлын

байрууд хэвийн ангилалтай байна. Ажлын байранд гэрэлтүүлгийн хэмжилтийн дүнг харахад зарим хэмжилтийн үр дүн зөвшөөрөх хэмжээнд хүрээгүй. Ажилтнуудын нийт тоосны өртөлтийн түвшинг тодорхойлсон дүнгээс харахад ЗДХ-ээс хэтэрсэн хэмжилт тодорхойлогдоогүй боловч зарим хэмжилтийн дүн ЗДХ-ний утгын 50-100%-тай тэнцэж байна. Шуугианы хэмжилтээр ажилтнуудын өртөлтийн төвшинг тодорхойлсон дүнгээс харахад ЗДХ-ээс хэтэрсэн хэмжилт тодорхойлогдоогүй боловч зарим слесарь, мужаан зэрэг ажлын байрны шуугианы өртөлт 82.9-84.9 дБА байгаа нь Ажлын байран дахь шуугианы өртөлтийн хэмжилт, стандартад заасан хэмжээнээс өндөр байна. Агааржуулалтын үнэлгээгээр нийт 25 өрөө тасалгаанд хийснээс ихэнх өрөөний агааржуулалтын систем хүрэлцээгүй буюу БНБД 44-04-21-д заасан сэлгэх давтамж 2 удаа / цагт шаардлагыг хангахгүй байна. Эмч, эмнэлгийн эрсдэлтэй ажлын байрнд ажиллаж байгаа ажилнуудад бугуйн хамгаалалт оёж 50ш ажилтанд тараасан. Шуугианы эрсдэл өндөр ажилтангуудад Үйлдвэрчний эвлэлтэй хамтран 50 ажилтанд 3М шуугиан бууруулалттай чихэвч тараасан. **хэрэгжилт 100%,**

• **Хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж, эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд**

✓ Хүн амд үзүүлэх нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх арга хэмжээний хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үйлчлэх хүртгээмжийг нэмэгдүүлэх зорилгоор эмч, сувилагч, ажилтнуудад дохионы хэлний мэдлэг олгохоор сургагч багш бэлтгэх сургалт зохион байгуулж, 5 ажилтанг бэлтгэж байна.



✓ 2023 оны 03 сарын 30-ны өдрөөс эхлэн ясны сийрэгжилтийг тодорхойлж эхэлсэн. Баянзүрх дүүрэгт нийт 47847 ахмад настан бүртгэлтэй байгаагаас Эрүүл мэндийн төвийн ахмадын кабинетаар 20317 болон өрхийн эрүүл мэндийн төвүүдээр давхардсан тоогоор 325666 ахмад настан үйлчлүүлсэн байна. Үүнээс 28710 буюу 60 хувийг ясны сийрэгжилт тодорхойлох шинжилгээнд хамруулаад байна.



✓ TORCH-ийн цочмог халдвар илрүүлэх, Эрт үеийн ургийн гажигаас урьдчилан сэргийлэх зорилгоор 2023 оны 1 сараас эхлэн жирэмсэн эхчүүдэд TORCH вирусын халдвар илрүүлэх шинжилгээг жирэмсэний хяналтанд 5121 жирэмсэн орсоноос 671 жирэмсэнг шинжилгээнд хамруулсан.



✓ Ходоодны хавдраас урьдчилан сэргийлэх зорилгоор өтгөний хеликобактери илрүүлэх шинжилгээг 2023 оны 1 сараас шинээр хийж, 2023 онд шинээр нэвтрүүлж, 11 сарын байдлаар нийт 865 хүнд шинжилгээ хийсэн.

✓ Бэлгийн замаар дамжих халдварын үндсэн 7 үүсгэгч илрүүлэх шинжилгээг 02 сарын 06-ны өдрөөс эхлэн хийж, 10 сарын байдлаар 1000 хүнд шинжилгээ хийсэн.

✓ “Энэ жилдээ-Эрүүл жиндээ” аяны хүрээнд Баянзүрх дүүргийг үндэсний хэмжээнд ТҮМЭН дасгалыг сурталчлагч загвар дүүрэг болгох зорилгоор идэвхитэй хөдөлгөөн, чийрэгжүүлэлтийн ТҮМЭН дасгалын сургагч багш бэлтгэх, мэргэжил аргазүйн сургалтыг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Баянзүрх дүүргийн Биеийн тамир спортын хороотой хамтран амжилттай зохион байгуулсан. Сургалтад Баянзүрх дүүргийн Ерөнхий боловсролын 34 сургууль Сургуулийн өмнөх боловсролын 52, Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн 28 эрүүл мэндийн нийгмийн ажилтан хороодын хэсгийн ахлагч нийт 700 гаруй сургагч багшийг бэлдсэн. Эдгээр сургагч багш нар Ерөнхий боловсролын 34 сургуулийн 4200 албан хаагч, Сургуулийн өмнөх боловсролын 52 цэцэрлэгийн 2400, 28 Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн 576, Эрүүл мэндийн төвийн 350 нийт 7526 ажилтан, албан хаагч нарт ТҮМЭН дасгалыг зааж сургаж, ажлын байран дээрээ хийж хэвшүүлсэн

байна. Үүний үр дүнд Баянзүрх дүүрэг нь ТҮМЭН дасгал нь загвар дүүрэг болж, 05 сарын 27-нд ажлын байран дээрхи дасгал хөдөлгөөнийг идэвхижүүлэх, ач холбогдлыг таниулах, хүн бүр хийж хэвшүүлэх нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж, 1000 ажилтан албан хаагчдыг хамруулсан үзүүлэх тоглолтыг зохион байгуулсан. **хэрэгжилт 100%**,



✓ Стандартын шаардлага хангасан байртай өрхийн эрүүл мэндийн төвийн тоог нэмэгдүүлж, үйлчилгээний хүртээмж, хүчин чадлыг нэмэгдүүлэх арга хэмжээний хүрээнд Баянзүрх дүүргийн 16-р хороо буюу “Насан урт” ӨЭМТ нь стандартын шаардлага хангасан байранд үйл ажиллагаагаа явуулдаг. **хэрэгжилт 100%**,



✓ Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудыг эмнэлгийн тусламж, үйлчилгээнд нэн шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, автомашинаар шат дараалан хангаж, шинэчлэх арга хэмжээний хүрээнд Салбар амбулатори 1-ийн эмэгтэйчүүдийн кабинетэд Шинжьюкү ХХК-иас 279,564,000 төгрөгийн үнэтэй ургын гажиг тодорхойлох суурин эхо аппаратыг 2023 оны 04 дүгээр сарын

06-ны өдөр, эрэгтэйчүүдийн кабинетэд Ашидбуян ХХК-иас 50,183,694 төгрөгийн үнэтэй зөөврийн ЭХО аппаратыг 2023 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр, Сүвэн уул ХХК-иас нийлүүлсэн 2 ширхэг суурин даралтын аппаратыг поликлиникийн эмэгтэйчүүдийн кабинетад 1 ширхэг, салбар амбулатори 1-ийн дотрын кабинетэд 1 ширхэг, Сүвэн уул ХХК-иас нийлүүлсэн 2 ширхэг суурин инфра улаан гэрлийн аппаратыг салбар амбулатори 2 болон салбар амбулатори 1-ийн уламжлалтын кабинетад, СИ АЙ ТИ компаниас нийлүүлсэн 1 ширхэг ходоодны дурангын хошууг салбар амбулатори 1-ийн дурангын кабинетад, Сүвэн уул ХХК-иас нийлүүлсэн 2 ширхэг биохимийн ус цэвэршүүлэгч аппаратыг поликлиник болон дарь эх нэгдсэн эмнэлгийн лабораторийн биохимийн аппаратад холбон суурилуулж тус тус өөрийн хөрөнгөөр нийлүүлсэн. **хэрэгжилт 100%**

✓ Баянзүрх дүүрэгт төрийн өмчийн нэгдсэн эмнэлэг байгуулах ажлын хүрээнд 2022 оны 3 дугаар улиралд тус эмнэлгийн барилгыг барих байршлын судалгааг гаргаж, 34 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 3 га газрыг шийдвэрлэсэн боловч 300 ортой эмнэлгийг барихад нийт 15000 га газар шаардлагатай тул газрын асуудлыг Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газар бүрэн шийдвэрлэж чадаагүй. Эрүүл мэндийн төв нь өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлох, шинээр эмнэлэг байгуулахад санхүүгийн боломж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийж, эмнэлэг тусламж, үйлчилгээний ямар чиглэлд ажиллах талаар Эдийн засагчдын холбоогоор судалгаа, төлөвлөлт хийлгэж, 300 ортой эмнэлгийн дотоод зохион байгуулалтын зураг төслийг мэргэжлийн байгууллагаар гаргуулсан, шаардлагатай тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, аж ахуйн тооцооллыг гаргаж, Баянзүрх дүүргээс сонгогдсон Улсын Их хурлын 5 гишүүдэд танилцуулж, шаардлагатай санхүүжилтийг 2024 оны төсөвт тусгуулахаар хүргүүлэн ажилласан. Монгол улсын 2021 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар баталсан “Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт”-ын “XIX.1.1”-д тусгагдсан “Ахмад настан, хүүхдийн эмнэлэг”-ийн (Баянзүрх дүүргийн 8-р хороо) барилга нь 7 давхар хүртэл баригдаж, гадна болон дотоод засал хийгдэж дууссан бөгөөд барилгын явцтай 3 удаа очиж хяналт хийж, Нэгдсэн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа MNS5095:2017 стандартын шаардлага хангуулах саналыг өгч хийлгүүлсэнээр барилгын явц 80 хувьтай байна. Ахмад настан, хүүхдийн эмнэлэг (200 ортой) ашиглалтанд ороход гадна цахилгааны узелийн төсвийг 2024 оны төсөвт суулгуулсан бөгөөд уэль байрлуулах газрыг чөлөөлөх талаар холбогдогдох байгууллагууд ажиллаж байна. Тус эмнэлэг 2024 оны 6 сард ашиглалтанд орох төлөвлөлттэй байна. **хэрэгжилт 50%**



✓ Иргэдэд анхан шатны тусламж үйлчилгээг тэгш, хүртээмжтэй хүргэх, өрхийн эмнэлгийн чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор хууль тогтоомжийн хүрээнд Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн хагас жилийн гүйцэтгэлийн үнэлгээ 2023 оны 6 сард хийж, 88.2% буюу 2% ахицтай үнэлгээ хийгдсэн. Үнэлгээний нэгтгэлийг Нийслэлийн Эрүүл мэндийн газарт журмын дагуу бүрдүүлж хүргүүлсэн. Жилийн эцсийн үнэлгээг 12 сард хийгдэнэ. **хэрэгжилт 50%-тай** байна.

1.5. Нийслэлийн Засаг даргын захирамж, албан даалгаврын хэрэгжилт

- Нийслэлийн Засаг даргын 2022.08.15 өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” А/1049 захирамж Нийслэлийн байгууллагуудын дотоод удирдлагын UB ERP систем дэх өргөдөл гомдлын дэд системээр иргэд байгууллагаас ирүүлсэн өргөдөл гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх, мэдээ тайланг гаргаж ажиллах, журмыг хэрэгжүүлэх хүрээнд ЗГ-ын 11:11, 1800-1200 тусгай дугаар, Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв, мөн бичгээр иргэд байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг хүлээн авч байна. Байгууллагад нийт 279 өргөдөл ирсэнээс шийдвэрлэгдсэн 276 үүнээс талархал 106 (38,5%), гомдол 144 (52,1%), санал хүсэлт 17 (6,15%)-тай байна. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 3 хоног байгаа ба 5 хоногт багтаан шийдвэрлэсэн өргөдөл 78.4%-ийг эзэлж байна. Өргөдөл гомдлын хандалтаар харахад Өрхийн эрүүл мэндийн төвийн тусламж, үйлчилгээтэй холбоотой 32,17%, эрүүл мэндийн салбарын үйл ажиллагааны тухай 30,77%, 2 дахь шатлалын эрүүл мэндийн байгууллагын тусламж үйлчилгээтэй холбоотой 30,77%, албан хаагчийн ёс зүй харилцаа хандлагатай холбоотой 2,80%, бусад 3,49% -ийг тус тус эзэлж байна. Өргөдөл гомдлыг бууруулах чиглэлээр салбар амбулатори дээр байгаа лавлагааны утаснуудыг хэвийн ажиллагааг шалгаж, зарим салбар амбулаторийн лавлагааны утсыг хэвийн ажиллагаатай болгож, 24 цагаар нэг дугаарыг ажиллуулж байна. Өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй өргөдөл гомдлыг бууруулах чиглэлээр уулзалт, хэлэлцүүлэг хийж, “Харилцаа хандлага” сайжруулах 1 сарын аян зарласан. Аяны хүрээнд талархалын тоог нэмэгдүүлэх, гомдлын тоог бууруулахаар ажиллаж байна.

- Нийслэлийн Засаг даргын 2023.02.07 өдрийн “Албан хэрэг хөтлөлтийн eDoc систем ашиглах журам батлах тухай А/111 захирамж аар Байгууллагын “Албан хэрэг хөтлөлтийн цахим Edoc систем” ашигладаг мэдээ, тайлан гаргадаг захиргааны нийт 32 албан хаагч нарт системийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх, албан хэрэг хөтлөлтийн стандарт, архивын баримтыг зохих зааврын дагуу хадгаламжийн нэгж бүрдүүлж байгууллагын архивт хүлээлгэн өгөх сургалтыг 2023 оны 05 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулсан. Цаашид байгууллагаас явуулах бүх албан бичгийг албан хаагч нар цахим системээр боловсруулж хэвшүүлэх, ирсэн бичгийн шийдвэрлэлт болон системд бүртгэгдсэн зөрчлийг бууруулах тал дээр анхаарч арга зүйн өдөр дутамдаа өгч ажиллаж байна.



- Нийслэлийн Засаг даргын 2023.03.10 өдрийн “Стратегийн команд штабын сургууль зохион байгуулах тухай” А/194 захирамжаар Гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг гамшгийн эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах, төлөвлөх, гамшгаас хамгаалах мэдлэг, дадлага, чадвар олгох чиглэлээр ЭМТ-ын даргын А/22 тоот тушаалын дагуу 26 ӨЭМТ, 2 ТЭМТ-үүдийг хамруулан 5 чиглэлээр дадлага сургалтыг амжилттай зохион байгуулсан. Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө болон холбогдох хууль тогтоомж дээр үндэслэж салбар нэгжийн эмч, эмнэлгийн ажилчдыг дайчлан 6 бүлэг болгож Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2020 оны А/303 тоот захирамжийг үндэслэн Хээрийн эмнэлгийн бэлэн байдал, нөөц хангалтыг төлөвлөн ажиллаж байна. Хээрийн эмнэлгийн бэлэн байдлыг хангах үүднээс Удирдлага зохион байгуулалт, ар тал хангалтын бүлэг-22, Халдвар эсэргүүцэх бүлэг-13, Гэмтэл, мэс заслын бүлэг-8, Цацрагийн хордлогын яаралтай тусламжийн бүлэг-16, Цус сэлбэх бүлэг-12, Эрэмбэлэн ялгах, яаралтай тусламжийн бүлэг-17 тус бүр байгуулж үйл ажиллагаагаа төлөвлөж байна. Нийт хүний нөөц 88, машин тоо 4, асар 3. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах талаар эмч, эмнэлгийн мэргэжилтэний мэдлэгийг дээшлүүлж, эрсдэлээс сэргийлэх зорилгоор: Боом, Галзуу өвчний үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээ бэлэн байдлыг хангах талаар Үзүүлэх сургалтыг 5 өртөөгөөр зохион байгуулж 60 гаран хүн хамруулсан. Газар хөдлөлтийн үеийн бэлэн байдлыг хангах команд штабын дадлага, сургууль, бэлэн байдлын хангах үзүүлэх сургуулалтийг 6, 15, 18, 25, 26-р ӨЭМТ-үүдтэй хамтран зохион байгууллаа. Тарваган тахал өвчний үеийн бэлэн байдал хариу арга хэмжээ сэдэвт үзүүлэх сургалтыг батлагдсан хуваарийн дагуу Баянзүрх дүүргийн 21 дүгээр хорооны 127 дугаар сургуулийн Урлаг зааланд зохион байгуулж үзүүлэх сургалтыг “Тарваган тахал өвчний сэжигтэй тохиолдол илэрсэн үед авах арга хэмжээ” үзүүлэх тоглолт, Өрхийн эрүүл мэндийн

төвд “Тарваган тахал өвчний сэжигтэй тохиолдол илэрсэн үед авах арга хэмжээ” видео баримтат кино хэлбэрээр тус бүр зохион байгуулж үзүүлэх сургалтад Хорооны засаг дарга нар болон бусад ажилчид, Дүүргийн эрүүл мэндийн төвийн эмч мэргэжилтэн, Өрхийн эрүүл мэндийн төвийн эмч ажилчид зэрэг нийт 31 хүн хамрагдлаа. БЗДЭМТ-ийн даргын 2023 оны А/22 дугаар тушаалын дагуу өндөр хоруу чанартай шувууны томуугийн вирусээр үүсгэгдсэн хүний томуугийн өвчний үеийн тархалтын үеийн эрүүл мэндийн байгууллагын бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах чадавхийг анхан шатны эрүүл мэндийн байгууллагын нийт ажилдад олгох зорилгоор БЗД 9, 16, 17, 19, 24 –р хорооны ӨЭМТ-үүд хамтран тус үзүүлэх сургалтыг зохион байгуулав. “Ковид-19 халдварын үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээ” сэдэвт үзүүлэх сургалтыг 13-р хорооны ӨЭМТ-ийн иргэний танхимд зохион байгууллаа. Тус үзүүлэх сургалтыг БЗДЭМТ, 1, 3, 4, 5, 7, 13, 14-р хорооны өрхийн эрүүл мэндийн төвүүд хамтран 2 тохиолдлын кейс гарган түүн дээрээ ажиллаж зохион байгуулсан бөгөөд нийт 33 хүн хамрагдсан.



• Нийслэлийн Засаг даргын 2023.04.12 өдрийн “Нийслэлийн гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийг шинэчлэн байгуулах тухай” А/358 захирамжаар Баянзүрх дүүргийн Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 13 ны өдрийн “Ажлын хэсгийг шинэчлэн байгуулах тухай” А/223 дугаар, “Гамшгаас хамгаалах сургуулийн ослын үеийн удирдлагын системийн тогтолцоонд шилжин ажиллах үед үүрэг гүйцэтгэх бүрэлдэхүүнийг томилох тухай” А/224 захирамжийн дагуу 2023 оны 06 сарын 7, 8, 9-ний өдөр болох үзүүлэх сургуулилтын бэлэн байдлыг хангах ажлын хүрээнд газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө болон холбогдох хууль тогтоомж дээр үндэслэж салбар нэгжийн эмч, эмнэлгийн ажилчдыг дайчлан ажиллах 6 бүлэг болгон бэлэн байдлыг хангасан. Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2020 оны А/303 тоот захирамжийг үндэслэн Хээрийн эмнэлгийн бэлэн байдал, нөөц хангалтыг төлөвлөн ажиллаж байна. Хээрийн эмнэлгийн бэлэн байдлыг хангах зорилгоор Удирдлага зохион байгуулалт, ар тал хангалтын бүлэг-22, Халдвар эсэргүүцэх бүлэг-13, Гэмтэл, мэс заслын бүлэг-8, Цацрагийн хордлогын яаралтай тусламжийн бүлэг-16, Цус сэлбэх бүлэг-12, Эрэмбэлэн ялгах, яаралтай тусламжийн бүлэг-17 тус бүр байгуулж үйл ажиллагаагаа төлөвлөж байна. Нийт хүний нөөц 88, машин тоо 4, асар 3. Гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг гамшгийн эрсдэлийг бууруулах,

бэлэн байдлыг хангах, төлөвлөх, гамшгаас хамгаалах мэдлэг, дадлага, чадвар олгох чиглэлээр төвийн даргын А/22 тоот тушаалын дагуу 26 Өрхийн эрүүл мэндийн төв, 2 Тосгоны эрүүл мэндийн төвүүдийг хамруулан 5 чиглэлээр дадлага сургалтыг зохион байгуулан ажилласан.

- Нийслэлийн Засаг даргын 2023.04.12 өдрийн “Цэргийн албаны ээлжит татлагыг зохон байгуулах тухай” А/371 захирамжаар 2023 оны 1 дүгээр ээлжийн цэрэг татлагаар 11804 цэргийн насны эрэгтэйчүүд хамрагдахаас эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан 861 залуусын 360 буюу 42% нь өвчнөөр улмаас тэнцээгүй байна.

1.6. Нийслэлийн Засаг даргаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт

Нийслэлийн удирдах ажилтнуудын 24 шуурхай хуралдаанаас 8 үүрэг даалгаврын хэрэгжилтийг ханган ажилласан.

1.7. Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх чиглэлээр хийсэн ажил, үр дүн

2023 оны жилийн эцсийн байдлаар өдрийн эмчилгээний өвчний түүхийг бүрэн цахимжуулсан. Мөн PACS сервер байрлуулж дүрс оношлогооны зургийг хэвлэхгүйгээр зургийн хариутай нь хамт эмч рүү эмнэлгийн e-health программаар шууд шийддэг болсон. Энэ нь байгууллагын төсөвт асар их хэмнэлт гаргахын зэрэгцээ үйлчлүүлэгч нарын чирэгдлийг багасгасан, мөн дүрс оношлогооны зургийг программаасаа шууд өндөр чанартай харснаар буруу оношлох эрсдэл байхгүй болсон.

Мөн үйлчлүүлэгчийн шинжилгээний хариу болон бусад мэдээллийг и-монголиа платформ болон и-клиник киоск машинаас шууд авах боломжийг бүрдүүлсэн нь үйлчлүүлэгч нарын чирэгдлийг 100% багасгасан.

The screenshot shows a medical information system interface. On the left, there is a sidebar with various menu items. The main area displays patient information, including name, date of birth, and gender. Below this, there are sections for 'Диагностика' (Diagnosis) and 'Тестийн үр дүн' (Test results). The 'Тестийн үр дүн' section shows a list of tests and their results, with some results highlighted in green. The interface is in Mongolian.

БЦЭМТ
Лаборатори
Шинжилгээний хариу

Эмнэлгийн хаяг: *Монгол улс, Улаанбаатар хот-13345, Баянзүрх дүүрэг, 7-р хороо, 15-р хороолол*
Утас: 70150056
Вэб: www.bccmt.mn.gov.mn

Эцэг/Эхийн нэр: _____ Нэр: _____ Нас: 26 Хүйс: эр

Регистрийн дугаар: _____ Тасаг: _____

Шинжилгээний үр дүн	Хяруу	Нэгж	Лавлах хэмжээ	Ажлааруулга
Илгээсэн Я.Оюунчимэг				
Баркод: 32413515	Сорын цус	Сорын үржлэг өгсөн	Харууны өсгөөс	2023-04-14 09:24
Тайлбар:	19.5	мдд/L	12.5-32.2	
Хийсэн: <i>Бат.Нандын-эрдэнэ</i>	Баталгаажуулсан	<i>Бат.Нандын-эрдэнэ</i>	2023-04-14 10:24	
Илгээсэн Я.Оюунчимэг				
Баркод: 32109460	Сорын цус	Сорын үржлэг өгсөн	Харууны өсгөөс	2023-01-09 15:07
Тайлбар:	12.8	мдд/L	30-100	
Хийсэн: <i>Б.Жамгалсайхан</i>	Баталгаажуулсан	<i>Бат.Нандын-эрдэнэ</i>	2023-01-09 15:17	
Илгээсэн Я.Оюунчимэг				
Баркод: 32413515	Сорын цус	Сорын үржлэг өгсөн	Харууны өсгөөс	2023-04-13 16:01
Тайлбар:	64.4	мдд/L	25-350	
Хийсэн: <i>Б.Жамгалсайхан</i>	Баталгаажуулсан	<i>Бат.Нандын-эрдэнэ</i>	2023-04-13 16:25	

Хувьсган: admin 2023/06/05 10:23

1.8. Тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр хийсэн ажил, үр дүн

ТЭР БУМ МОД үндэсний хөтөлбөр

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар “ТЭРБУМ МОД” үндэсний хөдөлгөөнийг зарласны хүрээнд БЗДЭМТ нь 2023 оны 05 сарын 23-ны өдөр БЗД-ийн 28-р хороонд байрлах “Эко цэцэрлэгт хүрээлэн”-д 300ш Хайлаас мод тарьсан.



2023 оны 10 дугаар сарын 17-ны өдөр Баянзүрх дүүргийн 32 дугаар хорооны Засаг дарга, Баянзүрх дүүргийн Татварын хэлтсийн 18 хүн, Эрүүл мэндийн төвийн 7 ажилтан, 32 дугаар хорооны хэсгийн ахлагч нарын хамт Баянзүрх дүүргийн 32



дугаар хорооны 2 айлд 11 мод суулгасан. Шар хуайс 36 ширхэг, улиас 6 ширхэгийг суулгав.

ИХ ЦЭВЭРЛЭГЭЭ

2023 оны 05 сарын 12-ны өдөр гадна талбай болон өрөө тасалгаанд их цэвэрлэгээг 11:30-13:00 цагийн хооронд хийж гүйцэтгэлээ. Нийтдээ 60 гаруй эмч ажилчид 4 салбар амбулаторийн гадна орчны эргэн тойрон, булан тохойн хог хаягдлын цэвэрлэж, хогийн сав, шатны бариул, сандлыг цэвэрлэж угаасан.



Баянзүрх дүүргийн засаг даргын 2023 оны 03 сарын 16-ны өдрийн А/147 дугаар захирамжийн дагуу Хаврын их цэвэрлэгээний сарын аянд Баянзүрх дүүргийн эрүүл мэндийн төвийн нийт 179 ажилтан 4 салбар амбулаторийн гадаах талбайг цэвэрлэж хаврын их цэвэрлэгээний аянд нэгдлээ.



2023 оны 10 дугаар сард 1 дүгээр гадна талбайд болон эмнэлгийн контейнэр болон агуулахад их цэвэрлэгээ хийж акталсан хөрөнгийг устгах, шилжүүлэх, борлуулах ажлыг 2023 оны 11 дүгээр сарын 7-ны өдөр хийж гүйцэтгэсэн.



БАЙГУУЛЛАГЫН ТОХИЖИЛТЫН АЖИЛ


Улаанбаатар хотын автозамын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооноос гаргасан Улаанбаатар хотын автозамын түгжрэлийг бууруулахад иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын санаачилга, оролцоог хангах талаар зөвлөмж ирүүлсэний дагуу төлөвлөгөө гаргаж, хэрэгжүүлж ажилласан. Салбар бүрт дугуйны зогсоолыг хийж байршуулсанаар урин дулаан цагт дугуйтай ирж үйлчлүүлэх үйлчлүүлэгчийн зогсоолыг шийдэж өгсөн.



Дарь-эх нэгдсэн эмнэлгийн үйлчлүүлэгчдэд ээлтэй орчин бүрдүүлэх зорилгоор өөрийн хөрөнгөөр 1 давхарт болон хэвтэн эмчлүүлэх тасагт хананы цаг байршуулав.



Дарь эх нэгдсэн эмнэлгийн гадна болон дотор нийт 11 камержуулалтыг хийсэн. Дарь эх нэгдсэн эмнэлгийн эмнэлгийн гэрэлт хаяг, дугуйны зогсоол, түргэний машины гэрэлт самбар, яаралтай тусламжийн гадна хаяг хийсэн.



Үйлчлүүлж буй хүүхдүүдэд зориулж хүүхдийн эмчийн өрөөний гадна буланд хүүхдийн хүлээлгийн булан тохижуулав.



Салбар амбулатори 1-д Энгийн хог ялган ангилах хогын савыг 2023 оны 10 сарын 15-нд байршуулсан. Хогын савтай болсоноор хог ангилан ялгах, хог гадуур халих зэрэг асуудалгүй болсон.



Дарь эх нэгдсэн эмнэлгийн хэвтэн тасагтай болсоны дагуу эмнэлгийн тохижилтыг хийж гүйцэтгэсэн. Дуугүй хөтөч, давхар бүрт толь, ус цэвэршүүлэгч, иргэдийн эрх үүргийн самбар, мэдээлэлийн ил тод байдлын самбар, өрөөний хаягжилт, яаралтай тусламжийн тасгийн эмч сувилагчийн амралтын өрөө 4 давхрын ээлжийн сувилагч нарын амрах амралтын өрөө, тасгийн эмч нарын өрөө, 4 давхарт алдарын булан зэргийг шинээр зохион байгуулж тохижуулсан.



ХОЁРДУГААР БҮЛЭГ.

БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

2.1. Байгууллагын “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-ний хэрэгжилт, үр дүн

Монгол улсын Засгийн газрын хэрэг эрхлэх даргын 2020 оны 100 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтын дагуу Эрүүл мэндийн төвийн Байгууллагын 2023 онд хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, нийт 126 ажил хэрэгжүүлэхээр батлуулсан.

Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа стратеги төлөвлөгөө болон бодлогын баримт бичигтэй уялдуулан, зорилт, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, үр дүнг зөв бодитой гаргасан эсэхэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж батлуулсан.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө нь 4 бүлэг, 26 зорилт, 126 арга хэмжээг хэрэгжүүлж, жилийн эцсийн байдлаар хэрэгжилт **93.8** хувьтай байна.

- Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилт- **94.7** хувь,
- Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт, арга хэмжээний хэрэгжилт- **98.4** хувь,
- Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний хэрэгжилт, хүрсэн үр дүн-**83.7** хувь,
- Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний хэрэгжилт, хүрсэн үр дүн-**91.6** хувь

Арга хэмжээний хяналт-шинжилгээ, үнэлгээний чанарын үзүүлэлт

Үнэлгээ	Арга хэмжээ	
	Тоо	Эзлэх хувь
100	94	74.6
90	14	11.1
70	9	7.1
50	3	2.3
30	3	2.3
0	2	1.6
Хэрэгжих боломжгүй	1	0.8
ДҮН	126	100

Нийт 126 арга хэмжээ төлөвлөснөөс 1 арга хэмжээ хэрэгжих боломжгүй хасуулах саналтай байна.

2.1.1. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт, арга хэмжээний чиглэлээр хийгдсэн үйл ажиллагааны талаар

Дүүргүүдийн хэмжээнд анхдагч **ЭРЭГТЭЙЧҮҮДИЙН КАБИНЕТ** байгуулсан.


Нийслэлийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2.5.2, Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.4.3-д тусгагдсан арга хэмжээг Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төв байгуулсан. Салбар амбулатори 1-д Эрэгтэйчүүдийн их эмчийн мэргэжил эзэмшсэн, ажлын туршлагатай эмчийг ажилд авч эрэгтэйчүүдийн кабинетийг 2022 оны 10 сард байгуулсан. Тус кабинетэд өөрийн хөрөнгөөр нийт 11 нэр төрлийн (ЭХО, Эр эс тоологч тор, Эс тоологч тоолуур, ширээ 1 ширхэг, сандал 1 ширхэг, ор 1 ширхэг, жин, сахрын тест, Центрифуг, Яаралтайн шкаф 1, Орхиметр) тоног төхөөрөмж, 4 нэр төрлийн тавилга эд хогшилыг 2023 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр “Ашидбуян” ХХК-иас нийлүүлсэн. Тусламж үйлчилгээний шинэ төрлийг нэвтрүүлж, кабинетын үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. 11 сарын байдлаар эрэгтэйчүүдийн кабинетаар 1485 иргэд үйлчлүүлсэн байна.



Дарь эх нэгдсэн эмнэлэг нь хэвтэн эмнэлгээр тасаг нээж ажиллуулсан.

Дарь-эх нэгдсэн эмнэлэг нь 2023 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн ЭМСайдын А/260 тоот тушаалаар магадлан итгэмжлэлийг 1 жилийн хугацаатай авсан. Даатгалын ерөнхий газартай гэрээ байгуулахын тулд хавдрын эмчилгээний чиглэлээр ор ажиллуулж эхэлсэн. Эмнэлгийг ажиллуулах бэлтгэл ажлуудыг өөрийн хөрөнгийн хэмжээнд нийцүүлэн зохион байгуулан ажиллаж байна.

Жижиг мэс ажилбар буюу өдрийн мэс засал хийх өрөөг шинээр гаргаж тохижуулан бэлдэж, буглаа нээж, полип авч эхэлсэн. Молекул биологийн лаборатори байгуулан, өрөө тасалгааны тохижилт хийж, бэлгийн замын PCR 1000 хүнд шинжилгээ хийсэн. Эс судлалын лабораторыг нэгдсэн эмнэлэгтээ төвлөрүүлж нийт 28 өрх 4 амбулаториас нийт 8009 хүний шинжилгээ хийгдэсэн. Хэвтэн эмчлүүлж буй нийт 1073 хүнд сэргээн засах ба уламжлалтын эмчилгээ хийсэн. Яаралтай тусламжийн тасгыг шинээр байгуулж, 21, 27, 29, 2, 30, 31, 32 хорооны нийт 145 иргэдэд эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлсэн.



“Энэ жилдээ-Эрүүл жиндээ” аяны хүрээнд Баянзүрх дүүргийг үндэсний хэмжээнд ТҮМЭН дасгалыг сурталчлагч загвар дүүрэг болсон.

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Баянзүрх дүүргийн Биеийн тамир спортын хороотой хамтран амжилттай зохион байгуулсан. Сургалтад Баянзүрх дүүргийн Ерөнхий боловсролын 34 сургууль Сургуулийн өмнөх боловсролын 52, Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн 28 эрүүл мэндийн нийгмийн ажилтан хороодын хэсгийн ахлагч нийт 700 гаруй сургагч багшийг бэлдсэн. Эдгээр сургагч багш нар Ерөнхий боловсролын 34 сургуулийн 4200 албан хаагч, Сургуулийн өмнөх боловсролын 52 цэцэрлэгийн 2400, 28 Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн 576, Эрүүл мэндийн төвийн 350 нийт 7526 ажилтан, албан хаагч нарт ТҮМЭН дасгалыг зааж

сургаж, ажлын байран дээрээ хийж хэвшүүлсэн байна. Үүний үр дүнд Баянзүрх дүүрэг нь ТҮМЭН дасгал нь загвар дүүрэг болж, 05 сарын 27-нд ажлын байран дээрхи дасгал хөдөлгөөнийг идэвхижүүлэх, ач холбогдлыг таниулах, хүн бүр хийж хэвшүүлэх нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж, 1000 ажилтан албан хаагчдыг хамруулсан үзүүлэх тоглолтыг зохион байгуулсан.



Онол практикийн бага хурлыг байгууллагадаа зохион байгуулсан.

1. “Баянзүрх дүүргийн эрүүл мэндийн салбарын хөгжилд бидний оролцоо” сэдэвт Онол практикийн бага хурлыг зохион байгуулж, Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газар, Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төв, Өрхийн эрүүл мэндийн төвийн ЗДЭМТ, эмч, эмнэлгийн мэргэжилтэн, АШУҮИС-ийн зочин багш нарын бүрэлдэхүүнтэй 60 зочин ирж оролцсон. Нийт Эрүүл мэндийн төв, Өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, эрүүл мэндийн нийгмийн ажилтан, сувилагч нарын 33 судалгааны ажлын бүтээл ирсэнээс эхний шалгаруулалтанд 20 судалгааны ажлыг илтгэл, 13 судалгааны ажлыг ханын илтгэл хэлбэрээр танилцуулж хэлэлцсэн. Эмнэлзүйн чиглэлээр, Нийгмийн эрүүл мэнд, сувилахуйн чиглэлээр тус бүр 3 бүтээл шалгаруулан өргөмжлөл, мөнгөн шагнал, Ханын илтгэл 2 бүтээл шалгаруулан Засаг даргын Тамгын газрын өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан. Мөн Онол практикийн бага хуралд ирүүлсэн 33 судалгааны бүтээлээр*/ “Онол практикийн бага хурал-2023” ном хийхээр төлөвлөсөн.

2. Улсын нэгдсэн төв эмнэлэгтэй хамтарч “Эрдмийн чуулган 44” илтгэлийн уралдаанд Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвөөс 21 эмч, эмнэлгийн мэргэжилтэн оролцсоноос 2 дугаар шатны шалгаруулалтад 3 бүтээл шалгарснаас сувилахуйн салбараас 1 бүтээл эхний 10 дугаарт шалгарч “Эрдмийн чуулган 44” 2023 номонд бүтээлээ хэвлүүлсэн.

САЙН ТУРШЛАГА-2023 арга хэмжээнд амжилттай оролцлоо.

Нийслэлийн эрүүл мэндийн газраас жил бүр зохион байгууллагддаг “Сайн туршлага 2023 арга хэмжээ”-нд Эрүүл мэндийн төв нь Шинээр нэвтрүүлсэн үйлчилгээний технологи номинацид Андрологийн тусламж үйлчилгээг нэвтрүүлж, нэгдүгээр байр эзэлж, Бамбай булчирхайн зангилаа, бусад эмгэгийг хэт авиагаар эрт оношилж, эмчилгээний үр дүнг хянах, Чихрийн шижин ба инсулин эмчилгээний гарын авлага бүтээлээр гэрчилгээ авсан. Өрхийн эрүүл мэндийн төвүүдээс Сайн туршлагын бүтээлийн санд бүртгэгдэх гэрчилгээ авсан бүтээлүүд “Оч манал” өрхийн эрүүл мэндийн төв “Сэргээн засах тусламж үйлчилгээ”, “Мараната” өрхийн эрүүл мэндийн төв “Синусын зангилаа сулралын хам шинж”, “Нэмүүлэн” өрхийн эрүүл мэндийн төв “Яаралтай тусламжийн өрөөг иж бүрэн тохижуулснаар амь тэнссэн үеийн тусламж үйлчилгээг цаг алдалгүй үзүүлэх нөхцөл бүрдүүлэх”, “Насан Урт” өрхийн эрүүл мэндийн төв “Цахим үндэстэн -Тусламж үйлчилгээнд ашигладаг анхан шатны маягт цахимжсан”, “Ачитсайхан” өрхийн эрүүл мэндийн төв “Олон улсын чанарын удирдлагын тогтолцооны менежментийг нэвтрүүлсэн нь ISO9001:2015”, “Ачитсайхан” өрхийн эрүүл мэндийн төв “0-2 сартай хүүхдийн анхаарал татсан нярайд гэрийн асаргаа сувилгаа, эмчилгээний хяналт тавих”, “Өнөр Энхмэнд өрхийн эрүүл мэндийн төв “Сувилагчийн тусламжийн цүнх” бүтээлүүд тус тус гэрчилгээ авсан.



Тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор БЗДХ-ын үндсэн 7 үүсгэгчийг илрүүлэх шинжилгээг авдаг болсон.

Амьгүй төрөлт, зулбалтаас урьдчилан сэргийлэх зорилгоор Бэлгийн замаар дамжих халдварын үндсэн 7 үүсгэгч илрүүлэх шинжилгээг 02 сарын 06-ны өдрөөс эхлэн хийж, 10 сарын байдлаар 1000 хүнд шинжилгээ хийж, эмчлэн эрүүлжүүлж ажиллаж байна.



Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдэд чиглэсэн TORCH шинжилгээг авдаг болсон.

Эрт үеийн ургийн гажигаас урьдчилан сэргийлэх зорилгоор жирэмсэн эхчүүдэд TORCH вирусын халдвар илрүүлэх шинжилгээг жирэмсэний хяналтанд 5121 жирэмсэн орсноос 671 жирэмсэнг шинжилгээнд хамруулсан.



Хеликобактерийн антиген илрүүлэх шинжилгээг авч эхэлсэн.

Ходоодны хавдраас урьдчилан сэргийлэх зорилгоор өтгөнд хеликобактерийн антиген илрүүлэх шинжилгээг 2023 онд шинээр нэвтрүүлж, 11 сарын байдлаар нийт 865 хүнд шинжилгээ хийсэн.



Ахмад настанд чиглэсэн тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж, ясны сийрэгжилтийг тодорхойлдог болсон.

Баянзүрх дүүрэгт нийт 47847 ахмад настан бүртгэлтэй байгаагаас Эрүүл мэндийн төвийн ахмадын кабинетаар 20317 болон өрхийн эрүүл мэндийн төвүүдээр

давхардсан тоогоор 325666 ахмад настан үйлчлүүлсэн байна. Үүнээс 28710 буюу 60 хувийг ясны сийрэгжилт тодорхойлох шинжилгээнд хамруулаад байна



Иргэдийн хүлээгдлийг бууруулж, даралтаа өөрөө үзэх боломж олгосон.

Салбар амбулатори 1-д артерийн даралт үзэх булан байгуулж, 2 автомат даралтын аппараттай болсон. Жирэмсэн эмэгтэйчүүд болон дотрын эмчид үзүүлэх иргэд давхардсан тоогоор 111032 хүн даралтаа хэмжүүлсэн байна.



Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүрч үйлчлэх зорилгоор дохионы хэлний сургагч багш бэлтгэгдсэн.

Эрүүл мэндийн төв нь дохионы хэлний сургалт эрхлэгч “Үжин Тайж” нийгэмд үйлчлэх төрийн бус байгууллагатай хамтран “Дохионы хэлний сургагч багш бэлтгэх” 16 багц цагийн сургалтыг зохион байгуулж байна. Тус сургалтад эрүүл мэндийн төвийн салбар амбулаториудын хөтөч сувилагч 4, эрүүл мэндийн нийгмийн ажилтан 1, нийт 5 хүнийг хамруулан сургагч багшаар бэлтгэсэн.




Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлд мэргэжлийн байгууллагаар үнэлгээ хийлгүүлсэн.

Баянзүрх дүүргийн эрүүл мэндийн салбар 1, 2, Дарь эхийн нэгдсэн эмнэлэг, поликлиник зэрэг 4 эмнэлгийн нийт 26 ажлын байрыг хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээнд хамруулсан. Эдгээр ажлын байранд нийт 32 ажилтныг төлөөлүүлэн 28 ажилтныг АШУҮИС-ийн НЭМС-ийн Хөдөлмөр орчны эрүүл ахуйн лабораторитой хамтран хөдөлмөрийн нөхцөлийн хэмжилтэд хамруулсан. Үнэлгээ дараах байдалтай гарсан. Үүнд:

- Хэмжилт, шинжилгээний дүнд үндэслэн MNS 5080:2001 стандартын дагуу хөдөлмөрийн нөхцөлийг үнэлэхэд бүх ажлын байр /26/ ажлын байрууд хэвийн ангилалтай байна.
- Ажлын байранд гэрэлтүүлгийн хэмжилтийн дүнг харахад зарим хэмжилтийн үр дүн зөвшөөрөх хэмжээнд хүрээгүй.
- Ажилтнуудын нийт тоосны өртөлтийн түвшинг тодорхойлсон дүнгээс харахад ЗДХ-ээс хэтэрсэн хэмжилт тодорхойлогдоогүй боловч зарим хэмжилтийн дүн ЗДХ-ний утгын 50- 100%-тай тэнцэж байна.
- Шуугианы хэмжилтээр ажилтнуудын өртөлтийн төвшинг тодорхойлсон дүнгээс харахад ЗДХ-ээс хэтэрсэн хэмжилт тодорхойлогдоогүй боловч зарим слесарь, мужаан зэрэг ажлын байрны шуугианы өртөлт 82.9-84.9 дБА байгаа нь Ажлын байран дахь шуугианы өртөлтийн хэмжилт, стандартад заасан хэмжээнээс өндөр байна.
- Агааржуулалтын үнэлгээгээр нийт 25 өрөө тасалгаанд хийснээс ихэнх өрөөний агааржуулалтын систем хүрэлцээгүй буюу БНБД 44-04-21- д заасан сэлгэх давтамж 2 удаа / цагт шаардлагыг хангахгүй байна.
- Эмч, эмнэлгийн эрсдэлтэй ажлын байрнд ажиллаж байгаа ажилнуудад бугуйн хамгаалалт оёж 50ш ажилтанд тараасан

- Шуугианы эрсдэл өндөр ажилтангуудад Үйлдвэрчний эвлэлтэй хамтран 50 ажилтанд 3М шуугиан бууруулалттай чихэвч тараасан.



2.1.2. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний хэрэгжилт

Шинжилгээний хариу хэвлэдэг И-Киоск машин байрлуулсан.


E-health программыг 2022 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс үйлчилгээнд нэвтрүүлж, 22 төрлийн үйлчилгээ цахимд шилжсэнээр эмч нарын ачаалал 70-80%, Шинжилгээний хариу болон бусад мэдээллийг программаасаа шууд татаж цахим стори дээрээ хавсаргадаг болсноор үйлчлүүлэгч нарын чирэгдлийг 100% бууруулсан.



2.1.3. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний хэрэгжилт

Байгууллага анх удаа түүхэн кино хийсэн.

Байгууллагын түүхийг харуулсан баримтат кино хийж, олон нийтийн сүлжээ, ТВ-ээр цацах, нийтэд таниулах ажлын хүрээнд Байгууллагын баримтат кино зураг авалт бүрэн дуусч, дурсамж хууч яриа өгөх хүмүүсээс ярилцлага авч, эвлүүлгийн ажлыг хийж бэлэн болсон. “Түмний төлөө зүтгэсэн хагас зуун” баримтат кино 45 минут үргэлжилнэ.

*Улирал бүр сэтгүүл гарган ажиллаж эхэлсэн.*


2023 оны 1-р улиралд “Баянзүрх-Эрүүл мэнд” сэтгүүлийг эрхлэн гаргаж 2022 оны оны шилдгүүдийн болон өндөр насны тэтгэвэрт гарсан ажилчдын ярилцлага, ажилчдын нийгмийн асуудлын талаар хийсэн ажил, орон сууцны урьдчилгаа авсан ажилчдын мэдээллийг ил тодоор оруулсан. 2023 оны 2-р улиралд “Онол практикийн бага хурал” сэдвээр, 3,4-р улирлын дугаарыг Оны ажлын тайланг цувралаар гаргасан.



Шинэ ажилтныг дадлагажуулах өврийн дэвтрийг хийж, чиглүүлэх сургалтыг тогтмол хийдэг болсон.

Шинэ ажилчдыг ажлын байр болон байгууллагын холбогдох мэдээлэлтэй танилцах, дадлагажуулах, чиглүүлэх ажлыг хөнгөвчлөх зорилгоор “Шинэ ажилтны өврийн дэвтэр”-ийг 2023 оны 8 сард гаргаж, 2023 онд шинэ ажилд орсон 100 гаруй шинэ ажилтанд, мөн салбар нэгж, албадуудад тараасан.

Мөн 2023 оны 9 дүгээр сараас “Шинэ ажилтныг сургах, дадлагажуулах, чиглүүлэх журам батлах тухай” Эрүүл мэндийн төвийн даргын 2023 оны А/102 дугаар тушаалаар сар бүрийн сүүлийн өдөр тухайн сард шинээр ажилд орсон ажилтнуудад байгууллагын танилцуулга, цалин хөлс, эмнэлгийн тусламж үйлчилгээ, сувилахуйн тусламж үйлчилгээ, эрүүл мэндийн даатгалын санхүүжилт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн чиглэлээр чиглүүлэх, дадлагажуулах сургалтыг хийж тогтмолжуулсан.



Ажилчдын урьдчилан сэргийлэх үзлэгт ӨНДӨР ӨРТӨГТ ШИНЖИЛГЭЭГ оруулж ирсэн.

Артерийн даралт, цусан дахь сахар тодорхойлох, чихрийн шижингийн эрсдэлийг үнэлэх, биеийн жингийн индекс тооцох, амин дэм, эрдэс бодис, ясны сийрэгжилт тодорхойлох, хооллолтын болон сэтгэл зүйчийн зөвлөгөө өгөх, ерөнхий хавдрын болон элэг, өндгөвч, бүдүүн гэдэсний хавдрын маркерийн шинжилгээ, хеликобактери болон MRSA илрүүлэх шинжилгээ, сүрьеэгийн эрсдэл үнэлэх, мөн нүдний эмчийн үзлэг, оношилгоо гэх мэт нийт 16 оношилгоо хийгдсэн.



2.2. Нийслэлийн Засаг дарга болон дүүргийн Засаг даргын хооронд байгуулсан “Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх гэрээ”-ний хэрэгжилт, үр дүн

Нийслэлийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх гэрээ”-ний Эрүүл мэндийн төвийн хийж хэрэгжүүлэх 7 зорилт, 12 арга хэмжээний хэрэгжилт жилийн эцсийн байдлаар 85.5 хувийн хэрэгжилттэй байна.

Зорилт 2.5. халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, эмчлэх, замаар халдварт бус өвчнөөс үүдэлтэй нас баралтын хувийг бууруулна:

Зонхилон тохиолдох халдварт бус өвчнөөс сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах эмч, эрүүл мэндийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалтыг “Эрүүл мэндийн боловсролыг дэмжих ухуулга, нөлөөллийн арга хэмжээ, зан үйлийг өөрчлөх, мэдээлэл, сургалт сурталчилгааны төрөл, чанарыг сайжруулж, иргэдийн сонирхол төрүүлэхүйц шинэлэг, сонирхолтой хэлбэрээр хэрэгжүүлэх”, “Халдварт бус өвчлөл, өвчний эрт үеийн хяналт, тандалтыг сайжруулах, эрт илрүүлгийн хамрагдалтыг нэмэгдүүлэх”, “Умайн хүзүүний хорт хавдрын цогц хяналтын зааврын танилцуулга”, “Хорт хавдрын өвчлөл, өвчний эрт үеийн хяналт, тандалтыг сайжруулах, эрт илрүүлгийн хамрагдалтыг нэмэгдүүлэх” зэрэг 4 сэдвийн хүрээнд 136, дотоодын 42 сургалтад 512 мэргэжилтэн тус тус хамрагдаж, нийт 46 удаагийн сургалтад 648 эрүүл мэндийн ажилтан хамрагдсан. Баянзүх дүүргийн нутаг дэвсгэрийн зах, худалдааны төв дээр зохион байгуулагдсан “Нэгдсэн арга хэмжээ” өдөрлөгт 5000 гаруй иргэн, 150 гаруй сургалтанд 5,100 иргэн хамрагдаж, 100 төрлийн мэдээ, мэдээллийг 110,000 иргэнд хүргэсэн. Эрүүл мэндийн төвийн ажилтануудын дунд зохиогдсон “Урьдчилан сэргийлж-эрүүл амьдарья-өглөөний цайг өөртөө-өөрчлөлтийг өөрөөсөө” аяны хүрээнд артерийн даралт, цусан дахь сахар тодорхойлох, чихрийн шижингийн эрсдэлийг үнэлэх, биеийн жингийн индекс тооцох, амин дэм, эрдэс бодис, ясны сийрэгжилт тодорхойлох, хеликобактери илрүүлэх, ерөнхий хавдрын болон элэг, өндгөвч, бүдүүн гэдэсний хавдрын маркерийн шинжилгээ, нүдний эмчийн үзлэг, оношилгоо хооллолтын болон сэтгэл зүйн зөвлөгөө гэх мэт нийт 16 оношилгоонд 310 ажилтан хамрагдсан байна. 2023 оны эхний 10 сарын байдлаар бөөр шээсний замын эрт илрүүлэг шинжилгээнд 37596 иргэн хамрагдаж, бөөрний нарийн мэргэжлийн эмчид 5401 иргэн үзүүлсэнээс 510 иргэн өдрийн эмчилгээнд хамрагдсан ба үүнээс 92 буюу 18% нь бөөрний үрэвслийн оношоор эмчлэгдэн эрүүлжиж байна.


- Артерийн гипертензи эрт илрүүлэг 226386 хүн хамрагдахаас 127764 буюу 56.4 %,
- Чихрийн шижингийн эрт илрүүлэг 226386 хүн хамрагдахаас 115508 буюу 51.0 %,
- Умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлэг 28555 хүн хамрагдахаас 8588 буюу 27%,
- Хөхний өмөнгийн эрт илрүүлэг 121450 хүн хамрагдахаас 66261 **хэрэгжилт 100%**,

- Жил бүр шат дараатайгаар 1-2 дүүргийн Эрүүл мэндийн төвд эрэгтэйчүүдийн кабинет байгуулах арга хэмжээний хүрээнд Салбар амбулатори 1-д Эрэгтэйчүүдийн их эмчийн мэргэжил эзэмшсэн, ажлын туршлагатай эмчийг ажилд

авч эрэгтэйчүүдийн кабинетийг 2022 оны 10 сард байгуулсан. Тус кабинетэд өөрийн хөрөнгөөр нийт 11 нэр төрлийн (ЭХО, Эр эс тоологч тор, Эс тоологч тоолуур, ширээ 1 ширхэг, сандал 1 ширхэг, ор 1 ширхэг, жин, сахрын тест, Центрифуг, Яаралтайн шкаф 1, Орхиметр) тоног төхөөрөмж, 4 нэр төрлийн тавилга эд хогшилыг 2023 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр “Ашидбуян” ХХК-иас нийлүүлсэн. Тусламж үйлчилгээний шинэ төрлийг нэвтрүүлж, кабинетын үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. Кабинет 2022 оны 11 сараас байгуулагдсанаас хойш нийт 1766, 2023 оны 1-9 сарын байдлаар 877 иргэд үйлчлүүлсэн. Нийслэлийн дүүргүүдээс анхдагч жишиг эрэгтэйчүүдийн кабинетаар сонгогдсан. **хэрэгжилт 100%,**



- Эрүүл мэндийн дэмжих төвийг 8 дүүрэгт байгуулах арга хэмжээний хүрээнд Зөвлөх Поликлиникт “Эрүүл мэндийг дэмжих төв”-ийг нэг урсгалтайгаар зохион байгуулж, засварын ажил бүрэн дуусаж 2022.05.01-ний өдөр ашиглалтад орж, үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. **хэрэгжилт 100%,**



Зорилт 2.6. Халдварт өвчнөөс сэргийлэх, илрүүлэх, хянах, тандах, эмчлэх үйл ажиллагааг сайжруулан, өвчлөлийг бууруулна.

БЗДХ/ДОХ, сүрьеэ халдварт гепатит болон бусад халдварт өвчний илрүүлэлтийг нэмэгдүүлж, эмчилгээнд хамруулах арга хэмжээний хүрээнд 2023 онд төрөлхийн тэмбүүгийн 3 тохиолдол бүртгэгдсэнээс хяналтанд ороогүй 2, амьгүй 1 тохиолдол бүртгэгдсэн. 2023 онд 11180 жирэмсэн эмэгтэй серологийн шинжилгээнд хамрагдаж, 121 тэмбүүгийн шинэ тохиолдол илрүүлж, эмчилгээнд хамруулсан нь өмнө оны мөн үетэй харьцуулахад 4,3 хувиар өссөн байна.

2023 онд 2021, 2022 онд сүрьеэгийн хавьтал гэж бүртгэгдсэн 1070 иргэнээс 676 буюу 63.2%-ийг үзлэгт хамруулж 7 шинэ тохиолдол илрүүлэн эмчилгээнд хамруулсан. Солонгосын үндэсний сүрьеэгийн нийгэмлэгтэй хамтран 2020, 2021,

2022 онд бүртгэгдсэн сүрьеэгийн тохиолдлын хавьтал 1293 иргэнийг урьдчилан сэргийлэх давтан үзлэгт хамруулж, 12 шинэ тохиолдол илрүүлэн эмчилгээнд хамруулсан. Сүрьеэгийн диспансер нь эрсдэлт бүлгийн 4869 хүнээс 2750 иргэнийг үзлэгт хамруулж 31 тохиолдлыг илрүүлэн эмчилгээнд хамруулсан. Мөн Солонгосын үндэсний сүрьеэгийн нийгэмлэг, Монголын өрхийн анагаах ухааны мэргэжилтэнүүдийн холбоо, Эрүүл сүрьеэгүй ирээдүйн төлөө Төрийн бус байгууллагуудтай холбоотой хамтран хүүхдийн байгууллагад бүртгэгдсэн сүрьеэгийн хавьтал болон хороодын эрсдэлт бүлгийн 3087 иргэдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж 10 сүрьеэ, 56 сүрьеэгийн далд халдварыг илрүүлэн эмчилгээнд хамруулсан байна. Эрүүл мэндийн сайдын 2017 оны 4 сарын 14-ны өдрийн “Журам батлах тухай” А/145 тоот тушаалын дагуу 6834 иргэнийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, сүрьеэгийн 1 тохиолдлыг илрүүлж эмчилгээнд хамруулсан. 2023 оны 11 сарын 10-ны өдрийн байдлаар архины албадан эмчилгээний нийт 229 иргэн сүрьеэгийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан байна. Сүрьеэгийн 1 тохиолдол илрүүлж Энэрэл эмнэлэгт хүлээлгэн өгсөн. **хэрэгжилт 70%,**




• Товлолт дархлаажуулалтын хувийг нэмэгдүүлэх замаар тарилгаар сэргийлэгдэх халдварт өвчний тохиолдлыг бууруулах арга хэмжээний хүрээнд Товлолын дархлаажуулалтын хамралтын хувийг нэмэгдүүлэх зорилгоор өрхийн эрүүл мэндийн төвүүдэд товллын дархлаажуулалтын төлөвлөлтийг чанаржуулах, товллын дархлаажуулалтад хамрагдаагүй хүүхдийн бүртгэлийг сайжруулах, хамрагдаагүй шалтгааныг тодорхойлох зэрэг дэмжлэгт хяналтыг зохион байгуулж, үүрэг даалгаврыг өгсөн. Баянзүрх дүүргийн хэмжээнд Баянзүрх дүүргийн хэмжээнд 2023 оны эхний 10 сарын байдлаар Товлолт дархлаажуулалтын хамралт 96.1%, Тавт вакцины 3 дахь тунгийн хамралт 98%, Улаанбурхан-Гахайнхавдар-Улаануудын /УГУ/ эсрэг вакцины 2 дахь тунгийн хамралтын хувь 95.9% **хэрэгжилт 97%,**



Зорилт 2.7. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тогтолцоог бий болгоно

Дүүрэг бүрд Нийгмийн эрүүл мэндийн төвийг байгуулах арга хэмжээний хүрээнд 2021 оны 05 дугаар сарын 25-ны өдөр Төрийн худалдан авах ажиллагааны газраас түлхүүр гардуулах нөхцөлтэй “Нийгмийн эрүүл мэндийн төвийн барилга”-ийн тендерийг зарлаж, 2,159.0 сая төгрөгөөр гүйцэтгэхээр “Шилдээд” ХХК шалгарч, 2021 оны 7 сарын 23-нд захиалагч Эрүүл мэндийн яамтай гэрээ байгуулсан. Газар чөлөөлөх хуучин сүрьеэгийн диспансерын барилгыг 2022 оны 8 сарын 19-нд нурааж дууссан. Сантехникийн шугам сүлжээ татахад 69-р сургууль, 115-р цэцэрлэгээс зөвшөөрөл авч, гадна дулаан, цахилгаан, бетон каркас цутгалтын ажил хийгдсэн бөгөөд 11 сарын 10-ны өдрийн байдлаар дулаан авах хүсэлтийг холбогдох байгууллагад өгч, дотор будгын ажил, тааз хийгдэж, ажлын гүйцэтгэл 90 хувьтай үргэлжилж байна. Барилгын ажлыг 2023 оны 12 сард дуусгаж, ашиглалтад оруулахаар төлөвлөгөөтэй ажиллаж байна. **хэрэгжилт 97%,**



Зорилт 2.8. Эх, хүүхдийн эндэгдлийг бууруулсан байна.

✓ Эх, хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах арга хэмжээний хүрээнд Дүүргийн хэмжээнд нийт 49857 жирэмсэн хяналтад орсноос 2023 оны 10 сарын байдлаар дүүргийн эрүүл мэндийн төвд 5121 нь өрхийн эрүүл мэндийн төвд 359 жирэмсэн хяналтад байна. Шинээр 3080 жирэмсэн хяналтад орсон. Эрт үеийн жирэмсний хяналтад 2736 эмэгтэй (90.5%), хожуу үеийн жирэмсний хяналтад 344 эмэгтэй (9,5%) орсон байна.

Эх, нярайд үзүүлэх тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор нийт 36 өрхийн эрүүл мэндийн жирэмсний хяналтын үзлэг, 2 тосгоны

эмнэлгийн жирэмсний хяналтын үзлэг, тусламж үйлчилгээг амбулаториор болон Дарь-эх нэгдсэн эмнэлгээр үзүүлж байна.

Жирэмсний хяналтыг сайжруулахаар амгалан амаржих газрын төрөлжсөн нарийн мэргэжлийн зөвлөх эмчтэй хамтран өндөр эрсдэлтэй 147 жирэмсэн эмэгтэйчүүдийг үзэж цаашид гарах эрсдэлийг тооцон ажиллаж байна.

Баянзүрх дүүргийн нэгдсэн эмнэлэгт бөөр шээсний замын үрэвсэл дотрын оноштой 25 жирэмсэн эхчүүдийг цаг алдалгүй гараас гарт хүргэн хэвтэн эмчлүүлж хамтран ажиллаж байна. **хэрэгжилт 99%,**

✓ Төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагуудтай хамтран хүүхдийн сэргийлж болох эндэгдлийг бууруулах ажлыг зохион байгуулах арга хэмжээний хүрээнд 2023 оны эхний 10 сарын байдлаар 0-1 насны эндэгдэл насны хүүхдийн эндэгдэл 72 тохиолдол, /1000 амьд төрөлтөд/ буюу 12 промилль өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.2 промилль өссөн, УБ дунджаас 1.3 промилль өссөн. 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 5 тохиолдол буюу 0.8 промилль өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.7 промилль буурсан, УБ дунджаас 0.5 промилль буурсан. Эндэгдлийг бууруулах зорилгоор дараах ажлуудыг хийсэн. Үүнд:

Хүүхдийн эмнэлгийн бус эндэгдлийн шалтгаан, үр дагаварыг дүгнэх, дахин давтагдахаас сэргийлэх, эрсдэлт нөхцөл байдлыг дүгнэх, холбогдох эмч нарын үйл ажиллагаа, үүрэг, хариуцлага, харилцаа, хандлага, эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар аюулгүй байдлын үр дүнг дээшлүүлэх зорилгоор жилийн эцсийн байдлаар 6 тохиолдол гарсан. Үүнээс магадлан хэлэлцэх хуралд 2 тохиолдлыг хэлэлцсэн. Мөн амьгүй төрөлтийн 6 тохиолдлыг хэлэлцэж, хурлаас гарсан зөвлөмжийн дагуу эрсдэлт бүлгийн нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүд болон архины хамааралтай эмэгтэйчүүдийн судалгаа шинэчлэн гаргаж, жирэмсэнээс хамгаалах аргад хамралт сайжирсан байна. Үүний үр дүнд 10 дугаар сарын байдлаар 1-5 хүртэлх хүүхдийн эндэгдэл буурсан **хэрэгжилт 100%,**

Зорилт 2.9 Гэр бүл төлөвлөлт, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүн бүрд хүргэнэ

Баянзүрх дүүрэг өсвөр насны 183253 хүүхэдтэй. Үүнээс 26994 хүүхэд хамрагдахаас 2023 оны жилийн эцсийн байдлаар 14610 өсвөр насны хүүхдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсанаас 3617 хүүхдээс өвчлөл илэрч, 10993 хүүхэд эрүүл байна. Өвчлөлөөр нь авч үзвэл: Амьсгалын зам 893, хоол боловсруулах эмгэг-149, бөөр шээсний зам-252, зүрх судасны-32, бусад өвчлөл-2291 Монголын хүүхдийн сан, Шинэ найдвар асрамжийн төв, Гэрэл асрамжийн төв, Домбоска 4 асрамж халамжийн төв болон албан бус сургалтын 122 өсвөр насны хүүхэд 8 Төвийн харьяа 2, 5, 17, 25, 26 хорооны Өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй хамтарч 6 ерөнхий боловсролын сургуулийн 6-10 дугаар ангийн хүүхдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан. **хэрэгжилт 100%,**



- 2023 оны 11 сарын байдлаар нийт нөхөн үржихүйн насны 106479 эмэгтэйчүүд байна. Үүнээс 43706 буюу 41 хувь нь жирэмснээс сэргийлэх арга хэрэгсэлд хамрагдсан. Илүү өртөмхий болон эрсдэлт бүлгийн 8.884 эмэгтэйчүүд байна. Үүнээс 4823 / 54.2% нь жирэмснээс сэргийлэх арга хэрэгсэлд хамрагдсан. Хөгжлийн бэрхшээлтэй, хөдөлмөрийн чадвар алдалт тогтоолгосон 1457 эмэгтэйгээс 610 эмэгтэйг жирэмснээс сэргийлэх арга хэрэгсэлд хамруулсан. Үүнээс Сэтгэцийн эмгэгийн улмаас хөдөлмөрийн чадвар алдалт тогтоолгосон нөхөн үржихүйн насны 407 эмэгтэйгээс 168 эмэгтэйг жирэмснээс сэргийлэх арга хэрэгсэлд хамруулсан. Жирэмснээс хамгаалах арга хэрэглэсэн нийт 7330 нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүд байна. Үүнээс суулгац 107, ерөндөг 341, эмийн аргаар 2232, бэлгэвч 4191, тариагаар 459 хэрэглэсэн байна. Жирэмснээс сэргийлэх арга хэрэгслийн үлдэгдэл өрхийн эрүүл мэндийн төвүүдэд нийт 14997 байна. Үүнээс суулгац 181, ерөндөг 1068, эм бэлдмэл 4567, бэлгэвч 8166, тариа 1015 ширхэг байна. Дүүргийн эрүүл мэндийн төвийн өсвөр үеийн кабинетын үйл ажиллагаанд жирэмснээс сэргийлэх арга хэрэгсэлд 51 охин хамруулснаас охидын ерөндөг 33, суулгац 9 тавьж, эм 5, жирэмсний тест 21 ширхэг, бэлгэвч 300 ширхэг хэрэглэсэн. Хүүхдийн тусламжийн 108 дугаар утсаар ирсэн 21 хүүхдийг холбогдох газруудтай холбож, хамтран ажилласан. Харьяа эрүүл мэндийн төвүүд нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдэд "жирэмслэхээс сэргийлэх арга хэрэгсэл", "Гэр бүл төлөвлөлт" чиглэлээр нийтдээ 61 сургалтад 2719 эмэгтэйчүүдийг хамруулсан. **хэрэгжилт 100%,**



Зорилт 2.10. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын бэлэн байдал, хариу арга хэмжээний тогтолцоог бэхжүүлнэ.

- Шаардлагатай хүний болон эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног, төхөөрөмжийн нөөц, бэлэн байдал хангагдах арга хэмжээний хүрээнд Нөөцийн бэлэн байдалд 30-60 хоногийн халдваргүйжүүлэх бодис 16 нэр төрлийн 421ш, нэг удаагийн хэрэгсэл 12 нэр төрлийн 168945ш, эм, эмнэлгийн хэрэгсэл нийт 369 нэр төрлийг бүрдүүлэн ажиллаж байна. ЭМТ-д 330 эмч, эмнэлгийн мэргэжилтэн ажиллаж байна. Нөөцийн бэлэн байдал хангагдсан. Хэрэгжилт 100%

Зорилт 2.11. Хотын хүн амыг эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, тэр дундаа нэн шаардлагатай эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг чанартай хүргэж, аюулгүй, үр дүнтэй, нэн хэрэгцээтэй эм, вакцинаар ханган, эрүүл мэндийн даатгалд бүрэн хамруулна.

- ✓ Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үйлчлэх хүртгээмжийг нэмэгдүүлэх зорилгоор эмч, сувилагч, ажилтнуудад дохионы хэлний мэдлэг олгохоор сургагч багш бэлтгэх сургалт зохион байгуулж, 5 ажилтанг бэлтгэж байна.



✓ 2023 оны 03 сарын 30-ны өдрөөс эхлэн ясны сийрэгжилтийг тодорхойлж эхэлсэн. Баянзүрх дүүрэгт нийт 47847 ахмад настан бүртгэлтэй байгаагаас Эрүүл мэндийн төвийн ахмадын кабинетаар 20317 болон өрхийн эрүүл мэндийн төвүүдээр давхардсан тоогоор 325666 ахмад настан үйлчлүүлсэн байна. Үүнээс 28710 буюу 60 хувийг ясны сийрэгжилт тодорхойлох шинжилгээнд хамруулаад байна.



✓ TORCH-ийн цочмог халдвар илрүүлэх, Эрт үеийн ургийн гажигаас урьдчилан сэргийлэх зорилгоор 2023 оны 1 сараас эхлэн жирэмсэн эхчүүдэд TORCH вирусын халдвар илрүүлэх шинжилгээг жирэмсэний хяналтанд 5121 жирэмсэн орсоноос 671 жирэмсэнг шинжилгээнд хамруулсан.



✓ Ходоодны хавдраас урьдчилан сэргийлэх зорилгоор өтгөний хеликобактери илрүүлэх шинжилгээг 2023 оны 1 сараас шинээр хийж, 2023 онд шинээр нэвтрүүлж, 11 сарын байдлаар нийт 865 хүнд шинжилгээ хийсэн.

✓ Бэлгийн замаар дамжих халдварын үндсэн 7 үүсгэгч илрүүлэх шинжилгээг 02 сарын 06-ны өдрөөс эхлэн хийж, 10 сарын байдлаар 1000 хүнд шинжилгээ хийсэн.

✓ “Энэ жилдээ-Эрүүл жиндээ” аяны хүрээнд Баянзүрх дүүргийг үндэсний хэмжээнд ТҮМЭН дасгалыг сурталчлагч загвар дүүрэг болгох зорилгоор идэвхитэй хөдөлгөөн, чийрэгжүүлэлтийн ТҮМЭН дасгалын сургагч багш бэлтгэх, мэргэжил аргагүйн сургалтыг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Баянзүрх дүүргийн Биеийн тамир спортын хороотой хамтран амжилттай зохион байгуулсан. Сургалтад Баянзүрх дүүргийн Ерөнхий боловсролын 34 сургууль Сургуулийн өмнөх боловсролын 52, Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн 28 эрүүл мэндийн нийгмийн ажилтан хороодын хэсгийн ахлагч нийт 700 гаруй сургагч багшийг бэлдсэн. Эдгээр сургагч багш нар Ерөнхий боловсролын 34 сургуулийн 4200 албан хаагч, Сургуулийн өмнөх боловсролын 52 цэцэрлэгийн 2400, 28 Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн 576, Эрүүл мэндийн төвийн 350 нийт 7526 ажилтан, албан хаагч нарт ТҮМЭН дасгалыг зааж сургаж, ажлын байран дээрээ хийж хэвшүүлсэн байна. Үүний үр дүнд Баянзүрх дүүрэг нь ТҮМЭН дасгал нь загвар дүүрэг болж, 05 сарын 27-нд ажлын байран дээрхи дасгал хөдөлгөөнийг идэвхижүүлэх, ач холбогдлыг таниулах, хүн бүр хийж хэвшүүлэх нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж, 1000 ажилтан албан хаагчдыг хамруулсан үзүүлэх тоглолтыг зохион байгуулсан. **хэрэгжилт 100%**,

• Стандартын шаардлага хангасан байртай өрхийн эрүүл мэндийн төвийн тоог нэмэгдүүлж, үйлчилгээний хүртээмж, хүчин чадал сайжруулах арга хэмжээний хүрээнд 2020-2024 онд Нийслэлийн хэмжээнд 11 жишиг өрхийн эмнэлэг баригдахаас Баянзүрх дүүрэгт жишиг 2 өрхийн эмнэлгийн байр баригдахаар төлөвлөгдсөн. Үүнээс:

1. Баянзүрх дүүргийн 16 дугаар хорооны “Насан урт” ӨЭМТ стандартын шаардлага хангасан байранд 2022 оны 3 дугаар сараас үйл ажиллагаа явуулж байна. /100%/

2. 17 дугаар хорооны өрхийн эмнэлгийн байр баригдах төсөв суусан, газар чөлөөлөгдсөн, тендерт шалгарсан компаниудын зураг төслийн ажил хийгдсэн байна. **Хэрэгжилт 100%**

2.3. Төсвийн орлогын төлөвлөгөө болон нийслэлийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөний биелэлт, нийслэлийн төсвөөс дүүргийн төсөвт олгож буй санхүүгийн дэмжлэгийн харьцуулалт

2023 оны 1-11 сарын байдлаар гүйцэтгэлийн санхүүжилтэд бүрэн шилжсэн. Эрүүл мэндийн даатгалаас нийт 15,514,922,752 төгрөг орж ирснээс эрт илрүүлэг 3,193,127,000 төгрөг, үндсэн үйл ажиллагааны санхүүжилт 12,321,795,752 төгрөгийн санхүүжилт авсан байна. 2023 оны жилийн эцсээр Эрүүл мэнд нийгмийн даатгалын ерөнхий газраас үндсэн тусламж үйлчилгээний 1,359,506,771.5 төгрөгийн авлагатай гарсан, одоогоор аваагүй байна.

Гүйцэтгэлээр санхүүжиж байгаатай холбоотой сар бүр төсвийн төлөвлөгөөг гүйцэтгэлээр орж ирсэн орлогодоо тохируулан боловсруулж, НЭМГ-т хүргүүлдэг. Тухайн сард өглөг, авлага үүсгэхгүйн тулд тооцооллыг тухай бүрд нь хийж ажиллаж байна.

2.4. Хяналт шалгалтын байгууллагаас ирүүлсэн, санал зөвлөмж, түүнийг хэрэгжүүлсэн байдал

Санхүүгийн тайлангийн аудит 2023 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт орж 1 албан шаардлага, 2 зөвлөмжийг ирүүлсэн бөгөөд дараах байдлаар хэрэгжүүлэн ажилласан. Төлбөрийн актгүй.

- Балансад тусгагдсан анхны өртгөө нөхсөн 1080 ширхэг хөрөнгийг хойшид дахин ашиглах боломжтой хөрөнгийг дахин үнэлгээнд оруулахаар, цаашид ашиглах боломжгүй, эвдэрч гэмтсэн хөрөнгийг актлахаар Нийслэлийн Өмчийн Харилцааны газарт хөрөнгийн жагсаалтыг хүргүүлсэн боловч хөрөнгийн дахин үнэлгээ хийх хугацаа болоогүй, зөвхөн актлах хөрөнгөө жагсаагаад явуулж, 240 ширхэг 2023 оны үндсэн хөрөнгөөс 240 нэр төрлийн хасуулж, актлах хөрөнгөө устгал хийсэн.

- Байгууллагын ил тод байдлыг ханган ажиллах үүднээс шилэн дансанд санхүүгийн мэдээллийг цаг хугацаанд нь үнэн зөв байршуулах үүрэгтэй билээ. 2023 онд 3 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан. 2023 оны 11-р сарын байдлаар байршуулах ёстой 163 мэдээллийг хугацаанд байршуулан ил тод болгоод байна.

2.5. Төрийн албан хаагчдын ажлын гүйцэтгэл, мэргэшлийн түвшнийг үнэлж дүгнэсэн байдал

Засгийн газрын 2019 оны 05, 395 дугаар тогтоолын дагуу эмч, ажиллагсдын 2023 оны 1,2,3-р улирлын ажлын гүйцэтгэлийг үнэлж үнэлгээгээр 352 ажилтанд 693,947,345 төгрөгийн урамшуулал олгосон.

Эрүүл мэндийн төвийн даргын 2023 оны Б/37 дугаар тушаалаар ТҮЭМ, ТҮ зэрэглэлийн эмч, ажилтнуудын үндсэн цалинг 100,000 төгрөгөөр 2023.01.02-ноос нэмэгдүүлсэн.

Гэмтэл, мэс заслын эмч сувилагч, чанарын багийн гишүүд, Ахлах сувилагч, Халдварын сэргийлэлт хяналтын багийн гишүүд, эд хөрөнгө хариуцдаг ажилтнуудад сар бүр 5-10 хувийн нэмэгдлийг 2023.02.01-нээс олгож эхэлсэн.

Засгийн газрын 2022 оны 491 дүгээр тогтоолоор 2023.01.01-нээс төрийн алба хаасан жил тутамд нэмэгдэл олгохоор заасантай холбоотойгоор бүх ажилтны ажилласан жил тулгалт, өмнө ажиллаж байсан төрийн байгууллагын мэдээллийн тулгалтыг Төрийн албаны зөвлөлийн Хүний нөөцийн програмд хийснээр 2023.01.01-нээс нийт 332 ажилтанд 1-25 хувиар төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг олгосон.

Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолоор ТҮЭМ, ТҮ зэрэглэлийн цалингийн доод хэмжээг 2023.07.01-нээс шинэчлэн батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн төвийн даргын 2023 оны А/71 дүгээр тушаалаар нийт ажилчдын цалинг 2023.06.01-нээс үндсэн цалинг 300,000 төгрөгөөр нэмэгдүүлсэн. Энэхүү тушаалаар үндсэн цалингийн доод хэмжээ 1,289,855 төгрөг, дээд хэмжээ 1,664,899 төгрөг болсон байна.

Дотоод журам, ҮЭХ-той байгуулсан Хамтын гэрээнд заасны дагуу 13 дахь сарын цалинг нийт ажилчдад 12 дугаар сарын 10-ны өдөр өгөхөөр төлөвлөсөн.

Эх барих эмэгтэйчүүд, хүүхэд, өсвөр үе, сүрьеэгийн кабинетын хэвийн бус нөхцлийн нөхцлийн болон сүрьеэгийн кабинетын нэмэгдлийг 46 эмч, эмнэлгийн мэргэжилтэнд сар бүр 10 болон 30 хувиар тогтмол олгосон.

2.6. Үндсэн чиг үүргийн биелэлт, үр дүнд дотоод аудит, хяналт эсвэл хяналт, шинжилгээ, үнэлгээ хийсэн эсэх, уг ажлын дүгнэлтийг үйл ажиллагаандаа авч хэрэгжүүлсэн байдал

“Дотоод хяналт”-ын 2 зорилт 14 арга хэмжээний төлөвлөгөө боловсруулсан хэрэгжилтийг ханган ажиллаж, жилийн эцсийн байдлаар 90 хувьтай хэрэгжсэн.

Төлөвлөгөөт “дотоод хяналт”-ын арга хэмжээг батлагдсан төлөвлөгөөний дагуу, төлөвлөгөөт бус “дотоод хяналт”-ын арга хэмжээг байгууллагын удирдлага болон Удирдлагын зөвлөлийн гишүүдээс өгсөн үүрэг чиглэлийн дагуу Эрүүл мэндийн төвийн даргын баталсан удирдамжийн хүрээнд, томилогдсон ажлын хэсэг дундаж 14-28 хоногийн хугацаанд хяналтыг гүйцэтгэж, илгэх хуудсаар тайлагнан, гарсан алдаа дутагдалд засаж сайжруулах хугацаатай “Зөвлөмж” хүргүүлж, хэрэгжилтийг ханган, зөвлөмжийн хүрээнд хийсэн ажлын тайланг хүлээн авсан.

1. Нийт 21 албан хаагч ажил хавсран гүйцэтгэж байгаагаас хяналтаар 7 албан хаагч ажил хавсран гүйцэтгэх хугацаа нь дуусгавар болсон. 14 албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнд хяналт хийж, ажлаа зорилтот түвшинд хүргэж хангалттай сайн гүйцэтгэж байгаа 6 албан хаагчийн гэрээг үргэлжлүүлэх, Төрийн хэмнэлтийн хуулийн үйлчлэлд хамааруулж, 4 албан хаагчийн ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл хөлсийг зогсоож, цаашид ажил сайжруулах хугацаатай Зөвлөмжийг 4 албан хаагчид өгсөн. Зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажлын тайланг 04 дүгээр сарын 01-нд хүлээн авч, үр дүнд Архивын ажилтанд 3, Хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэнд 4, Эдийн засагчид 6 ажлыг хэрэгжүүлж, ажил сайжруулсан. Мөн төлөвлөгөөт бус хяналтаар гэрээгээр ажил гүйцэтгэж байгаа 5 гэрээт ажилтны ажлын гүйцэтгэл, үр дүнд хяналт хийж, 2 ажилтны гэрээний хугацааг сунгах, 2 ажилтны гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж, ажил сайжруулах мэдэгдэх хуудас өгөх, 1 ажилтны гэрээг дуусгавар болгохоор болсон.

2. Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнуудын албан тушаалын тодорхойлолтын дүгнэлтийг гарган, шинэчлэн боловсруулах ажлын хяналтаар 2023 оны 11 дүгээр сарын байдлаар 384 эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтэн, ажиллагсад ажиллаж байгаа ба ажиллагсдын ажлын тэнцвэрт байдлыг хангах зорилгоор нийт ажилтны “Албан тушаалын тодорхойлолт”-ыг Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтын загварт оруулж, хийгдэх ажлыг харьяа алба, нэгжийн удирдлагуудтай хамтран нарийвчлан тусгаж, ажлыг нь хуваарилан, ажил үүргийн хуваарийг тэнцвэржүүлж батлуулан, хэрэгжүүлсэн. Батлагдсан “Албан тушаалын тодорхойлолт”-ыг ажилтан бүрд гардуулж, 1 хувийг нь хувийн хэрэгт нь хадгалсан.

3. Төвийн даргын баталсан тушаал, шийдвэрийн биелэлтэд хяналт, үнэлгээ хийхэд 2018-2023 оны 744 А тушаал, 2022, 2023 оны 591 Б тушаалыг холбогдох хуулийн зүйл заалттай нийцэж байгаа эсэх, агуулга, биелэлтэд хяналт хийсэн. Хяналтын үр дүнгээр цаашид засаж сайжруулах шаардлагатай 10 төрлийн “Зөвлөмж”-ийг холбогдох албанд өгч, хэрэгжилт 100% хангагдсан.

4. Байгууллагын Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааны хяналтаар цаашид засч сайжруулах шаардлагатай Тушаал боловсруулахтай холбоотой -10, Албан хэрэг хөтлөлттэй холбоотой -8, Архивын үйл ажиллагаатай холбоотой -2 төрлийн хугацаатай арга хэмжээний “Зөвлөмж”-ийг тухайн албан тушаалтанд хүргүүлж, хэрэгжилтийг хангуулан ажилласан.



5. Бараа, материалын худалдан авалт, зарцуулалтад хийсэн хяналтаар бичиг хэрэг, бараа материалыг зарлагадахдаа шаардах хуудасгүй олгодог, шаардах хуудсыг дутуу бичүүлдэг, дарга ерөнхий нягтлан бодогчийн зөвшөөрөлгүй олгодог, гарын үсэг дутуу, шаардах хуудсыг хааж хэвшээгүй, Төрийн хэмнэлтийн хуулийн дагуу тэвчиж болох зардлыг төлөвлөдөггүй зэрэг дутагдлууд илэрсэн ба 4 арга хэмжээг 30 хоногийн хугацаанд сайжруулах тухай “Зөвлөмж”-ийг холбогдох албанд хүргүүлж, хэрэгжилтийг бүрэн хангуулсан.

6. Иргэдээс ирсэн өргөдөл, гомдлыг нягтлан шалгаж, хууль зүйн үндэслэлтэйгээр эцэслэн шийдвэрлэж, иргэнд хуулийн хугацаанд хариу өгсөн эсэхэд хяналт тавих зорилгоор Эрүүл мэндийн төвийн хэмжээнд 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 10 дугаар сарын 25-ны өдөр хүртэлх хугацаанд ирсэн нийт өргөдөл, гомдол, санал, хүсэлт, талархал, тэдгээрийн шийдвэрлэлтэд хяналт хийж, нийт 535 гомдол, санал, хүсэлт, талархал бүртгэгдсэнээс гомдол 331, санал 10, хүсэлт 18, талархал 176 ирсэн ба 61.8%-г гомдол, 1.9%-г санал, 3.4%-г хүсэлт, 32.9%-г талархал эзэлсэн байна. Хяналтаар өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн байдал болон хариу арга хэмжээ авахдаа Эрүүл мэндийн төвийн даргын 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн А/89 дүгээр тушаалын 4 дүгээр хавсралтын 5 дахь хэсэгт заасан “Байгууллагын үйлчилгээтэй холбоотой өргөдөл, гомдлын агуулгад судалгаа дүгнэлт хийж, түүний мөрөөр авах арга хэмжээг зохион байгуулж, хэрэгжилтийг хангах үүрэг чиглэл бүхий “**ОРОН ТООНЫ БУС БАГ**”-ийг даргын тушаалаар томилон байгуулж, өргөдөл гомдлыг бууруулах арга хэмжээ авч ажиллахаар болсон.

7. 2022 оны 12 сард Эм зүйн алба, Эмнэлгийн эмийн сангийн үйл ажиллагаанд хийсэн хяналтын үр дүнгээр Эмнэлгийн тусламж үйлчилгээ, чанар аюулгүй байдлын албанд -3, Эм зүйн албанд -7, Эмнэлгийн эмийн санд -6, Бага эмч нарт -5, Кабинетуудад -6, Чанарын багуудад -7 төрлийн ажил сайжруулах арга хэмжээний зөвлөмжийг хүргүүлсэн ба дараах үр дүн гарсан. Үүнд:

- 2023 оны 1-4 сарын эм, эмнэлгийн хэрэгслийн тооцооллыг кабинет бүрээр тооцож гаргасан.
- Нийлүүлэлтэд тасалдал үүсээгүй тохиолдолд эм, эмнэлгийн хэрэгслийн захиалгыг 100 хувь олгодог болсон.
- Эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж бодисын захиалгыг сард 1 удаа буюу тухайн сарын 27-ноос дараа сарын 05-ны өдрийн дотор олгож байгаа ба тасалдал үүссэн эмнүүдийг ирсэн даруйд нь нэмэлтээр олгодог болсон.
- Эмнэлгийн эмийн сангийн нөөцөд байгаа эм, эмнэлгийн хэрэгслийн тоо хэмжээ нь агуулахын бүртгэлийн үлдэгдэлтэй таардаг болсон
- Агуулахын бүртгэл үнэн зөв хөтлөгддөг болсон.
- Гэмтэж муудсан, хагарсан, хэрэглэх хугацаа дууссан, дуусах дөхсөн эм, эмнэлгийн хэрэгсэлийг зохицуулсан.

8. Кабинетуудын ажлын ачаалалд хяналт үнэлгээ өгч, ажлын тэнцвэрт байдлыг хангах чиглэлээр 2023 оны 10 сарын 18-нд хяналт хийж, дараах ажлуудыг шат дараатай сайжруулсанаар ажил хаягдах, их бага ажиллах байдал буурсан үр дүн гарч эхэлсэн. Үүнд:

- Нийт 384 ажилтны “Албан тушаалын тодорхойлолт”-ыг Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтын загварт оруулж, хийгдэх ажлыг нарийвчлан тусгаж, ажил үүргийн хуваарийг тэнцвэржүүлсэн.
- Кабинетуудад дутагдалтай байгаа 64 төрлийн эм, эмнэлгийн хэрэгслийн дутагдлыг арилгахын тулд 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэх
- Шаардлагатай байгаа 16 төрлийн эмнэлгийн тоног төхөөрөмж, 4 ширхэг суурин компьютерыг 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, шинээр авсанаар ачаалал буурах
- Кабинетад дутагдалтай байгаа 5 эмч, мэргэжилтнийг 2024 онд бүрдүүлэх зэрэг арга хэмжээ авахаар болсон.

9. 5 салбарын Чанарын багуудын үйл ажиллагаанд 2023 оны 10 сарын 18-нд шалгуур үзүүлэлтээр хяналт хийж, дундаж оноо 92,4%-тай үнэлэгдсэн. Хяналтын мөрөөр амбулаториудын Чанарын багуудад хугацаатай ажил сайжруулах “Зөвлөмж” өгч ажиллаж байна. Үүнд:

- Хавтасны эмх, цэгцийг сайжруулах, баяжилт хийх.
- Дотоод сургалтын тоо, удирдамж, илтгэх хуудас, ирц, тохиолдлыг тухай бүр нь бүртгэж байх.
- Шинэ ажилтныг сургах.
- Сургалт, өдөрлөг, аян, дотоод хяналт, хурал, өргөдөл, гомдол зэргийг тухай бүр нь бүртгэж, тоон мэдээг багийн гишүүд бүгд мэддэг байх.
- Зөвлөмжийн хэрэгжилтийг 2023 оны 12 сарын 22-нд хяналт хийж, үр дүнг тооцохоор төлөвлөсөн.

10. Эрүүл мэндийн ажилтны ажлын байрны нөхцөл байдлын үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэхэд ХАБЭА хариуцсан мэргэжилтэн хариуцан АШУҮИС-ийн Нийгмийн Эрүүл мэндийн хүрээлэнтэй “Хамтран ажиллах гэрээ” байгуулан байгууллагын “Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ”-г 6,0 сая төгрөгийн өртөгтэйгөөр 26 ажлын байрны, 32 ажилтныг төлөөлүүлэн, 28 ажилтны хөдөлмөрийн нөхцөлийг хэмжилтэд хамруулж дүгнэлтийг гаргуулсан.

11. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан орон тооны бус зөвлөлийг шинэчлэн байгуулж, зөвлөлийн ажиллах журам, Галын аюулгүй байдлын журам, Эрүүл мэндийн байгууллагын ажилтны ажлын байрны аюулгүй ажиллагааны журам, Осол гэмтлийн үеийн менежментийн журам, Зөөврийн шатны журам, Дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, гарсан гомдлыг шийдвэрлэх журмыг шинэчлэн боловсруулж батлуулан ХАБ хариуцсан мэргэжилтэнд хүргүүлж, журмуудын хэрэгжилтийг хангуулж байна.

12. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн үйлчлэлээр хэмнэж болох бүх зардлыг хэмнэх үүрэгтэй бөгөөд гэрээгээр ажил гүйцэтгэж байгаа ажилтнуудын ажлын гүйцэтгэл, үр дүнгийн хяналтаар үр дүнгүй гэрээтээр ажил гүйцэтгэж байгаа 3. Баттөмөрийн гэрээг цуцлах, байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулахад тодорхой үүрэг гүйцэтгэн ажиллах байгаа Б.Ганзориг, О.Ядмаа нарын гэрээг үргэлжлүүлэх, С.Ганболд, Д.Баасандорж нартай байгуулсан гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж, гэрээг шинэчлэн байгуулах тухай саналыг Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, хэрэгжилтийг бүрэн хангасан.

13. Ажилтан, албан хаагчдын ажлын цаг ашиглах, ажлын цагийн нягтралд хяналт хийж, хяналтын хүрээнд “Ажлын цаг ашиглах” журам боловсруулан батлуулсан ба нийт ажиллагсдын 2023 оны 01 сараас 11 сарын ажлын цагийг бүртгэлийн систем, чөлөөний хуудастай тулган хийж, улирал бүрийн ажлын гүйцэтгэлийн үр дүн дүгнэхэд ажилласан цагийн дагуу үнэлгээ өгч, ажил сайжруулан ажилласан.

14. Байгууллагын бүтцийн дагуу 8 албаны үйл ажиллагаанд 3 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг хяналт хийж, 15 асуудлыг дэвшүүлж, шийдвэрлэн ажилласан.

15. Урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэг, оношилгоо зохион байгуулалт, явц, хамрагдалт, халдвар хамгаалалт, хүрсэн үр дүнд ЭМТ-ийн даргын баталсан удирдамжийн дагуу 5 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг Хамтран ажиллах гэрээтэй ажиллаж байгаа 4 эмнэлгийн үйл ажиллагаанд 6 чиглэлийн дагуу хяналт, үнэлгээ хийж, хяналтын тайланг ЭМДЕГ-т хүргүүлж, хяналт хийгдсэн эмнэлгүүдэд хугацаатай Зөвлөмж хүргүүлсэн.

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын 2022 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн Журам шинэчлэн батлах тухай А/215 тоот тушаалаар Харьяа эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын дагуу бодлогын баримт бчгийн хэрэгжилт, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааны тайланд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, зөвлөмж боловсруулж, хэрэгжилтийг хангуулан ажиллаж, хагас бүтэн жилээр Нийслэлийн Эрүүл мэндийн газар болон Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газарт хугацаанд нь хүргүүлэн ажиллаж байна. Хагас жилийн 16 тайлан, хэрэгжилтийн хяналт-шинжилгээ үнэлгээ хийгдэж, зөвлөмжийг холбогдох мэргэжилтэнд хүргүүлж хэрэгжилтийг хангуулан жилийн эцсийн байдлаар 45 бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, тайланд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, үнэлгээг ахиулан ажилласан. Үүнд:

1. Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн төлөвлөгөөний 1, 2, 3, 4-р улирлын биелэлтийг гаргаж хүргүүлсэн.
2. Нийслэлийн засаг даргын 2022 оны а/1592 дугаар захирамж, нийслэлийн засаг даргын тамгын газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын 2023 оны 148 дугаар зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийн биелэлтийг хүргүүлсэн.
3. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн хагас жил болон жилийн эцсийн биелэлтийг Нийслэлийн эрүүл мэндийн газар болон дүүргийн Засаг даргын тамгын газарт хүргүүлсэн.
4. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хагас жил болон жилийн эцсийн биелэлтийг Нийслэлийн эрүүл мэндийн газарт хүргүүлсэн.
5. Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хагас жил болон жилийн эцсийн тайланг Нийслэлийн эрүүл мэндийн газарт хүргүүлсэн.
6. Монгол улсын хөгжлийн 2023 оны биелэлтийн хагас жил болон жилийн эцсийн биелэлтийг Нийслэлийн эрүүл мэндийн газарт хүргүүлсэн.
7. Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хагас жил болон жилийн эцсийн биелэлтийг Нийслэлийн эрүүл мэндийн газар болон дүүргийн Засаг даргын тамгын газарт хүргүүлсэн.
8. Эрүүл идэвхитэй амьдрал, Эх, хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэнд, Хавдрын эсрэг, Харшлаас сэргийлэх, Эрүүл чийрэг эр хүн, Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх нийт 6 арга хэмжээний төлөвлөгөөний хагас жил болон жилийн эцсийн биелэлтийг Нийслэлийн эрүүл мэндийн газарт хүргүүлсэн.
9. Нийслэлийн хөгжлийн 2023 хагас жил болон жилийн эцсийн биелэлтийг жилийн биелэлтийг Нийслэлийн эрүүл мэндийн газар болон дүүргийн Засаг даргын тамгын газарт хүргүүлсэн.
10. Төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн шууд захирагчийн хооронд “Баянзүрх дүүргийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх гэрээний хагас жил болон жилийн эцсийн биелэлтийг Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.
11. Баянзүрх дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хагас жил болон жилийн эцсийн биелэлтийг Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.
12. Байгууллагын үйл ажиллагааны хагас жил болон жилийн эцсийн тайланг Нийслэлийн эрүүл мэндийн газар болон дүүргийн Засаг даргын тамгын газарт хүргүүлсэн.
13. Мэдээллийн ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн биелэлтийг хагас жил болон жилийн эцсийн тайланг Нийслэлийн эрүүл мэндийн газарт хүргүүлсэн.
14. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлтийг хагас жил болон жилийн эцсийн тайланг Нийслэлийн эрүүл мэндийн газарт хүргүүлсэн.
15. Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хагас жил болон жилийн эцсийн тайланг Нийслэлийн эрүүл мэндийн газарт хүргүүлсэн.
16. Хөрөнгө оруулалтын жилийн эцсийн тайланг Нийслэлийн эрүүл мэндийн газарт хүргүүлсэн.
17. Гадаадын зээл тусламжаар хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрийн жилийн эцсийн тайланг Нийслэлийн эрүүл мэндийн газарт хүргүүлсэн.
18. Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргатай байгуулсан хөдөлмөрийн гэрээний хагас жил болон жилийн эцсийн тайланг Нийслэлийн эрүүл мэндийн газарт хүргүүлсэн.

Авлига, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чиглэлээр

2023 онд “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ”-ний 8 зорилт 20 арга хэмжээ төлөвлөснөөс хэрэгжилт 91 хувьтай байна. 2023 оны хувьд авлига, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой гомдол, санал гараагүй байна. Үүнд:

1. Байгууллагын эрх бүхий албан тушаалтныг томилон ажиллуулж, Нийтийн албанд томилогдон ажиллаж байгаа 16 удирдах албан тушаалтны Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд мэдүүлсэн бол нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасны дагуу шинээр удирдах албан тушаалд томилогдсон 4 албан тушаалтны ХАСУМ болон ХАСХОМ-г meduuleg.iaas.mn-д, томилогдсон мэдээллийг Шилэн дансанд хуулийн хугацаанд байршуулсан.

2. Байгууллагын Үнэлгээний хороонд ажиллах 4 албан тушаалтнаар “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл”-ийг бөглүүлэн Шилэн дансанд хуулийн хугацаанд байршуулсан.


3. Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх заалтын хүрээнд байгууллагын <https://bzemn.ub.gov.mn/> вебсайтад сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн тайланг байршуулж байгаа бөгөөд хөрөнгөтэй холбоотой шийдвэрийг сар бүр, 5 сая төгрөгөөс дээш мөнгөн хөрөнгийн орлого зарлагын гүйлгээг сар бүрийн 07-н ийн дотор тухай бүр байршуулсан.

4. Хүний нөөцийн орон тоо, өндөр насны тэтгэвэрт гарсан хүний тоо, 6 сараас дээш хугацааны сургалтад хамрагдсан хүний тоо, ажил олгогчийн болон өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн ажилтны тоо, хүүхэд асрах жирэмсний амралт авсан ажилтны тоог сар бүрийн 05-ны дотор Шилэн дансанд хугацаанд нь мэдээлж байна. 2023 оны 11 дүгээр сарын байдлаар өндөр насны тэтгэвэр тогтоолгосон ажилтан 7, хүүхэд асрах жирэмсний амралт авсан ажилтны тоо 14, 6 сараас дээш хугацааны сургалтад явсан ажилтан 4, ажил олгогчийн болон өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн ажилтны тоо 60 байна.


5. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4 дэх заалтыг хэрэгжүүлэх чиглэлээр тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор, жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор шилэн дансанд байршуулан ил тод тайлагнасан байна.

6. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7 дахь заалтыг хэрэгжүүлэхээр байгууллагын вэб сайтад тусламж үйлчилгээний төрөл, цагийн хуваарь, цаг хэрхэн авах, байршил, холбоо барих, өдөр тутмын мэдээлэл, цаг үеийн холбогдолтой томоохон арга хэмжээний мэдээллүүдийг байршуулан ажиллаж байна.


7. Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлж сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбарыг байршуулан, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдээ мэдээллийг байршуулж байна. Мөн Эрүүл мэндийн төвийн <https://bzemn.ub.gov.mn/> вебсайт, эмч, ажиллагсдын дундын дотоод



(БЗД-ЭМТ ажилтнуудын дотоод групп) Facebook хуудсанд “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн буланг бий болгож, мэдээ, (“**Авлигыг мэдээлэх утас**” 40 секундын шторк, “**Авлига, ашиг сонирхлын зөрчил гэж юу вэ?**” 2 мин 30сек видео, “**Та яг одоо 110-руу залгаарай**” 30 секундын бичлэг) мэдээллийг хүргэж байна.



8. Авлигатай тэмцэх газраас зарласан “**Мэдье, нэгдье**” аянд нэгдэж, аяныг 2023 оны 10 дугаар сарын 16-ны өдрөөс 10 дугаар сарын 30-ны өдөр хүртэлх хугацаанд Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсээс “Ашиг сонирхлын зөрчил гэж юу вэ?”, Авлигын гэмт хэрэг, Эрүүгийн хуулийн зохицуулалт” сэдвээр нийт эмч, ажиллагсад цахим хэлбэрээр сургалт зохион байгуулж, сургалтад 144 ажиллагсад хамрагдсан. Мөн дотооддоо “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилсан сэргийлэх” сэдэвт сургалт зохион байгуулж, 42 ажиллагсдыг хамруулан АТГ болон өөрсдийн бэлтгэсэн гарын авлага материалыг тараасан.



9. Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ, хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгаж байгаа ба 2023 онд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 154 гэрээ байгуулсан. Гэрээний төсөлд Дотоод хяналтын ажилтан авлигын эрсдэлийн чиглэлээр хяналт тавьсны үндсэн гэрээг байгуулж, нэгдсэн мэдээллийн сан бий болгосон.

2.7. Архив, албан хэрэг хөтлөлт, хариутай албан бичгийн шийдвэрлэлтийн байдал

Албан хэрэг хөтлөлт

№	Баримт бичгийн нэр	2023 оны баримт бичгийн эргэлтийн тоо
	Ирсэн албан бичиг	677

2.	Ирсэн тушаал, тогтоол, захирамж	86
3.	Ирсэн өргөдөл гомдол, хүсэлт /ажилчдаас/	129
4.	Явуулсан бичиг	764
5.	Эрүүл мэндийн төвийн даргаас үндсэн үйл ажиллагаатай холбоотой гаргасан “А” тушаал	106
6.	Эрүүл мэндийн төвийн даргаас хүний нөөцтэй холбоотой гаргасан “Б” тушаал	392

Архивын үйл ажиллагаа

Байгууллагын 2023 онд хөтлөгдөх ХХНЖ-ийг боловсруулан батлуулан архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд баримтлан ажиллаж байгаа бөгөөд архивт баримт хүлээн авах хуваарийг гарган хуваарийн дагуу алба, нэгж, мэргэжилтнүүдээс баримтыг хүлээн авч байгууллагын архивыг нөхөн бүрдүүлсэн.

Нөхөн бүрдүүлэлтийн дүнд байгууллагын үйл ажиллагааны явцад үүссэн 2022 оны баримтаар байгууллагын архивт нөхөн бүрдүүлэлт хийсэн бөгөөд 2022 онд хөтлөгдөх хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу алба, нэгжээс нийт 87 баримт хүлээн авснаас байнга хадгалах 14, түр хадгалах 65, 70 жил хадгалах 8 баримт байна.

Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.6, Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/452 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Байгууллагын үйл ажиллагаанд үүссэн 2022 оны удирдлагын баримт бичиг болох 4 хадгаламжийн нэгжийн 173 баримт бүхий 855 хуудас А тушаал, 3 хадгаламжийн нэгжийн 485 баримт бүхий 626 хуудас Б тушаалыг скайнердаж цахим хувь үүсгэн Archive Edoc системд оруулж утга шивэлт хийгдэж Баянзүрх дүүргийн Архивын тасгаас нягтлан шалгаж баталгаажуулсан.

Баянзүрх дүүргийн архивын тасагт цаасан суурьт баримтаар 2023 онд нөхөн бүрдүүлэлт хийх байгууллагуудын жагсаалтад манай байгууллага орсон бөгөөд нөхөн бүрдүүлэлт хийгдэх ажлын хүрээнд байгууллагын архивын данс, тоо бүртгэлийн баримтуудыг шинэчлэх, бүртгэл дээрх баримтуудыг тулгах, нөхөн бүрдүүлэлтэд хамаарах оны баримтуудад нягтлан шалгалт хийх, баримтын бүрдлийг хангах, засварлах зэрэг ажлууд хийгдээд явж байна.

Байгууллагын архивд байнга хадгалах 2003-2022 оны 197, түр хадгалах 1997-2022 оны 1295, 70 жил хадгалах 1991-2022 оны 106 хадгаламжийн нэгж, зураг төслийн 22 хадгаламжийн нэгж хадгалагдаж байна.

“Байгууллагын үйл ажиллагаанд үүссэн удирдлагын нийтлэг баримт бичгийн хадгалах хугацааны үлгэрчилсэн жагсаалт”-ын дагуу ҮЖ-дугаар зүйлийг үндэслэн хадгалах хугацаа дууссан түүх, эрдэм шинжилгээний болон практик ач холбогдолгүй гэж үзсэн 1981-2015 оны 73 хэргийн 1,992 хадгаламжийн нэгжийн устгах хэргийн акт бүртгэлийг үйлдэж бэлэн болгосон.

Зохион байгуулалтын нэгж ажилтнуудад бүртгэлээр 19 хадгаламжийн нэгжийг түр олгож 8 хадгаламжийн нэгжийг архивт буцаан авсан.

Эрүүл мэндийн төвд ажиллаж байгаа болон ажиллаж байгаад гарсан 38 хүнд ажилд орсон, чөлөөлөгдсөн, тэтгэмжтэй чөлөө, ээлжийн амралтын тушаалын хуулбар, цалингийн баримт, нийгмийн даатгалын төлөлтийн лавлагаа, цалингийн цэсний түүвэр, зэрэг 82 хуудас лавлагаа, 8 баримтыг цаасаар болон файл хэлбэрээр олгосон.

Байгууллагын албан хэрэг хөтлөлт, архивын үйл ажиллагаанд Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам (2020-3Г тогтоол Дугаар 246), Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам (2021-А/222), Албан хэрэг хөтлөлтийн edoc систем ашиглах журам (2023-А/111)-ыг тус тус баримтлан ажиллаж байгаа бөгөөд 2021 оны шинэчлэгдсэн 5140-1:2021 баримт бичгийн стандартыг мөрдөж ажиллаж байна.

2.8. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал

Нийслэлийн байгууллагуудын дотоод удирдлагын UB ERP систем дэх өргөдөл гомдлын дэд системээр иргэд байгууллагаас ирүүлсэн өргөдөл гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх, мэдээ тайланг гаргаж ажиллах, журмыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 3Г-ын 11:11, 1800-1200 тусгай дугаар, Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв, мөн бичгээр иргэд байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг хүлээн авч байна.

Байгууллагад 2023.01.02-11.25-ныг хамрах хугацаанд нийт 583 өргөдөл ирсэнээс шийдвэрлэгдсэн 582 (99,82%), шийдвэрлэх шатанд 1, үүнээс талархал 202 (34,64%), гомдол 347 (59,51%), санал хүсэлт 33 (5.66%)-тай байна.

Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 3-5 хоног байгаа ба нийт өргөдлийн 47,76%-ийг, 10-15 хоногт шийдвэрлэсэн өргөдөл 16,49%, 30 хоногт шийдвэрлэсэн өргөдөл 1,03%-ийг тус тус эзэлж байна.

Өргөдөл гомдлын хандалтаар харахад Өрхийн эрүүл мэндийн төвийн тусламж, үйлчилгээ, үйл ажиллагаатай холбоотой 231 (39,79%), эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаа, 2 дахь шатлалын эрүүл мэндийн байгууллагын тусламж үйлчилгээтэй холбоотой 285 (48,8%) албан хаагчийн ёс зүй харилцаа хандлагатай холбоотой 24 (4,11%), бусад 71 (12,17%)-ийг тус тус эзэлж байна.

Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой: Үүнд: Эмнэлгийн тусламж үйлчилгээний хүлээгдэл, /дугаарлаж удаан хүлээдэг, нэмэлт цаг оруулахад хүлээгдэл ихтэй, шүдний кабинетийн цаг дүүрсэн байдаг, тусгай дугаарын 1800-0119-өөс цаг олддоггүй, амбулаторийн ажлын зохион байгуулалттай холбоотой, иргэдийг эмч болон амбулатори, салбар хооронд нааш цааш явуулдаг, жирэмсний цаг олголт, шинжилгээ, олон явуулдаг гэх зэрэг шалтгаант/, эрт илрүүлэгийн үзлэг хийж байгаа гэрээ хийсэн хувийн хэвшлийн эмнэлгүүдийн зарим нь үйлчилгээний чанар хүртээмж муу, зарим нь үзлэг шинжилгээг зогсоосон, гэрээ дууссан, тоног төхөөрөмж хангалтгүй, дурангийн шинжилгээ зарим эмнэлэг авахгүй байгаа, 13а маягт авах нь маш их чирэгдэл үүсгэж байга, хороо хуваагдсантай холбоотой зарим ӨЭМТ-ийн үйл ажиллагаа жигдрээгүй, иргэд хаана үзүүэхээ мэдэхгүй, зарим хороод хуваагдсанаас хол газар очиж үзүүлж байна, эмнэлгийн зарим дотоод зохион байгуулалттай холбоотой, ачаалал тэнцүүлэх зорилгоор зарим хороог Дарь эх нэгдсэн эмнэлэгт үзүүлдэг болсонтой холбоотой хол байна гэх мэт шалтгаан байна.

Эрүүл мэндийн төв, ӨЭМТ, амбулаторид ирж байгаа өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 3-4 хоног байна. Тухайн иргэнтэй холбогдож чадаагүй, иргэн утсаа авахгүй байх, унтраасан, орох ярианы эрх хаагдсан, хаяг буруу байх, шалтгаан тодруулах зэрэг асуудлаас шалтгаалан ажлын 7 хоног дотор, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн зөрчил гаргасан асуудлыг шийдвэрлэх, ёс зүйн хэсгийн хорооны хурлаар орох зэргээс шалтгаалж тухайн гомдол 7-10 хоногт шийдэгдэж байна. Хугацаа хэтэрсэн болон хугацаа хэтэрч шийдвэрлэгдсэн өргөдөл, гомдол байхгүй.

Шийдвэрлэх хугацаа ажлын 10 болон түүнээс дээш хугацаатай өргөдөл гомдлууд дээр 10 хоног тутамд явцын тэмдэглэл хөтөлж байна. Мөн бусад

байгууллагаас албан тоот, тодорхойлолт шаардах, нэмэлт судалгаа, хийхээс бусад шалтгаантай өргөдлүүдийг ажлын 3 өдөрт багтаан хааж шийдвэрлэх чиглэлийг хэрэгжүүлж ажиллаж байна. Дээрх хугацаанд нийт ирсэн өргөдөл гомдлын 231 буюу 39,79% хувь нь Өрхийн эрүүл мэндийн төвүүд дээр ирж байгаа гомдолууд эзэлж байна. Өрхийн эмнэлгийн угтах үйлчилгээ, хөтөч ажилтны мэдээллээр хангах, зөв чиглүүлэх байдал дутагдалтай, эмнэлгийн тусламж үйлчилгээ чирэгдэл ихтэй, цаг олгох байдал дутагдалтай, хөнгөлөлттэй эм бичих чирэгдэл ихтэй, сүлжээний асуудалтай, чирэгдүүлдэг, дүүргийн зарим хороод хуваагдсантай холбоотой өрхийн эмнэлгийн байр хангалтгүй, шинэ өрхийн үйл ажиллагаа жигдрээгүй, харьяаллаас шалтгаалж үзэхгүй байх гэх зэрэг шалтгаант/ асуудлууд эзэлж байна.

Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд залруулж болох санал гомдлыг тухай бүр шийдвэрлэх, иргэдэд мэдээ мэдээллийг хүртээмжтэй ойлгомжтой байдлаар хүргэх, харилцаа хандлагын асуудлыг анхаарч ажиллахыг чанар, эмнэлгийн тусламжийн албанаас тухай бүр зөвлөмж, зөвлөгөө өгч ажиллаж байна.

Салбар амбулаториудын лавлагааны утсыг хэвийн, байнгын ажиллагаатай байлгах үүднээс төлбөрөөс шалтгаалж таслагдахгүй байхаар зохицуулалтыг санхүүгийн албанаас хийсэн.

ӨЭМТ-үүдтэй өргөдөл гомдлыг бууруулах чиглэлээр уулзалт, хэлэлцүүлэг хийж “Харилцаа хандлага” сайжруулах 1 сарын аян 2-р улиралд зарлан хэрэгжүүлсэн.

Аяны хүрээнд талархалын тоог нэмэгдүүлэх, гомдлын тоог тодорхой хувиар бууруулахаар ажиллаж байна. Цаашид талархалыг нэмэгдүүлж гомдлыг бууруулах зорилгоор өргөдөл гомдлын тодорхой хувийг эзэлж байгаа эрүүл мэндийн байгууллагын ажилтны ёс зүй, харилцаа хандлагатай холбоотой гомдлыг бууруулах чиглэлийг барьж Эрүүл мэндийн яамны дэргэдэх ёс зүйн хороотой хамтарч 4,5 дүгээр сард харьяа салбар амбулатори, мэргэжилтнүүд, Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн холбогдох эмч мэргэжилтнүүдэд Ёс зүйн сургалт хийж 205 эмч, эмнэлгийн ажилтанг хамруулсан.

“Эрүүл мэндийн байгууллагын ажилчдад тавигдах ёс суртахуун, соёлын шаардлага” сэдэвт сургагч багш бэлтгэхдэх сургалтыг явуул, ЭМТ-ийн салбар амбулаториуд болон ӨЭМТ-дэд нэг нэг сургагч багш бэлдэж, бэлтгэгдсэн сургагч багш нараар салбарууд дээр нь сургалт оруулсан.

ЭМДҮЗ-ийн 08 дугаар тогтоол гарсантай холбоотой амбулаториудад болон ӨЭМТ-дэд 13а маягт илгээхтэй холбоотой гомдлууд нэмэгдсэн учир ЭМДЕГ-ын мэргэжилтнүүд болон харьяа НЭМГ, ЭМЯ-ны мэргэжилтнүүдтэй уулзаж гомдлыг бууруулах чиглэлээрх тушаалын төсөлд саналаа өгсөн.

Шинээр үүсгэн байгуулагдсан ӨЭМТ-дийн үйл ажиллагаатай танилцаж, чанарын багийн гишүүдтэй уулзалт хийн НЭМГ болон БЗДЭМТ-ийн даргын “Өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай” 2022 оны А/89 дугаар тушаалыг танилцуулж, гомдлыг хурдан шийдвэрлэх, аль болох гомдол гаргахгүй байх дээр анхаарч, хамтарч ажиллах чиглэл өгсөн.

ӨЭМТ-ийн дарга нартай уулзах уулзалтын үеэр гомдлын шийдвэрлэх хоногийг багасгах, бодитой шийдвэрлэх, ёс зүй, харьцаа хандлагатай холбоотой гомдол гаргахгүй байх талаар сануулж зөвлөлдсөн.

2023.11.03-ны өдөр нийт Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нартай хийсэн уулзалт дээр ирж байгаа өргөдөл гомдлыг бууруулахад анхаарах, шийдвэрлэх хугацаа богино байх, шийдвэрлэлтийг бодитой, иргэнд хүргэх хариу тодорхой, чанартай байх талаар зөвлөмж өгч, мэдээлэл танилцуулан 1 сарын аян зарлаж ажиллаж байна.

Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол /төрлөөр/, / (2023.01.02-2023.11.25)



№	Төрөл	1-сар	2-сар	3-сар	4-сар	5-сар	6-сар	7-сар	8-сар	9-сар	10-сар	11-сар	12-сар	Нийт
1	Талархал	28	13	30	28	21	19	4	21	15	10	13		202
2	Санал	1	0	3	-	2	1	-	3	1	-	2		13
3	Хүсэлт	3	2	2	4	4	-	1	1	1	1	1		20
4	Гомдол	38	18	35	48	30	39	22	49	29	22	18		348
	Нийт тоо	70	33	70	80	57	59	27	74	46	33	34		583

Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол /хэлбэрээр/ (2023.01.02-2023.11.25)

№	Он сар	Өргөдөл гомдлын тоо	Үүнээс					
			Бичгээр	ЗГ 11:11 1800- 1200	Утсаар хандсан	ННҮТ	ННЗБ	Бусад
1	1-сар	70		70	-	-	-	-
2	2-сар	33		33	-	-	-	-
3	3-сар	70		68	-	-	2	-
4	4-сар	80		76	-	-	4	-
5	5-сар	57		56	-	-	1	-
6	6-сар	59		59	-	-	-	-
7	7-сар	27		27	-			-
8	8-сар	74		73	-	-	1	-
9	9-сар	46		46	-			-
10	10-сар	33		33	-			-
11	11-сар	34		34	-	-	-	-
12	12-сар				-			-
	Нийт	583		575	-		8	-

2.9. Байгууллагын үйл ажиллагаанд дотоод удирдлагын программ нэвтрүүлсэн байдал, үр дүн

Байгууллагын удирдлагын түвшинд болон захиргааны ажилчдын түвшинд вайбэр болон телеграмм программ ашиглаж байна. Харин нийт ажилчдын түвшинд имэйл болон фэйсбүүк дотоод групп ашиглаж мэдээлэл хүргэж ажиллаж байна.



2.10. Байгууллагын үйл ажиллагааны зардал хямдруулах, төсөв хэмнэх чиглэлээр зохион байгуулж, үр дүнд хүрсэн бодитой ажил

Монгол улсын Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоол эрүүл мэндийн байгууллагад хамааралгүй.



Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 зүйлд заасны дагуу батлагдсан төсвөөс жилийн эцсийн байдлаар 1,236,133.100 төгрөгний төсвийн хэмнэлттэй ажилласан байна. Томилолт, баяр ёслол, тэмдэглэлт ой, олон нийтийг хамарсан арга хэмжээ зэргээс – 38,000,000 төгрөгийг хэмнэж ажилласан байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ


3.1. Мэдээллийн ил тод байдлыг хангах чиглэлээр хийж хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн

Монгол улсын “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай” хуулийг үндэслэн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг өдөр бүр шинэчилж Баянзүрх дүүргийн эрүүл мэндийн төв цахим хуудас, <https://bzemn.ub.gov.mn/> сайтаар дамжуулан олон нийтэд хүргэн ажиллаж байна.



Байгууллагын вэб сайтын цэсийг шинээр (8 цэс, 27 дэд цэс) мэдээллийг цэсний дагуу оруулж эхэлсэн. Мөн вэб сайт нь өдрийн хандалтыг тоог харуулдаг хөгжүүлэлтийг нэмж хийсэн. 2023 оны 11 сарын байдлаар 19,448 дагагчтай байгаа ба үүнээс 17,891 нь Улаанбаатар хотын иргэд, 1557 нь хилийн чанд, орон нутгийн иргэд мэдээлэл авч байна. Нийт хандалтын тоо 920.078, нийт мэдээний тоо 700+,

нийт 43 хорооны Өрхийн эрүүл мэндийн төвүүд тус тусын цахим хуудас болон вебсайт ажиллуулж мэдээлэл өгч байна.



3.2. Хүний нөөцийн ил тод байдлыг хангах чиглэлээр хийж хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн

ЭМТ-ийн даргын 2022 оны А/75 дугаар тушаалаар Эрүүл мэндийн төвд шинээр ажилд орох эмч, эмнэлгийн мэргэжилтэн, захиргааны удирдах ажилтан, мэргэжилтнүүд болон үйлчилгээний ажиллагсдыг сонгон шалгаруулах үйл ажиллагааны журмыг шинэчлэн баталсан. Дээрх журмаар шинээр ажилд орсон эмч, эмнэлгийн мэргэжилтнийг сонгон шалгаруулж эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, халдварын сэргийлэлт хяналтын шалгалт авч аман ярилцлага болон бичгийн шалгалтанд хангалттай 80%-аас дээш оноо авсан тохиолдолд ажилд томилж хэвшсэн. Мөн ажлын байран дээр тухайн сул ажлын байранд зарын дагуу ирсэн ажилтныг тухайн ажиллах нэгж дээр 3 хоног туршин ажиллуулж туршилтын хугацааны дараа ажилд авах эсэх шийдвэрийг нэгжийн даргаар гаргуулсны дараа ажилтныг ажилд авахаар шийдвэр гаргаж сонгон шалгаруулалтын үйл ажиллагааг явуулсан.

Туршилтын хугацаагаар ажиллуулж үзэхэд туршилтын хугацаанд 5 ажилтан цаашид ажиллах боломжгүй гэсэн тайлбар, дүгнэлттэй, бусад 33 ажилтан ажиллах боломжтой гэсэн дүгнэлттэйгээр туршигдаж ажлын байранд түр гэрээгээр томилогдон ажиллаж байна. /Шинэ ажилтантай эхний ээлжинд туршилтын 3 сарын гэрээ, цалингүй чөлөөтэй болон хүүхэд асрах чөлөөтэй ажилтны оронд чөлөөний хугацаанд гэрээ байгуулсан/

Байгууллагын вэб сайтад нээлттэй ажлын байр, сонгон шалгаруулалт, ёс зүйн дүрэм, ажилтны сургалт, захиргааны албан хаагчдын мэдээлэл, байгууллагын удирдлагын зөвлөлийн мэдээлэл, шагнал олгох журам, хууль эрх зүйн цэсүүдийг нэмж, мэдээллийг Мэдээллийн технологийн ажилтанд нийт 18 материалыг бэлтгэн өгч вэб сайтад оруулсан.

Хүний нөөцийн мэдээллийн самбарт холбогдох мэдээлэл сэтгүүл, гарын авлагыг тавьж, сул ажлын байрны зарыг Эрүүл мэндийн салбарын нээлттэй болон хаалттай цахим хуудсуудаар мэдээлж, үндсэн мэргэжлийн сургалт эрхлэгч байгууллага болох Амгалан амаржих газар, ЭМЖЖ эмнэлэг, Улсын гуравдугаар төв эмнэлгийн Сургалтын албатай хамтран шинэ төгсөгчдөөс Эх барих эмэгтэйчүүдийн эмч, Чих хамар хоолойн эмч, Дотоод шүүрлийн булчирхайн эмчийн хүний нөөцийг

бүрдүүлж ажилласан. 2023 онд 5 салбар нэгжид нийт 105 хүний нөөцийн сул орон тоог зарлаж ажилд авсан.

Хүний нөөцийн хөгжлийн 2022-2025 оны хөтөлбөрийг 11 зорилтын хүрээнд батлуулж хэрэгжилтийг жилийн эцэст гаргаж байна.

Шилэн дансанд 2023 оны 1,2,3,4,5,6,7,8,9,10-р сарын орон тооны мэдээлэлд орсон өөрчлөлтийг тогтмол хуулийн хугацаанд нь оруулсан. ЭМЯ-ны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний Ёс зүйн Хяналтын хорооноос 2023 онд зохион байгуулах сургалтын захиалгыг байгууллага дээрээ авахаар албан бичгээр хүсэлт өгсний дагуу 2023 оны 4-р сард Дүүргийн Соёлын ордонд “Эмнэлгийн мэргэжилтний анхан болон дунд шатны сургалт” зохион байгуулсан ба сургалтанд нийт 91 эмч, эмнэлгийн мэргэжилтэн оролцож, 2 багц цаг авсан.

Эрүүл мэндийн төвийн салбар нэгж амбулаторид болон 3 амбулаторийн харъяа ӨЭМТ-үүдийн дунд “Ёс зүйг эрхэмлэгч хамт олон” уралдааныг 2023.04.21-ний өдөр дүүргийн Соёлын ордонд зохион байгуулсан. Нийт 8 баг оролцсоноос Салбар 2-р амбулаторийн харъяа ӨЭМТийн баг 1-р байр эзэлж, багийн 10 гишүүнийг цалингийн 40 хувиар урамшуулж, удаах байруудыг эзэлсэн Эрүүл мэндийн төвийн салбар, нэгжүүдийн 30 ажилтанд үндсэн цалингийн 10-30 хувийн урамшуулал олгосон.

Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, 320 ажилчдад салбар, нэгж тус бүр дээр байрлан ганцаарчилсан сэтгэл зүйн зөвлөгөө өгч ажлын байран дээр болон амьдралдаа эмч мэргэжилтнүүд бид бүхэн сэтгэл зүйн эрүүл мэнддээ анхаарах, урьдчилан сэргийлэх хандлагыг төлөвшүүлэх, сэтгэл зүйн боловсролдоо анхаардаг, цаг гаргадаг, стресс тулгамдсан асуудлаа зөвөөр тайлдаг, сэтгэл зүйн хямралд өртөх эрсдэлийг бууруулах, амьдарлын зөв дадал хэвшлээрээ өөрийн сэтгэл зүйн эрүүл мэнддээ анхаардаг байх нь чухал сэдвүүдээр ярилцан, сэтгэл зүйн зөвлөгөө өгсөн.

БЗДЭМТ-ийн дэргэдэх Ёс зүйн хэсгийн хорооноос “Сувилахуйн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ” сэдэвт сургалтыг нийт 87 сувилахуйн мэргэжилтэнгүүдэд 2023 оны 10 сарын 03-06-ны хооронд зохион байгуулсан. Уг сургалтаар сувилахуйн мэргэжилтний ёс зүйн дүрмийг таниулах, мэдлэгийг бататгах, Ёс зүйн дүрмийн хэм хэмжээг баримталж ажиллах мэдлэг дадлага олгох сэдвээр зохион байгуулсан. Сургалтын өмнө болон дараах 5 асуулттай сорил авч харьцуулан дүгнэхэд мэдлэгийн түвшин дунджаар 33% байсан бол сургалтын дараах сорилоор 72% болж ахисан үр дүнтэй байна.

Эрх бүхий албан тушаалтнаар Дотоод хяналтын ажилтанг томилж шинээр томилогдсон болон удирдлагын зөвлөлийн нийт 16 гишүүдийн хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг АТГ-ын холбогдох мэдээллийн санд 2023 оны 2-р сард хуулийн хугацаанд бүртгүүлж мэдээллийг оруулсан.

Эрүүл мэндийн төвийн bzemn.ub.gov.mn вэб сайтаар хүний нөөцийн холбогдох эрх зүйн баримт бичгүүд, сул орон тооны зарыг тогтмол шинэчлэн мэдээлсэн.

Хүний нөөцийн мэдээллийн самбарт холбогдох мэдээлэл сэтгүүл, гарын авлагыг тавьж, сул ажлын байрны зарыг Эрүүл мэндийн салбарын нээлттэй болон хаалттай цахим хуудсуудаар мэдээлж, үндсэн мэргэжлийн сургалт эрхлэгч байгууллага болох Амгалан амаржих газар, Улсын Гуравдугаар төв эмнэлэг, ЭМЖЖ эмнэлгийн Сургалтын албатай хамтран шинэ төгсөгчдөөс Эх барих эмэгтэйчүүдийн эмч, Чих хамар хоолойн эмч, Дотоод шүүрлийн булчирхайн эмчийн хүний нөөцийг бүрдүүлж ажилласан. 2023 онд нийт 105 хүний нөөцийн сул орон тоог зарлаж ажилд авсан.

2023 оны 1-р улиралд Хүний нөөцийн албанаас “Баянзүрх-Эрүүл мэнд” сэтгүүлийг эрхлэн гаргаж 2022 оны оны шилдгүүдийн болон өндөр насны тэтгэвэрт гарсан ажилчдын ярилцлага, ажилчдын нийгмийн асуудлын талаар хийсэн ажил, орон сууцны урьдчилгаа авсан ажилчдын мэдээллийг ил тодоор оруулсан. 2023 оны 2-р улиралд “Онол практикийн бага хурал” сэдвээр, 3,4-р улирлын дугаарыг Оны ажлын тайланг цувралаар гаргасан.

Засгийн газрын 2019 оны 05, 395 дугаар тогтоолын дагуу эмч, ажиллагсдын 2023 оны 1,2,3-р улирлын ажлын гүйцэтгэлийг үнэлж үнэлгээгээр 352 ажилтанд 693,947,345 төгрөгийн урамшуулал олгосон.

Гэмтэл, мэс заслын эмч сувилагч, чанарын багийн гишүүд, Ахлах сувилагч, Халдварын сэргийлэлт хяналтын багийн гишүүд, эд хөрөнгө хариуцдаг ажилтнуудад сар бүр 5-10 хувийн нэмэгдлийг 2023.02.01-нээс олгож эхэлсэн.

Засгийн газрын 2022 оны 491 дүгээр тогтоолоор 2023.01.01-нээс төрийн алба хаасан жил тутамд нэмэгдэл олгохоор заасантай холбоотойгоор бүх ажилтны ажилласан жил тулгалт, өмнө ажиллаж байсан төрийн байгууллагын мэдээллийн тулгалтыг Төрийн албаны зөвлөлийн Хүний нөөцийн програмд хийснээр 2023.01.01-нээс нийт 332 ажилтанд 1-25 хувиар төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг олгосон.

Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолоор ТҮЭМ, ТҮ зэрэглэлийн цалингийн доод хэмжээг 2023.07.01-нээс шинэчлэн батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн төвийн даргын 2023 оны А/71 дүгээр тушаалаар нийт ажилчдын цалинг 2023.06.01-нээс үндсэн цалинг 300,000 төгрөгөөр нэмэгдүүлсэн. Энэхүү тушаалаар үндсэн цалингийн доод хэмжээ 1,289,855 төгрөг, дээд хэмжээ 1,664,899 төгрөг болсон байна.



3.3. Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангасан байдал буюу шилэн дансны хөтлөлтийн байдал, үр дүн

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4 дэх заалт, Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх заалтыг хэрэгжүүлэхээр байгууллагын санхүүгийн орлого, зарцуулалтын тайланг сар бүрийн 2-нд гаргаж, байгууллагын ЭМТ-ийн дарга, НЭМГ-т хүргүүлдэг. 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг НЭМГ-т хуваарийн дагуу нэгтгүүлж, төсвийн гүйцэтгэлийн, зарцуулалтын мэдээ, хандив, тусламжийн зарцуулалтын мэдээг Шилэн дансанд хуулийн хугацаандаа байршуулсан. Байгууллагын веб сайтад сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн тайланг байршуулсан. 2023 оны санхүүгийн тайланд хийгдсэн аудитын тайлан дүгнэлтийн бүрэн эхээр нь шилэн дансанд ил тод байршуулсан. Хөрөнгөтэй холбоотой шийдвэрийг сар бүр, 5 сая төгрөгөөс дээш мөнгөн хөрөнгийн орлого зарлагын гүйлгээг сар бүрийн 7-ноос өмнө тухай бүр байршуулсан. Санхүүгийн ил тод байдлыг нийтэд нээлттэй байлгах үүднээс ШИЛЭН ДАНС-нд нийт 163 мэдээллээс 163 мэдээллийг хуулийн хугацаанд багтаан үнэн зөв байрлуулан тайлагнасан байна.


ШИЛЭН ДАНС

+ (976)-7100 1111
shilendans@mof.gov.mn

Нэвтрэх

НҮҮР
БАЙГУУЛАГА
БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЭГЧ
ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САН
НЭЭЛТТЭЙ ӨГӨГДӨЛ
СУРАЛЦАХҮЙ

Нэр томьёоны тайлбар



Баянзүрх дүүргийн эрүүл мэндийн төв

И-мэйл: bzdemt@gmail.com
Ажлын утас: 70150069

Шуудангийн хаяг:
Сошиал хаяг:
Баянзүрх Дүүргийн эрүүл мэндийн төв

Далгарангүй харах

ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ

Төсвийн байгууллага

Төсөв, гүйцэтгэл

Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт

Бусад

Тайлант он: 2023

Тэмдэглэгээний тайлбар

№	Тайлангийн нэр	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах хугацаа	Замнал эсэх	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Сар бүр																
1	Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт	Төлөвлөгөө	7 хоногийн дотор	*	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
2	Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт - эдийн засгийн ангидал	Гүйцэтгэл	дараа сарын 8-ны дотор	*	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
3	Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл - Хөтөлбөр, зориулалт	Гүйцэтгэл	дараа сарын 8-ны дотор	*	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓

2023 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгасны дагуу 11 тендерийг зарлахдаа Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем)-ээр шуурхай зохион байгуулж, үр дүнг тухай бүр цахим системд байршуулан, Сангийн сайдын 2019 оны 132 дугаар тушаалаар батлагдсан “Тендер шалгаруулалтын материалыг тухайн тендерт оролцогчдод ил болгох журам”-ыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон 2023 оны 5-р сарын байдлаар нийт 9 байгууллагатай гэрээ байгуулан ажиллаж байна.

November 30, 2023

ХЯНАСАН:

ДАРГА



И.БАТЗАЯА

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

A handwritten signature in blue ink, appearing to be 'М.ОЮУН'.

М.ОЮУН